

ЭДИЙН ЗАСАГЧ
Б.ДӨЛГӨӨН
ҮНДЭСЛЭЛ
НОТОЛГООГҮЙ
БОДЛОГО ИХ ТАРАХ
ТУСАМ ДООРОО ХИЙ
ЭРГЭНЭ

Нэн тэргүүнд тухайн асуудлыг
үүсгэж буй учир шалтгааныг
зөв оношлох ёстой



МАНДАЛ
ДААТГАЛ

Аяллын үеэрх
ЭРСДЭЛЭЭ ШИЛЖҮҮЛ



Гадаад аяллын даатгал

6\$-с эхэлнэ.

Хамгаалалт

50,000\$

Даатгалыг онлайнаар 2 минутад!

mandal.mn

Редакторын зурвас 05

Майнголиа биш
Түризмонголиа болох уу

Дэлхий 2024 онд 06

Эдийн засаг өнгөлөг байх
үү?

Дэлхий 2024 онд 09

Хиймэл оюуны судалгаа
хэрхэх вэ?

Газар 10

Сэтгэлгээ өөрчлөгдвөл
газар амь орно

Онцлох зочин 12

Эдийн засагч Б.Дөлгөөн:
Үндэслэл нотолгоогүй
бодлого их гарах тусам
доороо хий эргэдэг

Бүтээл 21

“Өсөлтийн оношилгоо:
Реформ хийх аргачлал”
номын онцлох эшлэлүүд

Экспорт 22

Манай улсын мах, махан
бүтээгдэхүүний экспортын
хамгийн өндөр үзүүлэлт
276 сая ам.доллар

Дэлхий 2024 онд 26

Дэлхий Монголыг онилно

Аялал жуулчлал 30

Өмнийн говийн
дундаршгүй үүц

Аялал жуулчлал 32

Х.Түмэндэлгэр: “Унаган
терхөөрөө буй арал”
жуулчдыг соронзон мэт
татаж эхэллээ

Эрсдэлийг удирдагч 40

Даатгуулах соёл

Монгол даатгал 42

Л.Төр-Од: Даатгал нь
санхүүгийн тогтвортой
байдлын чухал
бүрэлдэхүүн хэсэг юм

Байгаль хамгаалал 44

Ногоон ирээдүйг
бүтээгчид

Ногоон бизнес 48

Асуудлын бус шийдлийн
нэг хэсэг нь бизнес

Хөрөнгө оруулалт 50

Монгол Улсад
үргэлжлүүлэн хөрөнгө
оруулахыг урьж байна

Сэргээгдэх эрчим хүч 54

Дараагийн Оюу толгойг
хаанаас олж болох вэ





Монгол Даатгал Хувьцаат Компани 1934 оноос
хойш даатгалын тааламжтай үйлчилгээг ард
иргэддээ үзүүлэн ажиллаж байна.
**Бидэнтэй хамт 90 жилийн түүхийг
бүтээлцсэн хэрэглэгч ТАНД баярлалаа**



CHATBOT

Майнголиа биш Туризмонголиа болох уу



Н.ЭНХБАЯР
Mongolian Economy
сэтгүүлийн редактор

“Эдийн засгийн цогц байдлын индекс нь орон нутаг, улс гүрэнд буй мэдлэгийг тухайн орон нутаг, улс гүрний бүтээж байгаа бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээгээр төлөөлүүлэн тооцож буй хэмжих нэгж юм. Тэгэхээр эдийн засгийн цогц байдлын цаадах гол хэмжигдэхүүн нь тухайн улс орны мэдлэгийн түвшин юм” хэмээн “Өсөлтийн оношилгоо: Реформ хийх аргачлал” номд дурджээ. Энэ мэт олон сонирхолтой санааг агуулсан тус номын зохиолч, эдийн засагч Б.Дөлгөөнийг бид энэ дугаартаа урив.

Хөгжлийн эдийн засагч гэж тодотгодог түүнтэй бид Монгол Улсын хөгжлийн төлөв байдал, хөгжилд саад бологч хүчин зүйлс, тэдгээрийг хэрхэн оношилж засах, Улаанбаатар хотын түгжрэл, газрын асуудлыг хөндөж ярилцлаа. Олон шийдэл санал болгосон түүний ярилцлагаас нэгийг тунгаана гэдэгт бид итгэлтэй байна. Тэрбээр “Шинэ сэргэлтийн бодлогын Хурдасгуур төв”-ийн Гүйцэтгэх захирлаар ажиллаж байхдаа хөгжлийн томоохон төслүүдийг хэрэгжүүлж, хүртээмжтэй өсөлтийг хангах, экспорт, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх чиглэлээр маш олон судалгааг амжилттай хийхэд голлох үүрэг гүйцэтгэсэн юм.

2023 онд дэлхийн хэмжээний социал одууд, инфлюенсерүүд, БНСУ-ын урлагийн алдартнууд, телевизийн нэвтрүүлгийн хэд хэдэн баг Монголд хөл тавив. CNN сувгаар

талын Монголыг онцолсон сурталчилгаа, нэвтрүүлгүүд давтамжтай цацагдав. Манай улсад 2023 онд 600 мянган жуулчин ирж, 1.3 тэрбум ам.долларын орлого оруулжээ. Гадаадын жуулчдын хамгийн их зорин очдог Өмнөговь аймгийн жуулчны баазууд, байгалийн цогцолборт газрууд гадаадын, тэр дундаа Өмнөд Солонгосын жуулчдын хөлд дарагдлаа. Солонгос хэлтэй жуулчны хөтөч, жолооч нарын эрэлт огцом өсөв. Тиймээс тус улсын иргэдийн 2024 онд аялах орны нэг нь Монгол байх нь гарцаагүй. Гэхдээ бид гадаадын жуулчдын эл урсгалд бэлэн үү?

Аялал жуулчлалын салбарыг дэмжсэн Засгийн газрын бодлого нь үзэсгэлэн, арга хэмжээнд оролцох төдийгөөр хязгаарлагддаг байсан цаг өнгөрч өнгөрсөн жилээс эхлэн шинэлэг арга барил, системтэйгээр ажиллаж эхэлснийг Монголд уригдсан олон “од”-оос харж болно. Эдийн засгийг солонгоруулах хамгийн ирээдүйтэй салбарын нэг аялал жуулчлалыг хөгжлийн шинэ шатанд гаргах чухал жилүүд биднийг хүлээж байна. Тиймээс энэ сэдвийг хөндсөн нийтлэлүүд энэ удаагийн дугаарт багтлаа.

Мөн даатгалын үйлчилгээний ач холбогдлыг ойлгуулсан үйл явдлуудтай холбогдуулан даатгалын салбарын хоёр контентийг энэ дугаарт багтаалаа.



ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ЭРХЛЭГЧ:
Д.Бэхбаяр (9999 4248)

РЕДАКТОР:
Н.Энхбаяр (9916 1303)

АНГЛИ РЕДАКТОР:
Роберт Йохан Шрайверс
Жаклин Истриж

СЭТГҮҮЛЧИД:
Б.Шүрэнчимэг
У.Сарангэрэл

ОРЧУУЛАГЧ:
М.Ариунзаяа

ДИЗАЙНЕР:
Ш.Оюундарь

МАРКЕТИНГИЙН АЛБА:
9409 2904, 7011 5476

ISSN 2664-195X

СЭТГҮҮЛ ЗАХИАЛГА:
Монгол шуудан (Утас: 7007 8916)
Түгээмэл шуудан (Утас: 7011 5015)

ХАЯГ: Улаанбаатар
Сүхбаатар дүүрэг 2-р хороо
Сөүлийн гудамж. Twin Tower-2 #403

ВЭБ: www.mongolianeconomy.mn
И-МЭЙЛ:

info@mongolianeconomy.mn
FACEBOOK: Mongolian Economy
TWITTER: EconomyMongolia

Таамаг

Эдийн засаг өнгөлөг байх уу?



ОУВС, Дэлхийн банкны шинжээчдийн үзэж буйгаар дэлхийн эдийн засгийн өсөлтийн хурд өмнөх онтой харьцуулахад саарч 2023 онд 2.1-3.0 хувийн хооронд байна. Харин 2024 онд 2.4-2.9 хувь байна гэж таамаглажээ. Дэлхийн эдийн засаг бүхэлдээ өмнөх жилүүдэд бий болсон өндөр инфляцыг хязгаарлах мөнгөний хатуу бодлогыг үргэлжлүүлэн явуулахаар байгаа нь эрэлтийг тодорхой түвшинд хумьж дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнийг бууруулах магадлалтай.

Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдал

Манай улс 2023 онд өндөр инфляцтай тэмцэж, мөнгөний хатуу бодлогыг үргэлжлүүлж байгаа ч түүхий эдийн экспортын өсөлтийн үр дүнд

Инфляц есөн хувьтай гарсан нь хоёр жилийн дараах хамгийн доод түвшинд хүрсэн үзүүлэлт

макро эдийн засгийн үзүүлэлтүүд сайжирч, төсвийн орлого нэмэгдсэн харьцангуй таатай жил болж байна. Энэ онд эдийн засагт гарч буй гол эерэг үзүүлэлтүүдээс дурдвал оны эхний есөн сарын байдлаар эдийн засгийн өсөлт 6.9 хувь, эхний 10 сарын байдлаар экспорт 12.47 тэрбум ам доллар байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 24.3 хувийн өсөлттэй. Үүнд голлон нөлөөлж байгаа хүчин зүйл нь нүүрсний экспорт биет хэмжээгээр 54.4 сая тоннд хүрсэн явдал юм. Инфляц есөн хувьтай гарсан нь хоёр жилийн дараах хамгийн доод түвшинд хүрсэн үзүүлэлт. Валютын нөөц 3.97 тэрбум ам.долларт хүрч оны эхнээс 400 орчим сая ам.доллаароор нэмэгдсэн. Ийн өсөлттэй байсан ам.долларын ханшийг зургаан сараас хойш 3455 орчим төгрөгт тогтвортой байх нөхцөлийг бүрдүүлсэн. ►

► Эдийн засагт гарч буй эдгээр эерэг өөрчлөлт нь нийт экспортын 86 хувийг бүрдүүлж буй эрдэс бүтээгдэхүүний экспортын өсөлттэй салшгүй холбоотой. Тэр дундаа эдгээр бүтээгдэхүүнийг худалдан авдаг манай улсын гадаад худалдааны гол түнш БНХАУ-аас ихээхэн хамаарч байгааг онцлох хэрэгтэй. Гаалийн статистик мэдээллээс харвал оны эхний 10 сарын байдлаар БНХАУ-руу гаргасан бараа бүтээгдэхүүний нийт экспортод эзлэх хувь 90.8, импортийн 40.3 хувийг эзэлж байна. Экспорт нэмэгдэж, төсвийн орлогын өсөлт таамагласан хэмжээнээс давж гарсан шалтгааныг БНХАУ-ын нүүрсний зах зээлтэй холбож тайлбарлах шаардлагатай.

БНХАУ-ын нүүрсний зах зээлийн төлөв

БНХАУ-ын нүүрсний импорт 2023 оны эхний 10 сарын байдлаар өмнөх оны мөн үетэй харьцуулахад 67 хувиар нэмэгдэж 384 сая тонн хүрсэн нь Монгол Улсын нүүрсний экспортын өсөлтөд нөлөөлжээ. Зөвхөн Шивээхүрэн боомтоор 14.82 сая тонн буюу 1.34 тэрбум ам.долларын нүүрс экспортолсон нь Хятадын хуурай газрын дөрөв дэх том боомт Сэхэ нээгдсэн 31 жилийн хугацаанд хамгийн өндөр дүн болсон талаар “Global times” сайтад дурджээ.

Монгол Улс БНХАУ-д экспортолж байгаа коксжих нүүрсний хэмжээгээрээ нэгдүгээрт бичигдэж байгаа ч нийт коксжих нүүрсэнд эзлэх хувь буурсан бол ОХУ-ын коксжих нүүрсний экспортын хувь хэмжээ өсөж хоёрдугаарт эрэмбэлэгдэж байна.

БНХАУ-ын нүүрсний эрэлт огцом нэмэгдсэн шалтгаан нь хэд хэдэн хүчин зүйлээс хамаарч байна. Нэгдүгээрт, дотоодын нүүрс чанар стандартын шаардлага хангаж буй эсэх. Улсаас явуулж байгаа шалгалтын үр дүнд дотоод дахь нүүрсний олборлолт саарсан. Хоёрдугаарт, Ковид-19 цар тахлын дараах үйлдвэрлэлийн сэргэлттэй холбоотой огцом тэлэлт. Гуравдугаарт, Хятадад олборлож буй нүүрсний дулаан илчлэгийн хэмжээ буурсан, үүнээс улбаатай ижил хэмжээний эрчим хүчийг гаргахын тулд илүү их нүүрс шаардлагатай болсон. Дөрөвдүгээрт, өмнөх жилүүдтэй харьцуулахад хур тунадасны хэмжээ бага байгаагаар холбоотой усан цахилгаан станцын

**Нүүрсний
эрэлт огцом
нэмэгдэхгүй ч
Монгол Улсад
ашигтай
нөхцөл байдал
үргэлжилнэ
гэж дүгнэж
болохоор**

үйлдвэрлэн гаргаж буй эрчим хүчний хэмжээ буурсан. Тавдугаарт, импортын нүүрсний үнэ өндөр байсан. Энэ жилийн нүүрсний үнийг 2021, 2022 онтой харьцуулахад буурч дотоодын үнэтэй ижил түвшинд хүрсэн зэрэг шалтгааныг дурдаж болох юм.

БНХАУ-ын нүүрсний худалдаачдын дунд явуулсан судалгаагаар 2024 онд нүүрсний эрэлт нэмэгдэх боловч 2023 оных шиг өндөр байхгүй гэсэн дүгнэлтэд хүрсэн. Нөгөө талдаа БНХАУ-ын Засгийн газрын зүгээс хямралд ороод байгаа үл хөдлөх хөрөнгийн зах зээлд нөлөөлөх оролдлого хийх болно. Энэ нь эргээд эрчим хүчний хэрэглээг тэлэх боломж олгох тухай “Ройтерс” агентлаг дурдсан. Мөн “Олон улсын эрчим хүчний агентлаг”-аас гаргасан “IEA Coal-2023” тооцоогоор БНХАУ-ын нүүрсний импорт 2024 онд 0.3 хувиар нэмэгдэнэ гэж төсөөлжээ. Энэ бүгдээс харвал ирэх онд нүүрсний эрэлт огцом нэмэгдэхгүй ч Монгол Улсад ашигтай нөхцөл байдал үргэлжилнэ гэж дүгнэж болохоор.

Монгол Улсын эдийн засгийн төлөв 2024 онд

Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг 2024 онд Европын сэргээн босголт хөгжлийн банк 7.5, Азийн хөгжлийн банк 5.9, Олон улсын валютын сан 4.5 хувь хэмээн нэлээн хэлбэлзэлтэй төсөөлжээ. Харин Сангийн яам 7.0, Монголбанк 6.0 хувь гэж төсөөлж байна.

Ирэх оны эдийн засагт гадаад хүчин зүйл болох геополитикийн асуудал, тахал, санхүүгийн болон худалдааны хямрал, Хятадын эдийн засгийн нөхцөл байдал дотоод хүчин зүйл болох байгалийн гамшиг, сонгуулийн будилаанаас үүдэлтэй эмх замбараагүй байдал гэх мэт шок үүсэж нөлөө үзүүлэхгүй бол өндөр өсөлттэй байх боломжтой.

УИХ-ын намрын чуулганаар 2024 оны төсвийг хэлэлцэн баталсан. Төсвийн төслөөр Монгол Улсын төсвийн орлого 25.3 их наяд, зарлага 27.4 их наяд, төсвийн алдагдал 2.1 их наяд төгрөг байхаар баталсан. Төсвийн орлогыг өнгөрсөн оноос 18.5 хувь буюу 4.2 их наядар нэмэгдүүлжээ. Харин төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр нь Засгийн газрын зээл болон Засгийн газрын үнэт цаас байхаар байна. ►

Эдийн засгийн өсөлтийн таамаг



► Энэ нь эдийн засгийн идэвхжилт, уул уурхайн салбарын өсөлт, иргэдийн орлогын өсөлт, далд эдийн засгийн бууралт гэсэн дөрвөн хүчин зүйлээс бүрдүүлнэ гэж тооцоолж байна.

Уул уурхайн салбарын хувьд экспортлох нүүрсний хэмжээг 60 сая тонн, зэсийн баяжмал 1.5 сая тонн, алт 20 тонн гэсэн нь өмнөх жилүүдтэй харьцуулахад нэлээд өссөн дүн юм. Хэрэв БНХАУ-ын нүүрсний эрэлт таамагласны дагуу өсөх тохиолдолд манай улс нүүрсний экспортыг 60 сая тоннд хүргэх төлөвлөгөө биелэх боломжтой.

УИХ-ын сонгуультай холбоотой төсөв тэлэх хандлагатай байдаг. Эдийн засагт үүсэх дарамт, цаашдын эрсдэлийг бодолцон зарлагаа орлоготойгоо уялдуулах замаар алдагдалгүй төсөв батлах боломжтой байв. Энэ тохиолдолд Засгийн газрын өрийн хэмжээ нэмэгдэхгүй, эдийн засагт ирэх ачаалал бага байх боломжтой юм. Засгийн газрын өр 2023 оны есдүгээр сарын байдлаар 30.8 их наяд төгрөг байгаа ч алдагдалтай төсөв баталсан нь өрийн хэмжээ өсөж эдийн засагт үзүүлэх дарамт нэмэгдэхээр харагдаж байна.

Улсын төсвөөс хийх гол хөрөнгө оруулалтууд дэд бүтэц, нефть, эрчим хүч болон нийгмийн салбарууд руу чиглэж үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлд хөрөнгө оруулалт маш бага байна. Энэ нь урт хугацаанд үйлдвэрлэлээр эдийн засгийг

тэлэх боломжийг хомс болгож байгааг анхаарах хэрэгтэй.

Төсөв ийнхүү ихээр тэлэхээр байгаа нь Төв банкнаас явуулж буй мөнгөний бодлогыг тодорхой үр дүнд хүргэхэд төвөгтэй нөхцөл байдал үүсэхэд хүргэж байна. Монголбанкны зүгээс ирэх онд инфляцын түвшнийг зургаан хувь дээр нэмэх, хасах хоёр хувьд барихаар төлөвлөж байна. Гэхдээ өмнөх жилүүдийн өндөр инфляцын шок, ирэх жилийн сонгуулийн нөлөө, ОХУ болон Украин, Израил болон Палестины нөхцөл байдлаас шалтгаалан нефтийн үнийн тогтворгүй байдал үүсэх эрсдэлтэй. Тиймээс инфляц зорилтот түвшинд хүрэхгүй байх магадлал бий. Тухайлбал, ОХУ-тай манай улс 2022 оны аравдугаар сард АИ-92 шатахууныг 2027 он хүртэл тогтвортой үнээр, дизелийн түлшийг 10 хувийн хөнгөлөлттэй үнээр худалдан авахаар гэрээ байгуулсан. Гэтэл 2023 онд ОХУ-ын Засгийн газраас дотоод дахь эрэлт нийлүүлэлтийн тэнцвэрийг хангах зорилгоор экспортын нефтийн бүтээгдэхүүнд түр хугацааны хориг тавьсан нь манай улс шатахууны хомсдолд орох, үнэ тогтворгүй байх эрсдэлийг үүсгэж байна.

Үүнээс харахад Монголбанкны зүгээс хэрэгжүүлэх инфляцын талаарх бодлого нэлээд сорилттой тулгарахаар байна. АХБ-ны зүгээс манай улсын инфляцыг 2024 онд 8.6 хувь байхаар төсөөлж байгаа нь ч инфляц нам түвшинд байхгүй гэдгийг харуулж байна.

Дээрх бүхнээс дүгнэхэд 2024 онд эдийн засгийн нөхцөл байдал дотоодын үйлдвэрлэл, үйлчилгээнээс илүүтэй түүхий эдийн экспортын хэмжээнээс хамааран 2023 оны түвшнээс дордохооргүй байна. Гэхдээ Хятадын эдийн засгийн нөхцөл байдал, дэлхий дахинаа баримталж буй мөнгөний хатуу бодлого, дайны нөхцөл байдлуудыг анхаарах шаардлагатай. Мөн БНХАУ-ын хувьд нүүрсний импорт 2023 онтой адил түвшинд байхаар төлөв ажиглагдаж байгаа. Гэсэн ч манай улсын зүгээс боомтын хүчин чадлыг нэмэгдүүлэхээс гадна нүүрсний үнийн бууралт, БНХАУ-ын үл хөдлөх хөрөнгийн салбарын зогсонги байдал, экспортын эрэлтийн бууралт зэрэг үүсэж болох эрсдэлийг тооцож эдийн засгийн хувьд авах хариу арга хэмжээг бодолцох нь зүйтэй. ■

Төсөв ийнхүү ихээр тэлэхээр байгаа нь Төв банкнаас явуулж буй мөнгөний бодлогыг тодорхой үр дүнд хүргэхэд төвөгтэй нөхцөл байдал үүсэхэд хүргэж байна

Дэлхий 2024 онд ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИ булан

Хиймэл оюуны судалгаа хэрхэх вэ?

Ирэх жил хиймэл оюун ухаан хэрхэн хөгжих бол

Хиймэл оюуныг сонирхох явдал 2023 онд дээд цэгтээ хүрэв. OpenAI компани интернэтийн хамгийн алдартай, хэрэгтэй чатбот ChatGPT-ийг 2022 оны арваннэгдүгээр сард танилцуулснаас хагас жилийн дотор “хиймэл оюун” гэх хайлт Google-д дөрөв дахин нэмэгджээ. Бүтээгч хиймэл оюуныг ямар нэг байдлаар ашигладаг гэж McKinsey Global Survey судалгаанд оролцогчдын гуравны нэг нь 2023 оны наймдугаар сард хариулсан.

Тус технологи 2024 онд хэрхэн хөгжих вэ? Судлаачид хиймэл оюуны загварыг хэмжээ, өгөгдөл, хэрэглээ гэсэн гурван үндсэн чиглэлд сайжруулж байна.

Хэмжээнээс эхэлбэ. Хиймэл оюун том байх тусмаа сайн гэдэг онол ноёрхож байв. Компьютерын хүчин чадал нэмэгдэн хэмжээ нь жижгэрсэн бол тэрбум, их наяд параметраар хэмжигддэг хэлний том загваруудын хувьд (LLM) тийм биш юм. SemiAnalysis байгууллагын мэдээлснээр ChatGPT-ийн делюкс хувилбарын ард буй GPT-4-ийн LLM-ыг сургахад 100 сая ам.доллар, 16 мянган тусгай GPU чип, хэдэн долоо хоног шаардагджээ. Өдгөө хүмүүсийн асуултад хариулж сургах зардал нь LLM-ийг өргөжүүлэх зардлаас давж буйг Nvidia компани мэдээлсэн.

Хиймэл оюун арилжааны бүтээгдэхүүн болсноор гүйцэтгэлийг нь хадгалахын зэрэгцээ илүү хурдан, овор багатай болгоход анхаарч байна. Ингэх нэг арга бол жижиг загварыг илүү их өгөгдөл ашиглан сургах юм. Жишээлбэл, 2022 онд Google DeepMind-ын гаргасан “Chinchilla” нь OpenAI-ын GPT-3 загварын дөрөвний нэгтэй тэнцэх хэмжээтэй ч хүчин чадлын хувьд илүү аж. Өөр нэг арга бол тухайн загварыг бүрдүүлэгч параметруудын тоон нарийвчлалыг багасгах. Гүйцэтгэлд ямар нэг доголдол гаргахгүйгээр Chinchilla шиг хэмжээтэй загварыг GPU чипд суулгах боломжтойг Вашингтоны Их сургуулийн баг харуулжээ. Хамгийн гол нь жижиг загваруудыг ашиглахад зардал бага байдаг. Заримыг нь ухаалаг утас, зөөврийн компьютерт ч ашиглаж болдог.

Дараагийнх нь өгөгдөл. Хиймэл оюуны загваруудыг их хэмжээний өгөгдөлд тулгуурлан сургах тусам илүү өгөөжтэй болдог. Гэхдээ “хэр их вэ?”-гээс “хэр сайн бэ?”-д илүү анхаарч эхэлж байна. Эдгээр загварыг сургахад ашигладаг өгөгдлийг олох улам хэцүү болж буй үед энэ маш чухал. Ирэх жилүүдэд чанартай, шинэ агуулга бүхий текстийн нөөц дуусаж магадгүй. Ирээдүйн загваруудыг сургахад өмнөх загваруудын гаргасан үр дүнг ашигласнаар чадвар нь муудах магадлалтай бөгөөд хэлний том загварыг хэрэглээнд

нэвтрүүлсэн нь интернэт өгөгдлийн эх үүсвэрийн үнэ цэнийг бууруулж байна. Гэхдээ хэмжээ бас бүхнийг шийдэхгүй. Зөв өгөгдлийг ашиглах нь шинжлэх ухаан гэхээсээ урлаг болоод буй. Загваруудыг ярианы хэл, компьютерын код, зураг, бичлэг зэрэг холимог өгөгдөлд тулгуурлан чадавхжуулж, сургах нь ихсэж байна.

Ямар шинэ хэрэглээ үүсэх вэ? Хиймэл оюуны хувьд хүмүүс ашиглах аргаа ч олоогүй байхад түрүүлж хөгжихөөд өндрөөс харж буйтай адил нөхцөл үүсээд буй. Юу хийж чадахыг нь харуулах гэхээсээ илүү юунд ашигтайг олох нь чухал байна. Улмаар загваруудын чанараас илүү хэрхэн үр өгөөжтэй ашиглах нь гол дэвшил болно.

Өдгөө эдгээр загварыг ашиглах гурван үндсэн арга буй. Эхнийх нь “даалгавар боловсруулах” буюу хэрэглэгч хүссэн үр дүндээ хүрэхийн тулд хиймэл оюунд чиглэл болохуйц үг хэллэг, асуултыг оруулах арга юм. Дараагийнх нь “нарийн тохируулах” буюу тодорхой даалгаврыг илүү үр дүнтэй

биелүүлэх үүрэгтэй загвар. Өмнө үүсгэсэн загварыг тухайн даалгаварт тохирсон илүү нарийвчилсан өгөгдлүүд ашиглан дахин сургадаг гэсэн үг. Жишээлбэл, хиймэл оюуныг эрүүл мэндтэй холбоотой асуултад сайн хариулдаг болгохын тулд эрүүл мэндийн сэтгүүлийн нийтлэлүүд ашиглан “нарийн тохируулга” хийх боломжтой. Гурав дахь нь LLM-ийг илүү том, хүчтэй бүтцэд суулгах. LLM нь хөдөлгүүртэй адил учраас тодорхой зорилгод хүрэхийн тулд хөдөлгүүртэй тулгуурлан машин бүтээх хэрэгтэй.

Үүний нэг жишээ бол “сэргээн баяжуулсан хариулт” (RAG) буюу LLM-ыг нэмэлт программ болон тодорхой сэдвээрх мэдлэгийн өгөгдөлтэй хослуулан илүү зөв хариулт гаргах арга юм. Тавигдсан асуултад хариулт хайхдаа систем эхлээд өөрийн өгөгдлийн санд хайлт хийдэг. Хэрэв тохирох мэдээлэл олвол түүнийгээ асуулттай нь хамт LLM-д дамжуулан тухайн мэдээллээс хариултаа гаргаж авахыг санал болгодог. Ийм маягаар эх сурвалжийг санал болгосноор хэрэглэгч илүү оновчтой хариулт олж авсан гэдэгтээ итгэж болно. Энэ нь LLM-ийг Google-ийн NotebookLM шиг хувь хүний хэрэглээнд тохирсон болгож байгаа юм.

Хиймэл оюуны арилжааны боломжид анхаарал төвлөрч буй үед ерөнхий хиймэл оюуны төлөөх өрсөлдөөн үргэлжилж байна. LLM болон бусад бүтээгч хиймэл оюуны хэлбэрүүд том зургийн нэг хэсэг, эсвэл түүнд хүрэх нэг алхам байж болох ч эцсийн хариулт лав биш. Стэнфордын их сургуулийн эрдэмтэн Крис Мэннинг “Хиймэл оюун бол мэдрэлийн төгс бүтэц бөгөөд үүнээс илүү гарах зүйл байхгүй гэж үзэх үндэслэл үгүй” гэж хэлжээ. ■

Хиймэл оюун бол мэдрэлийн төгс бүтэц бөгөөд үүнээс илүү гарах зүйл байхгүй гэж үзэх үндэслэл үгүй

Газар

Сэтгэлгээ өөрчлөгдвөл газар амь орно

Улаан-
баатарын
газар
шорооноос
нэг ч дарга
мяндагтанд
бүү өг

“Миний нутгийн газар шорооноос бурхан гуйсан ч бүү өг” гэсэн Галдан бошигтын алдартай захиас бий. Афоризм болтлоо эшлэгдэх болсон эл үгийг хэлсэн түүхэн учир шалтгаан, контекстыг нь үл харгалзах, эсвэл үл ойлгосны улмаас өдгөө зарим хүн янз бүрийн зорилгоор ашигладаг. Үндсэрхэг, мөн эдийн засаг, нийгмийн үндэслэлгүй аргументдаа бамбай болгож, гадныхан руу чиглүүлэх нь түгээмэл.

Харин энэ үгийг “Улаанбаатарын газар шорооноос нэг ч мяндагтан тушаалтанд бүү өг” хэмээн өөрчилбөл бодит байдалтай илүү нийцнэ. Учир нь нийслэлийн эрх мэдэлтнүүд газрыг зөвхөн хувийн, фракцын ашиг сонирхолдоо ашигласаар ирсэн.

Газрыг бид том зургаар хардаг эсэх эргэлзээтэй. Малын бэлчээр, тариалангийн талбай, барилгын талбай гэсэн ерөнхий зориулалтаас илүүтэйгээр уур амьсгалын өөрчлөлтийг хазаарлах, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, хүртээмжтэй бөгөөд тогтвортой хотжилтыг дэмжих, хүн амьдрахад ээлтэй ногоон, цэвэр, эрүүл орчныг бүрдүүлэх, эдийн засгийн хөгжлийн суурь болох зэрэг өргөн утгаар нь газрыг ойлгож, ашиглах ёстой юм. Гэтэл Улаанбаатарын алга дарам сул газрыг ч эрх мэдэлтэнүүд зөвхөн мөнгө, эрх мэдэл гэсэн линзээр хардаг. Харин иргэд нь машинаа тавих зогсоол, хашаа хатгах орон зай мэтээр дүгнэдэг. Ийм явцуу өнцөг нь өнөөгийн замбараагүй хот төлөвлөлт, түгжрэл, сургууль, цэцэрлэггүй хорооллууд, хүүхдийн тоглоомын талбай болон ногоон байгууламжгүй орон сууц бий болоход нөлөөлсөн. Өөрөөр хэлбэл, бидний сэтгэлгээ бохирдож, газар хэмээх асар том капиталыг тархин дахь түгжрэлийнхээ улмаас цөөн хэдэн өнцгөөр хардгаас энэ бүхэн эхлэлтэй. Дээр нь ёс суртахуунгүй байдал, тодруулбал авлига, хээл хахууль нь газрын менежментийг нийслэл хотод, аймаг орон нутагт ч эмх замбараагүй болгожээ.


2010 онд Перу улсын нэрт эдийн засагч,

Нобелийн шагналт Эрнандо Де Сото “Монголын эдийн засгийн форум”-д оролцохдоо “Улаанбаатарын гэр хорооллын газар дор 7.2 тэрбум доллар сул хэвтэж байна” гэж хэлсэн. Түүнээс хойш 14 жил өнгөрсөн ч байдал өөрчлөгдсөнгүй. Гэр хороолол улам тэлж, өнөөх олон тэрбум долларыг “хөдөлгөх” нэг ч санаачилга дорвитой ажил хэрэг болсонгүй. Гэр хорооллыг орон сууцжуулах төслүүдийн хувь заяа бүдгэрч, ихэнх нь замын дундаа таг зогсжээ. Шаардлагатай дэд бүтцийг нь Засгийн газраас бариад эхэлсэн бол нэг бус нэлээд хэдэн яндан цөөрч, олон айл орон сууц, хувийн байшинтай болж, агаарын бохирдол, түгжрэл тодорхой хэмжээгээр буурах байв. 2022 он гэхэд 24 байршилд 80 мянга орчим айлын орон сууц ашиглалтад оруулна гэсэн “сайхан” тооцоог 2013 онд гаргаж байсныг сануулья.

Газар ашиглалтын талаарх буруу сэтгэлгээ, бодлын тусгал нь Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтээс харагддаг. Уг нь нийслэлийн газар зохион байгуулалт болон хот төлөвлөлтийн “үндсэн хууль” нь эл төлөвлөгөө байх ёстой.

УИХ 2013 онд “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага” баримт бичгийг баталсан. Гэвч эл төлөвлөгөөнд дэвшүүлсэн зорилтуудын биелэлтийг 2018 онд хот төлөвлөлтийн чиглэл тус бүрээр үнэлэхэд хэрэгжилт нь 29,6 хувь байжээ. Үүний шалтгааныг Хот төлөвлөлт, судалгааны институтийн тайланд “ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх тогтолцоо бүрдээгүй, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө хугацаа хоцорч батлагдсан, салбарын мастер төлөвлөгөө бүрэн боловсруулагдаагүй, Ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, санхүүжилт хангалтгүй, Ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтэд мониторинг хийх тогтолцоо бүрдээгүй” гэж товч тодорхойлжээ. Үүний улмаас Улаанбаатарын ►

Улаанбаатар хотын суурьшлын төсөөлөл



► усны нөөц багасаж, суурьшлын бүсийн тэлэлт нэмэгдэж, дагуул хотуудын хөгжил удаашралтай, нийгмийн дэд бүтцийн хангамж тэнцвэргүй, орон сууцны барилгажилт нэмэгдсэн ч иргэдийн бодит, санхүүгийн байдалд нийцээгүй хангамж муутай, гудамж замын сүлжээ хүртээмжгүй, инженерийн бэлтгэл арга хэмжээний төлөвлөлт үе шат бүрд дутуу хэрэгжсэн мөн барилга байгууламжийн бүтээн байгуулалт, инженерийн дэд бүтцийн хүчин чадал, нөөц бололцооноос давсан үзүүлэлттэй хот болжээ.

2020 онд “Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үзэл баримтлал”-ыг УИХ дэмжсэнээр “Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө” боловсруулагдсан. Бохирдсон сэтгэлгээ, явцуу эрх ашиг, чадамжгүй институцүүдээ өөрчлөхгүй л бол нийслэл уг төлөвлөгөөний дагуу хөгжихгүй байх магадлал нэмэгдэж, өмнөх төлөвлөгөөнүүдийн адил дашийн шог болно.

Сингапурын Төлөвлөлтийн газар НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран анхны Ерөнхий төлөвлөгөөг 1971 онд гаргасан. “Тус төлөвлөгөө нь Сингапурыг аж үйлдвэрийн бүс, арлыг тойрсон амралт зугаалгын төвүүд бүхий шинэ

дагуул хотуудтай, тэдгээр хотууд нь авто зам, хурдны зам, метроны системээр холбогдсон, нисэх буудал зэрэг томоохон дэд бүтэцтэй, шинэ, орчин үеийн хотын төв, хүн ихтэй бүсээс холдож Чангид шинээр байгуулсан газар руу нүүсэн, дөрвөн сая оршин суугч бүхий Сингапурыг төсөөлсөн үнэхээр зоримог, урт хугацааны алсын хараа байлаа” хэмээн Үндэсний хөгжлийн яамны Амьдрахад таатай хотуудын төвийн гүйцэтгэх захирал Күү Тен Чай бичжээ.

Сингапурын сайн туршлагаас дурдаж буй нь учиртай. Учир нь өргөн уудам нутаг дэвсгэртэй ч дөрвөн уулын дундах нийслэл хотдоо (4,704.4 км2) чихэлдэн амьдарч буй Улаанбаатарын 1.7 сая иргэн 734.3 км2 газар нутагт аж төрж буй 5.4 сая сингапурчууд шиг сэтгэж, алсын хараатай байх шаардлагатай.

Тус улсын Ерөнхий сайд Лий Куан-Ю 2009 онд “Centre for Liveable Cities”-д өгсөн ярилцлагадаа “Бидэнд 1950-аад онд хотоо дахин хөгжүүлэх боломж олдсонд би сэтгэл хангалуун явдаг. Тэр бол амьдралд нэг л олдох боломж байлаа” хэмээн өгүүлсэн. Тэгвэл Улаанбаатар хотыг хөгжлийн өнөөгийн түгжрэлээс нь зөвхөн шинэ сэтгэлгээтэй, алсыг харсан удирдлага л (мөн иргэд) гаргаж чадна. ■

Бохирдсон сэтгэлгээ, явцуу эрх ашиг, чадамжгүй институцийг өөрчлөхгүй бол нийслэл хөгжихгүй

Онцлох зочин

Эдийн засагч
Б.ДӨЛГӨӨН:

**Үндэслэл
нотолгоогүй
бодлого их
гарах тусам
доороо хий
эргэдэг**



Б.Дөлгөөн нь Шинэ Сэргэлтийн Бодлогын Хурдасгуур Төвийн гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан. Тэрбээр Ерөнхий Сайдын дэргэдэх Эдийн засгийн Зөвлөлийн гишүүн юм. 2020- 2022 оны хооронд Үндэсний Хөгжлийн Газарт Дэд дарга, Эдийн Засаг, Хөгжлийн Яамны сайдын зөвлөхөөр тус тус ажиллаж байсан. Монголын эдийн засаг, санхүүгийн салбарт 10 гаруй жил ажилласан туршлагатай. Төрийн чадамжийг бүрдүүлэх чиглэлээр төрийн албан хаагчдад сургалт хийдэг.

Б.Дөлгөөн 2007 онд АНУ-ын Коннектикат коллежид математик, эдийн засагч мэргэжлээр бакалавр, 2018 онд АНУ-ын Харвардын их сургуульд олон улсын хөгжлийн эдийн засгийн магистр зэргүүдийг тус тус хамгаалсан. Англи, хятад хэлтэй.

Тэрбээр цөөнгүй бүтээл монгол хэлнээ хөрвүүлснээс олон нийтийн эдийн засгийн мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр Абхажит Банержи, Эстер Дүфло нарын зохиосон "Хүнд үеийн эдийн засаг" (2020), төрийн үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр Матт Эндрьюс, Ланч Притчетт, Майкл Вүүлкок нарын "Төрийн чадамжийг бүрдүүлэх нь" (2022) зэрэг номыг нэрлэж болно.

2023 онд "Өсөлтийн оношилгоо: Реформ хийх аргачлал" номоо хэвлүүлсэн .

Эдийн засагч Б.Дөлгөөн. Хөгжлийн эдийн засагч гэж түүнийг тодорхойлдог. Монгол Улс эдийн засгийн эрс шилжилт хийж, хүн бүр картын бараанд оочирлодог байсан хүнд үед түүний хүүхэд нас өнгөрсөн. Яг л Энэ үеэс тэрбээр өрх гэр ядуурлаас хэрхэн гарах, улс орны хэмжээнд ядуурлыг бууруулахад юу хийх ёстой юм бол хэмээх цаашид сурч, ажиллах их замын мөрөөдлийнхөө эхийг олж авсан гэдэг. Хөгжлийн эдийн засагч болохоор Харвардын их сургуулийг зорьж очсон түүхийг нь би уншиж байсан юм. Шинэ залуу үеийн төлөөлөл үр хойчдоо өнөөдөр байгаагаас илүү нийгмийг хүлээлгэн өгөх ёстой гэж зорьж яваа түүнтэй ярилцах олон сэдэв байгаа ч энэ удаад Монгол Улсын эдийн засаг, хөгжил цэцэглэлтийн боломжийн талаар ярилцлаа.

-Та АНУ-ын Коннектикут коллежийг математикч, эдийн засагч мэргэжлээр бакалавр, Харвардын Их Сургуулийг олон улсын хөгжлийн эдийн засгийн магистр зэрэгтэй төгссөн. Яагаад эдийн засагч болохоор шийдсэн бэ?

-Миний хүүхэд нас Улаанбаатар хотын 120 мянгад өнгөрсөн. Тухайн үед Монгол Улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засаг руу шилжиж, давснаас бусад нь хомсдоод, толгойтой бүхэн картын бараанд оочирлодог байв. Хэдэн зуун мянган хүн ажилгүй болж, олон мянган хүн архинд орж, гэрээсээ дайжсан хүүхдүүд траншейнд амьдарч эхэлсэн. Монголчууд бид их хүнд үеийг туулж өнгөрсөн дөө. Намайг дунд ангид ороход Монголын түүхийн хичээлээр монголчууд 800 жилийн өмнө дэлхийн талыг эзэлж, эзэнт гүрэн байгуулсан тухай зааж байсан. Гэтэл хичээлээ тараад гэртээ харих замд амьдрал нь хүндэрч, хог түүж амьдардаг хүмүүстэй тааралддаг байлаа. Тэдэн дунд ах дүү хоёртой их тааралдана. Одоо санахад ах нь улаан өмдтэй, хар малгайтай, байнга толгой гудайлгаад шуудайгаа үүрч алхдаг, харин дүү нь ерөөсөө ийм хүнд амьдарч байгаа гэж огт боддоггүй юм шиг урагшаа хойшоо гүйж явдагсан. Тааралдах болгонд тэд яагаад ийм байдалд орчихов гэсэн бодол надад төрдөг байлаа.

Бидний өвөг дээдэс дэлхийн талыг эзэлсэн гүрэнт улс байгуулсан атал яагаад үр хойч нь ингэж хог ухаж, амьдралаа залгуулах хүртлээ доройтов оо гэж өөрөөсөө асууна. Энэ цаг мөчөөс би хүмүүс яагаад ядуурал руу гулсаж ордог, эдгээр хүмүүсийг эргээд энгийн амьдралд нь оруулахын төлөө би юу хийж чадах бол гэж явсаар эдийн засгийн ухааныг судалж эхэлсэн дээ. Энэ чиглэлээр өөрийгөө үргэлж бэлдье, улс маань дахин ийм хүнд нөхцөлд бүү ороосой, орсон ч ийм алдаа дахин бүү гаргаж, ийм олон жилийг битгий алдаасай гэж боддог. ▶

► -Олон улсын хөгжлийн эдийн засагч мэргэжлийг сонгох болсон шалтгаан юу вэ?

-Тун товчхон хэлбэл үнэнийг мэдэх гэж сурсан. Бакалавртаа эдийн засаг үзсэн учир улс орон хөгжиж байж ядуурлыг бууруулдаг гэдгийг мэдэж байсан ч хэрхэн хөгжих вэ гэдэг асуултад хариулт хайхад би хангалттай суралцаагүй байснаа ойлгосон. Дэлхий дээр болсон, болоогүй олон онол байдаг, аль нь зөв, аль нь буруу вэ гэдгийг ялгаж салгах чадвар хараахан эзэмшээгүй байсан учраас магистрт сурах шаардлагатай гэдэг дүгнэлтэд хүрсэн гэх үү дээ.

Хэрэв хөгжлийн жорыг мэдэж, мэдсэнээ хэрэгжүүлж чадвал өнөөдрийн монголчууд бид бүгдээрээ энэ цаг үед урагшаа нэг алхаж, амьжиргааны түвшингээ дээшлүүлж, эх нутагтаа сайхан амьдрах боломж бүрдэнэ гэдэгт хувьдаа итгэлтэй байдаг. Миний хувьд ямартай ч хөгжлийн жорыг тодорхой түвшинд судалж мэдсэн, одоо өөрийнхөө чадлаар хэрэгжүүлэлтэд нь анхаарч ажиллаж байна. Намайг Лондонгийн Эдийн засгийн сургуульд нэг жил суралцахад манай сургуулийн уриа нь “Felix, qui potuit rem cognoscere causa” буюу орчуулбал, аливаа зүйлийн учир шалтгааныг мэдэж чадсан хүн азтай гэсэн утгатай байсан.

Өнөөдөр монголчууд илүү өндөр цалин хайгаад Солонгос, Япон руу ажиллахаар явж байна. Хэрэв манай улс эдийн засгийн хөгжлөөрөө Япон шиг, Сингапур шиг, Хятад шиг хурдтай өсөж чадвал залуус маань гадагшаа явах шаардлагагүй болно. Сүүлийн 50 жилийг харвал яагаад зарим улсын эдийн засаг ийм удаан өсөв, цөөн хэд нь яагаад бусдаасаа тасрав гэдэг асуулт урган гарна. Цааш ухвал, ерөөсөө улс орны хөгжлийн ялгаа тухайн улс орны боловсруулж, баримталж, амжилттай хэрэгжүүлсэн бодлогоос л хамаарна. Зарим улсын эдийн засаг 50 жилийн хугацаанд 3-4 дахин томорсон байхад зарим улс орных 15 дахин томорсон кэйсүүд бий.

Нэг хүнд ногдож буй орлогоороо монгол хүн өнөөдөр 5000 ам.долларт хүрсэн нь 1970-аад оны Нидерландын иргэнтэй адил түвшин юм. Харин 50 жилийн хугацаанд нидерланд хүний орлого даруй 12 дахин өсөж, 60,000 ам.долларт хүрсэн. Ийм хөгжил дэвшлийн учир шалтгааныг мэргэжлийн түвшинд судалсны хувьд өнөөдөр сурч мэдсэнээ хуваалцахаар хичээж ажиллаж

**Миний хувьд
хөгжлийн жорыг
тодорхой
түвшинд судалж
мэдсэн, одоо
өөрийн чадлаар
хэрэгжүүлэлтэд
нь анхаарч
ажиллана**

байна.

-Зах зээлийн шилжилтийн тэр үетэй харьцуулбал Монгол Улсын өнөөгийн хөгжил тэнгэр газар шиг ялгаатай болсон. Гэхдээ бидэнд үүнээс илүү хөгжих боломж байсан гэж боддог.

-Би өвөө, эмээ дээрээ өссөн. Өвөө маань хоёр ч дайнд оролцож улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг хадгалж үлдэхэд бүхнээ зориулсан хүн байсан юм. Дайны үеэр өвөөг морьтой довтолж явахад урд нь гранат дэлбэрч, морь нь үхээд өөрөө азаар амь гарсан. Ингээд бодохоор өвөө, эмээ маань эх орныхоо төлөө амь биеэ зориулж байжээ. Улс орны тусгаар тогтнолыг бүрдүүлж, бие даасан байдлыг цогцлоосон нь та бидний өвөө эмээ, аав ээж, ах эгчийн гавьяа. Одоо бидэнд эдийн засгаа өсгөж, монгол хүн бүр амар тайван, эрүүл орчинд өөрийн потенциалгаа ашиглаж чадах нийгмийг бүрдүүлэх үүрэг хариуцлага ирээд байна гэж боддог. Үүний үр шимийг магад та бид бүрэн эдэлж чадахгүй ч таны хүүхэд, манай хүүхэд хамтдаа хүртэнэ гэж би бодож ажилладаг.

Мэдээж илүү боломжийг та бид хаа нэгтээ золиосолж байгаа болов уу. Америкт магистраа хамгаалсны дараа манай гэр бүл цаашид хаана ажиллаж, амьдрах вэ гээд хоорондоо ярилцсан. Тэр үед Япон Улсын талаар их эргэцүүлсэн юм. Японы хотууд Дэлхийн II дайны дараа газрын хөрстэй тэгшлэгдэж, үнсэн товrog болсон байсан шүү дээ. Гудамжаа, хотоо, нийгмээ цаашлаад улсаа хэн босгосон юм? Үүнийг тэр үеийн япон залуус хөлс хөдөлмөр, оюун ухаанаа зарцуулж, бие сэтгэлээ зориулсны үр дүнд бий болгосон. Бүтэн үе нэг зорилгын төлөө нэгдэж чадсанаар өнөөдөр япон хүн өндөр хөгжилтэй эх оронд амьдарч, ядууралгүй эдийн засгийг бүтээж, бохирдолгүй орчин бүрдүүлжээ. Би Америкт ажиллавал магадгүй хөгжсөн улсын асуудлыг шийдэхэд л өөрийгөө зориулах байх. Харин Монголдоо ажиллавал дараачийн үедээ олон боломжийг бий болгож чадна гэж итгэсэн учраас эргэж ирсэн.

Магадгүй улсаа бие даан, монгол ухаанаар хөгжүүлэх боломж, бололцоо сүүлийн 30 жилд л монголчууд бидэнд бүрэн утгаараа гарч ирж байна. Энэ боломжийг энэ цаг үед та бидашиглаж, эрх чөлөөг энэ нутагт мөнхлөн үлдээх түүхэн ►



Харвардын их сургуулийн төгсөлтийн баяраар (2018.05)

► үүрэг ирсэн ч байж болох. Улс орны хөгжил гэдэг алга урвуулахын төдийд хурдан бий болдог эд ерөөсөө биш ч үндэслэл нотолгоотой бодлого боловсруулж, хэрэгжүүлж чадвал эдийн засгаа хурдтай өсгөж, 20-30 байраар урагшлуулах боломж хангалттай бий.

-Та бол монгол хүний оюуны потенциалыг харуулж яваа залуусын нэг төлөөлөл. Таны орчуулсан "Төрийн чадамжийг бүрдүүлэх нь" номын удиртгалд "... Аливаа системийг бодит үр дүнгээ өгтөл нь зүтгэж ажлынхаа ард гардаг тэр хүмүүст номоо зориуллаа" гэсэн байсан. Та эрдэм мэдлэг, боловсролыг юу гэж ойлгодог вэ?

-Оюуны потенциалгаа харуулж яваа олон сайхан залуу Монголдоо ажиллаж, гадагшаа сурсан нь эргэн ирж байгааг хараад улс маань хөгжих юм байна гэдэг итгэл үнэмшил бэхэждэг. Магистраа төгсөөд Монгол буцахаас өмнө Малайз гаралтай Винг Вүү гэдэг профессортой би уулзсан юм. Тэр намайг Монгол руугаа буцах гэж байгааг сонсоод нэг бодлоо хуваалцсан юм. Түүнийг 1990-ээд онд Харвардын их сургуульд эдийн засгийн доктороор суралцаж байхад

**Хөгжлийн
жорыг мэдэж,
мэдсэнээ
хэрэгжүүлж
чадвал эх
нутагтаа
сайхан
амьдрах
боломж
бүрдэнэ**

Монголд ардчилсан хувьсгал гарч, талбай дүүртэл жагсаж байж. Эрх мэдлээ өгөхгүй гэсэн зарим улсын удирдагчид танк ашиглаж байхад Монголын удирдагчид хулганын хамраас цус гаргалгүй шилжилт хийж, жагсагчдын хүсэлтийг хүлээж авахыг хараад Монгол Улс хөгжих нь дээ гэж Винг Вүү гуай бодсон юм билээ. Ийм гэгээлэг бодлыг нь сонсоод би "бүх монгол хүний зүрхэнд эх орноо гэсэн сэтгэл асаж байдаг юм аа" гэж хариулж байсан.

Би мэдлэг чадварыг сургуулийн диплом, эсвэл нэр хүндээр хэмждэг гэж боддоггүй. Боловсрол бол үнэнийг худлаас ялгаж мэдэх чадвар л гэж үздэг. Харвардад сурахаар явахдаа би хоёр "том" ачаатай явсан. Нэг нь гэр бүлээ авч явах ёстой гэсэн бодол, нөгөө нь аливаа зүйлийн учир шалтгааныг мэдэх хүсэл. Эдийн засгийн чиглэлээр суралцахаар ихэнх асуудлын шалтгаан олон хүчин зүйлээс үүдэлтэй байдгийг ойлгодог. Бас аль хүчин зүйл нь уялдаа холбоо, аль нь жинхэнэ учир шалтгаан бэ гэдгийг ухаардаг. Мэдээж учир шалтгааныг уялдаа холбооноос ялгахын тулд судалгаа шаардлагатай. Энэ хоёрыг ялгаж салгахгүй андуурч эндүүрвэл, хэчнээн ►

► уянгалаг шийдвэр гарлаа ч та бидний амьдралд тулгарч буй асуудал хэвээрээ үлдэх нь их. Олон улсад ч асар олон ийм бүтэлгүй тохиолдол бий. Тиймээс асуудлыг шийдэхийн тулд түүнийг зөв оношилж чадах мэргэжилтнүүд л хэрэгтэй. Үүнийг нь удирдаад зөв шийдэлд хүргэх улс төрчид шаардлагатай. Нэг захаас нь нөгөө захад очиход дөрвөн өдөр, дөрвөн шөнө давхиж хүрэх өргөн уудам эх орныг маань Оюу толгой, Таван толгой биш Монгол толгой л хөгжүүлнэ.

-Таны сүүлд гаргасан “Өсөлтийн оношилгоо: Реформ хийх аргачлал” номд бүхэлдээ улс орны эдийн засгийн хөгжлийн гарц гаргалгаа юу болох тухай өгүүлдэг. Сурч мэдсэнээ тайлагнасан бүтээл юм байна гэж бодсон?

-“Бүү мэд. Мэдсэн хүнээс бүү сур” гэсэн тангад хараал байдаг. Үүний яг эсрэгийг нь хийхийг би зорьж, сурч мэдсэнээ бусадтай хуваалцахыг эрхэмлэдэг. Улс орны хөгжил бол

хэн нэгэн аавын хүү ганцаараа хийдэг ажил биш. Олуулаа, тэр дундаа мэдэж сурсан хүмүүс улс төрийн институцэд нэгдэж байж хийдэг зүйл. Би хувьдаа аль ч намын эцсийн зорилго нь улсын хөгжил байх ёстой гэж боддог учир намчирхаад байдаггүй, хүмүүстэй уулзахдаа нас хүйсээр ялгаварладаггүй. Хүнд учир шалтгааныг мэдэх хүсэл эрмэлзэл байна уу, эсвэл биеийн амрыг харж, аргацаагаад явахыг илүүд үзэж байна уу гэж л шинждэг. Үнэхээр сурч мэдэх сонирхол байвал хэлээд өгье, ойлгохгүй байвал тайлбарлаад заая, би ч гэсэн мэдэхгүй бол хамтдаа суралцъя гэж ханддаг.

“Реформ хийх аргачлал” ном бол миний магистрын дипломын ажил дээр суурилсан бүтээл. Би судалгааны ажлаа Монгол Улсын макро эдийн засгийн хэлбэлзлийг хэрхэн бууруулах вэ гэдэг сэдвээр хийсэн юм. Түүхийг эргэн харвал манай улсын эдийн засаг 1990-1993 оны хооронд хямралд ороод буцаж 1989 оны ►



Ховд аймгийн Мөнххайрхан уулын ноён оргилд (2010)

► түвшиндээ хүрэхийн тулд 14 жилийг зарцуулсан. 1989 оны түвшиндээ 2004 онд хүрсэн гэсэн үг. Үнэхээр чадвартай, чадалтай эдийн засагчдын баг байсан бол ийм олон жилийг алдахгүй байсан гэж боддог. Энэ уналтыг зөвхөн эдийн засаг дээр биш, олон мянган хүн аж амьдралаараа төлсөн нь туйлын харамсалтай.

-Та “Шинэ Сэргэлтийн Бодлогын Хурдасгуур Төв”-ийн захирлаар ажиллах хугацаандаа ямар зарчим барьж ажиллав? Ямар ажил хийж бүтээсэн талаар танилцуулна уу?

-Улс орон үндэслэл нотолгоогүй бодлого гаргавал доороо хий эргэдэг. Үндэслэл нотолгоог цээжний пангаар мэдэх боломжгүй. Чихэн дээр цэцэг ургуулж хүнийг ятгаж болох ч асуудлыг шийдье гэвэл яахын аргагүй нэн тэргүүнд тухайн асуудлыг үүсгэж буй учир шалтгааныг нь зөв оношлох ёстой. Зөв бодлого гаргахын тулд нэгдүгээрт, асуудлаа зөв оношилж тодорхойлсон уу, хоёрт хэдэн шийдэл боловсруулж болох вэ, гуравдугаарт эдгээр шийдлээс амьдрал дээр аль нь амжилттай хэрэгжиж чадах вэ гэдгийг алдалгүй тооцоолох ёстой.

Ингэж тооцохдоо хэрэгжүүлэгч байгууллага тэрхүү бодлого, шийдлийг үнэхээр хэрэгжүүлж чадах уу, улс төрийн дэмжлэг авч чадах уу, санхүүжилт нь шийдэгдэх үү зэрэг олон зүйлийг авч үзэх ёстой. Төр хэр чадамжтай байна, энэ чадамжийг хэрхэн илүү бүрдүүлэх вэ гэдэг асуудалд бид зайлшгүй анхаарах ёстой. Энэ бол төр хүчтэй, хүчгүй, эсвэл том, жижиг байхын асуудал биш юм. Хамгийн чухал нь төр чадамжтай байх ёстой. Мөн энэ бол ямар ч компанид хамаатай асуудал.

Хурдасгуур төвд бид төрийг чадамжтай болгох, олон ажил хийсний дотор төрийн байгууллагын чадамжийг сайжруулах ажлуудыг нэрлэж болно. Нэг салбарт процессийн дахин инженерчлэл хийсэн. Төрийн чадамжийг бүрдүүлэх чиглэлийн сургалтыг Харвардын хөтөлбөрөөс буулгаж, Удирдлагын академид нутагшуулахыг зорьсон. "Шинэ сэргэлтийн бодлого"-д тусгасан Түгжрэл, эрчим хүч зэрэг бусад чиглэлээр судалгаа хийж, үндэслэл нотолгоо гаргахаас гадна хэрэгжүүлэлтийн шатанд тулгарах хүндрэлийг оношилсон.

Монголдоо ажиллавал дараачийн үедээ олон боломжийг бий болгож чадна гэж итгэсэн учраас эргэж ирсэн

-Улаанбаатар хотод тулгарч байгаа түгжрэлийн талаар ямар ажил хийв?

-Улаанбаатар хотын бүх уулзвар, тэмдэглэгээтэй симуляц загварыг гаргаж, ерөнхий боловсролын сургуулиудаас хамаарах түгжрэлийн хувийг тооцсон гээд хэд хэдэн ажлыг Хурдасгуур төв гүйцэтгэсэн. Түгжрэл нь нийт зорчилтын тоо, зорчилтын төрөл буюу авто машин, нийтийн тээвэр, мөн нийт дэд бүтцийн багтаамж болох замын уртаас хамаарч байгаа юм. Улаанбаатарт нийт 1200 км урт зам, 90 км урт дугуйн зам бий. 700 мянган машин бүртгэлтэй бөгөөд өдөрт 150-300 мянган машин хөдөлгөөнд оролцдог.

Мөн зорчих төрлүүдээр авч үзвэл нийслэлийн иргэдийн 40 орчим хувь ажилдаа очих, 20 гаруй хувь нь сургууль цэцэрлэгт хүүхдээ хүргэх, 10 гаруй хувь нь үзвэр үйлчилгээ авахаар зорчдог гэсэн судалгаа гарсан. Мөн замын хөдөлгөөнд оролцож байгаа машины тоо хэдэн хувиар өсөхөд дундаж хурд хэр хэмжээгээр буурч байгааг симуляц загвараар тооцож гаргасан. Энэ бүхнийг задлаад харахаар маш олон хүчин зүйл замын түгжрэлд нөлөөлж байгаа.

Хүн болгон машин авч чадах ч иргэн зам барьж чадахгүй. Компани зам барьж чадах ч дангаараа цахилгаан станц барьж чадахгүй. Тиймээс зарим зүйлийг төр л хийнэ. Төрийн цаана чухамдаа байгууллагууд бий бөгөөд тухайн байгууллагын чадамжийг сайжруулж байж л асуудлыг шийдвэрлэнэ.

-Улаанбаатар хотод бугшсан өөр нэг асуудал нь газартай холбоотой. Газрын асуудал нь түгжрэл, нийслэлийн бусад дэд бүтцийн хөгжилтэй шууд холбогдоно. Нийслэл хотын газрын асуудлыг шийдэх гаргалгаа юу байна вэ?

-Улаанбаатар хотод ажлын байр нэмэгдүүлж, өндөр цалинтай, өндөр бүтээмжтэй ажлын байр бий болгохын тулд газрын асуудлыг зайлшгүй шийдэх ёстой. Хурдасгуур төвийг удирдан хоёр жил гаруй ажиллахад Улаанбаатар хотын асуудал бүр газартай холбогдож байгаа нь харагдсан. Тухайлбал, Дулааны цахилгаан станц III-н хүчин чадлыг нэмэгдүүлж, шинэ зуух барья гэхэд цахилгаан станцтай зэрэгцүүлээд нэг хүн газрыг нь эзэмшсэн учраас газрын маргаантай ►

► байх жишээтэй. Эмнэлгийн эргэн тойрны газрыг хоосон үлдээсэн нь байгалийн гамшиг, дайн байлдаан тохиолдвол эмнэлгийн хүчин чадлыг хэд дахин нэмж, эдгээр газрыг хээрийн эмнэлгийн зохион байгуулалтад оруулах, нэмж өвчтөн хүлээж авах зорилготой байдаг. Гэтэл нэгдүгээр эмнэлэг, гуравдугаар эмнэлгийн хашаанд олон давхар барилгууд баригдаж, гэнэтийн осол тохиолдсон үед эмнэлгийн хүч чадлыг нэмэх боломжгүй болсон.

Улаанбаатарт дулааны шугам сүлжээнд холбогдсон 13 мянга орчим объект байдаг. Дулааны магистрал шугамын урт 370 км, дэд станц 297 бий. Эдгээрийн тоог нэмэгдүүлж, нэмж барихад газар хэрэгтэй. Хот дэд бүтцээ барих гэхэд газаргүй болсон эмгэнэлтэй нөхцөлд орсон. Эмгэнэл гэхээсээ илүү хариуцлагын хямралд орсон байна. Та санаж байвал Засгийн газрын ордны хажууд байсан балгас шахуу “Улаанбаатар таймс”-ийн газрыг дуудлага худалдаагаар 23.8 тэрбум төгрөгөөр “Таван Богд”-ын Ц.Баатарсайхан авч байсан. Үүн шиг бүх газрыг дуудлага худалдаагаар нээлттэй зарсан бол Улаанбаатар хот дэд бүтцээ өөрийн төсвөөс барих хангалттай мөнгө олох байж. Тиймээс ч “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг боловсруулахдаа төрийн бүтээмжийн сэргэлтийг оруулсны цаана төрийн чадамжийг сайжруулж, авлигыг цэгцэлье гэсэн гол санаа агуулагдаж байгаа.

“Газрын асуудал нь авлига, хээл хахуулийн уг үндэс, цаашлаад иргэдийн тав тухтай, эрүүл таатай орчинд амьдрах эрхийг хулгайлагч болсон. Эл ужиг асуудалтайгаа бид яваад л байх уу?”

–“Аэро сити”-г анх төлөвлөж байхад хүмүүс ойр хавийн газруудыг нь хэдэн зуун га-гаар авсан жишээ бий. Олон тулгуурт хоттой болох, дэд төвүүд барих талаар яригдаж байгаа ч мэдээлэлд ойр байснаар ойр хавьд нь газар эзэмшдэг болсон хүмүүсээс газраа яаж эргүүлж авах вэ гэдэг асуудал үүсэж байна. Төсөл нь эхлээгүй байхдаа бүдрээд байна шүү дээ.

Улс төрчдийн нэг алдаа бол асуудлаа бүрэн ойлгоогүй, учир шалтгаант нөхцөлийг нь тодорхойлолгүй шууд шийдэл гаргадаг нь юм. Гаднын сайн туршлага, шийдэл нь Улаанбаатар хотод, аль нэг дүүрэгт таарах уу, хэрэгжүүлэх

**Учир
шалтгааныг
уялдаа
холбооноос
ялгахын тулд
судалгаа
шаардлагатай**



нөхцөл нь манайд хэр бүрдсэн бэ гэдгийг бодох л ёстой.

Газрын асуудал нь нэгдүгээрт, мэдээлэл хэр нээлттэй байна вэ, хоёрдугаарт, дүрэм журмаа хэрхэн мөрдөж байна вэ гэдгээс шалтгаална.

Хамгийн их газар олгогдсон дүүрэг бол Хан-уул. Энэ дүүрэгт би бага насаа өнгөрүүлсэн. Манай 75-р сургуулийн гаднах хөлбөмбөгийн талбай дээр нэг зочид буудал, нэг орон сууц баригдсан. Энэ бүгд сургуулийн стандартыг зөрчиж газар олгосон нийслэл, дүүргийн тухайн үеийн засаг дарга нарын буруу. 20 жилийн дараа манай хүүхэд тоглох газар үгүй болсон. Ганц манай хүүхэд биш, маш олон хүүхэд хохирч байна. Ийм талбайтай байсан бол хөдөлгөөний дутагдалтай, жингийн илүүдэлтэй хүүхдүүд хэдээр буурах байсан бол гээд та бод доо.

Тэр үеийн газрын наймаатай холбогдсон дарга ►



Чарльз голын тэмцээний бэлтгэл (Бостон хот. 2013.10)

► нарт “би мэдээгүй, уучлаарай” гэж хэлэх ямар ч эрх байхгүй. Ганц Хан-уул дүүрэг биш, Баянгол, Сүхбаатар дүүрэгт ч газрын асуудал маш их. Явган хүний замгүй авто замууд тавьж, иргэд машинтайгаа зэрэгцээд явж байна. Ийм зам дээр хүүхдүүд бэртэж гэмтэж байна. Одоо хэдүүлээ үүнийг цэгцэлье. Улаанбаатар хотын өнөөдрийн асар олон асуудлын гол шалтгаан болсон газрын хуваарилалт М.Энхболд гэдэг хүний үед тавигдсаныг хүн болгон мэддэг. Манай үеийнхэн энэ завхралд цэг тавьж хариуцлага тооцох, нөгөө талаас бүх хүнд тэгш оролцох боломжийг хангасан схем бүрдүүлэх ёстой гэж боддог.

Өнгөрсөн дөрвөн жилийг харвал томоохон асуудлуудад хариуцлага тооцох ажлыг Ерөнхий Сайд Л.Оюун-Эрдэнэ эхлүүлээд явж байна. Үүнийг залуучууд бид дэмжиж, манайд нүүрлээд байгаа хариуцлагын хямралаас гарах ёстой.

**Төр хэр
чадамжтай
байна, энэ
чадамжийг
хэрхэн илүү
бүрдүүлэх вэ
гэдэгт бид
зайлшгүй
анхаарах
ёстой**

-Таныг эдийн засагч гэдгээр хүмүүс мэднэ. Харин улс төрийг хэр сонирхож байна вэ?

-Хөгжлийг түүчээлэх нь нэг хүний хийж чадах ажил биш. Мэдлэг чадвартай, хүсэл эрмэлзэлтэй залуучуудтай хамтарч байж хийнэ. Ардчилсан нийгэмд олуулаа нийлж хийхийн тулд намын тогтолцоонд нэгдсэний үндсэн дээр л хийх нь тодорхой. “Алсын Хараа 2050” бодлогыг та харвал монгол хүнийг дэлхийд өрсөлдөх чадвартай болгохыг л зорьж байгаа. Бүх л аав хүүхдэдээ бусдаас дутуугүй боломж олгох юмсан гэж боддог. Үүнийг улс үндэстний хэмжээнд авч үзээд монгол хүн аль ч улсын иргэнээс яавал дутуугүй амьдарч, ажиллаж болох вэ гэдгийг л гаргахыг зорьсон бодлого юм. Улмаар хөгжлийн бодлогыг газар дээр нь хэрэгжүүлэхийн тулд намд элсээд, улс төрд ороод явж байна. ►

► Улс төрд орохоосоо өмнө би их эргэлзсэн л дээ. Эргэлзсэн гол шалтгаан нь миний хүүхдүүд байсан. 2018 оны хүртэл би дан хувийн хэвшилд ажиллаж ирсэн. Гэтэл улс төр гэдэг бол надад шинэ зүйл, тэгээд ч орох юм бол цаг наргүй зүтгэж, хүүхдүүддээ зарцуулах цаг улам багасах юм байна гэж бодсон. Гэтэл би хүүхдэдээ унадаг дугуй унахыг зааж өгмөөр байдаг. Орой хичээл тараад ирэхэд нь өдөр юу болсныг нь зэрэгцэж суугаад сонсож, шөнө орных нь хажууд нь үлгэр уншиж өгмөөр байдаг. Их бодож гаргасан шийдвэр л дээ. Гэхдээ үнэхээр хөгжлийн талаар би сурч мэдсэн нь үнэн юм бол, энэ боломжийг ганц өөрийн хүүхдэд биш бүх монгол хүүхдүүдэд бүрдүүлэхийн тулд ажиллах ёстой гээд шийдвэрээ гаргасан.

-Таны хобби юу вэ? Тэр дундаа ямар ном унших дуртай вэ?

-Хобби гэвэл гэр бүлтэйгээ ууланд алхах дуртай. Долоо хоногт бараг 80 цаг ажилладаг болохоор би гэр бүлтэйгээ аль болох их цагийг өнгөрүүлэхийг, гэхдээ зурагтын урд биш агаар салхинд хамт байхыг их хичээдэг. Мөн оюутан байхдаа олимпын наадмын нэг төрөл болох сэлүүрт завиар хичээллэж байсан болохоор энэ спортыг Монголд хөгжүүлэх хүсэлтэй байдаг.

Номын тухайд дэлхий дахины ардчиллын үйл явц, ардчиллыг бэхжүүлэхэд ямар сорилтууд тулгарч байгаа талаарх номыг сүүлийн үед их уншиж байна. Энэ дундаас Фарийд Закариа,

**Монгол
хүн бүр
билиг оюун
төгөлдөр,
бодож
сэтгэхдээ
гүн байг**

Фрэнсис Фукуяма, Жаред Даймонд, Пиппа Норрис зэрэг алдартай хүмүүсийн номыг санал болгомоор байна. Би өөрөө орчуулгын нэлээд ном гаргасан. “Мөхөшгүй найдварын гал”, “Халуун хавтгай хавчигдмал дэлхий”, “Хятадыг 1 цагт” “Хүнд үеийн эдийн засаг” “Төрийн чадамжийг бүрдүүлэх нь” зэрэг номыг санал болгоё.

-Залуу хүний хувьд хүүхэд залууст юу гэж зөвлөх вэ?

-19 настайдаа би нэг жил Африкийн Уганда улсад сайн дурын ажил хийж, гудамжны хүүхдүүдэд мэргэжлийн боловсрол олгодог сургуульд багшилж байсан юм. Дараа нь Монголоор бол зах хязгаар аймагтаа орох Форт Портал хэмээх газарт ДОХ-ын улмаас эцэг эх нь нас барж, бүтэн өнчирсөн 500 гаруй хүүхдийг тэтгэдэг байгууллагад ажиллахдаа амьдрах оромж барьж өгдөг байлаа. Тэр үед бүтэн өнчин ах дүү дөрвөн хүүхдийнд очсоноо мартдаггүй. Хамгийн том нь найман настай, асарч харах нэг ч хүнгүй, хоолоо ч яаж хийхээ мэдэхгүй тэдэнд манай байгууллага хүнсийг нь авч өгч амьдрал залгуулдаг байсан. Тэдний гэрт нь очоод энэ хэдэн өнчин хүүхэд яаж амьдарна даа л гэж надад бодогдсон. Хамаатны хүмүүс нь тэднийг хөөж явуулаад газрыг нь дээрэмдэж авсан байсныг нь буцааж олж өгсөн. Хүн гэдэг бас их муухай амьтан юм даа гэдгийг тэр үйл явдлаас олж харсан.

Уганда улсад хоёр сая өнчин хүүхэд, Кампала хотод 10 гаруй мянган хүүхэд гудамжинд амьдарч байна. 21 дүгээр зуунд шүү дээ. Ингээд бодохоор Монгол Улсад маань асар их боломж, бололцоо байна. Өнөөдрийн түвшнийг Америк, Англитай харьцуулахад буурай мэт санагдавч дэлхийн 192 улстай харьцуулахад яг дунд нь яваа шүү гэдгийг захиж хэлмээр байна.

Мөн хөгжлийн шалгуур бол чинээлэг амьдралтай хүний хөрөнгийг хэр нэмэгдүүлснээр бус, харин амьжиргаа тааруу иргэдийнхээ амьдралыг хэр сайжруулснаар хэмжигддэг гэж би боддог. Тиймээс залуустаа “өөрөө амжилтад хүрч, алдарт гарсан бол аз жаргалын хаалгыг бусдадаа нээж өгөөрэй” гэж захимаар байна. Ачийг тань тэд бас бүү мартаг! Монгол хүн бүр билиг оюун төгөлдөр, бодож сэтгэхдээ гүн байг. ■



Уганда улсын Гүүд самаритан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн бага сургуульд (2004)

Бүтээл

“Өсөлтийн оношилгоо: Реформ хийх аргачлал” номын онцлох эшлэлүүд

Эдийн засагч Б.Дөлгөөн тус номоо Монгол Улс хөгжлийн бодит боломжоо бүрэн ашиглаж чадаж байна уу, үгүй бол ямар хүчин зүйлтэй холбоотой вэ гэдэгт хувь нэмрээ оруулах зорилго өвөртлөн бичжээ. Эл номын зарим онцлох эшлэлээс сонирхуулья.

✓ Өнөөдөр олон улсад хөгжлийг дөрвөн хэмжээсээр тодорхойлж, хэмжиж байна. Эдгээр нь эдийн засгийн хэмжээс, улс төрийн хэмжээс, нийгмийн хэмжээс, төр, захиргааны чадамжийн хэмжээс юм.

✓ Өрхийн орлогын өсөлт, бууралт мөн бодит орлого амьжиргааны түвшинтэй харьцуулахад хэр байна гэдэгтэй уялддаг. Хүмүүсийн орлого нэмэгдэнэ гэдэг нь тэдний бүтээмж өсөж буйг харуулсан үзүүлэлт юм. Бүтээмжээ өргөн хүрээнд нэмэгдүүлснээр эдийн засгийн хэмжээсээр улс орон хөгжиж байна гэж үздэг. Манай улс эдийн засгаа их хэмжээгээр тэлэх тусам энэхүү хэмжээсээр илүү хурдтай хөгжиж байна гэж ойлгох хэрэгтэй.

✓ Тухайн нийгэмд ямар гэр бүлд төрснөөс үл хамаарч хүн бүр байгалиас өгөгдсөн потенциалдаа ашиглах тэнцүү боломжтой байх тусам улс орон нийгмийн хэмжээсээр хөгжиж байна гэж үздэг. Та бидний хэн нь ч улс орон, газар нутаг, аав ээжийгээ сонгож төрдөггүй. Зайсан толгойгоос Долоон буудлын автобусны буудал хүртэл ердөө 10.5 км зайтай. Ердөө 10.5 км наана, цаана төрөхөд, ерөнхий боловсрол эзэмшихэд, тухайн хүн өөрт байгалиас заяасан потенциалдаа хүрч ажиллаж, амьдрахад ийм ялгаатай түвшнээс эхэлж байна.

✓ Олон улсад танигдсан Ланч Притчетт, Дани Родрик нарын эдийн засагчид улс орон суурь хүчин зүйлээ эхэлж сайжруулбал, хавсарга хүчин зүйлс дагаж сайжирна гэж таамагладаг. Энэ бол улс орны хөгжлийг чиглүүлэхэд тун хэрэгцээтэй таамаглал мөн. Чухам энэ таамаглал зөв бол улс орон өөрийн санхүүгийн болон бусад нөөцийг суурь хүчин зүйлээ сайжруулахад чиглүүлбэл хавсарга хүчин



зүйлс нь аяндаа дагаад сайжирна гэсэн үг. Аливаа хавсарга хүчин зүйл дээр анхаарч, маш их зардал гаргаж сайжруулаа гэхэд суурь хүчин зүйлс нь дээрдэхгүй бол мөнөөх нь дунд болон урт хугацаанд эргээд тухайн улс орны дөрвөн суурь хүчин зүйлийн түвшин рүү буурах эрсдэлтэй. Тиймээс Монгол Улс хязгаарлагдмал нөөцийг суурь хүчин зүйлс рүүгээ чиглүүлж, сайжруулах нь хамгаас чухал.

✓ Эдийн засгийн хэмжээсийг голчлон авч үздэгийн шалтгаан нь эдийн засаг бусад гурван суурь хүчин зүйлээс илүү чухал гэдэгт биш. Үүний цаана хэд хэдэн шалтгаан байгаагийн нэг нь улс орны эдийн засаг өссөнөөр Нийгмийн дэвшлийн индексийн гурван бүлгийн 53 хэмжээст нөлөөлөх нөлөө Монгол Улсын өнөөгийн нөхцөлд хамгийн өндөр байна гэсэн тооцоо юм.

✓ Эдийн засгийн өсөлт аль хүчин зүйлээс хамгийн өндөр хамааралтай байгааг Эдийн засгийн цогц байдлын индексээр (economic complexity index) хэмждэг. Тус индекс орон нутаг, улс гүрэнд буй мэдлэгийг тухайн орон нутаг, улс гүрний бүтээж байгаа бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээгээр төлөөлүүлэн тооцож буй хэмжих нэгж юм. Тэгэхээр эдийн засгийн цогц байдлын цаадах гол хэмжигдэхүүн нь тухайн улс орны мэдлэгийн түвшин юм.

✓ Хүмүүс ажилд орох шийдвэр гаргахдаа цалинг чухалчилдаг. Ажиллагсдын бодит цалин 2015 оноос хойш 14.7 хувиар өсжээ. Харин нэг ажилтанд ногдох ДНБ 71.4 хувиар өссөн. Тэгэхээр нийт эдийн засгийн өсөлтийн тун бага хувь нь ажилчдад хуваарилагдаж байгааг харуулж байна.

✓ Эдийн засгийн шинэчлэл хийх таван арга байдаг. Үүний хамгийн практик дээр амжилттай хэрэгжих, онолын хувьд үндэслэлтэй арга бол өсөлтийн оношилгооны арга юм. Өсөлтийн оношилгоо аргачлалаар тухайн эдийн засаг (улс орон, орон нутаг)-ийн өсөлтийг хамгийн ихээр хязгаарлаж буй хүчин зүйлийг тогтоодог. ■

Экспорт

Манай улсын мах, махан бүтээгдэхүүний экспортын хамгийн өндөр үзүүлэлт 276 сая ам.доллар

“Шинэ сэргэлтийн бодлого”-ын Аж үйлдвэрийн сэргэлтийн хүрээнд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг түүхий эдийн нөөцтэй уялдуулан боловсруулах, үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилт тавьсан. Нөгөөтгээгүүр, мах, махан бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх нэгдсэн стратеги боловсруулах, өрхийн мал аж ахуйгаас эрчимжсэн мал аж ахуй, кластерын хэлбэр рүү шилжин хөгжүүлэхийг дэмжих, олон улсын эрүүл ахуйн шаардлагыг хангасан брэнд бүтээгдэхүүн хөгжүүлэх, бүс нутгийн худалдаанд идэвхтэй оролцох зэрэг сорилтуудтай нүүр тулж байна. Дээрх асуудлыг шийдвэрлэх зорилгоор “Шинэ сэргэлтийн бодлогын хурдасгуур төв” УТҮГ-аас холбогдох судалгааны ажлыг гүйцэтгэсэн. Уг судалгаанд уул уурхайн бус экспортын голлох бүтээгдэхүүний нэг болох мах, махан бүтээгдэхүүнийг сонгон авч, мал аж ахуй, мал төхөөрөх, махны үйлдвэрлэл, экспортод гаргах үйл явцын зураглалыг гаргаж, тэдгээрийн хөгжлийн хязгаарлагч хүчин зүйлсийг тодорхойлохыг зорив.

Монгол Улсын Засгийн газраас 2016-2024 онуудад уурхайн бус нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх, малын эрүүл мэндийг хамгаалах, эрчимжсэн мал аж ахуй, хоршоог хөгжүүлэх, малчдыг чадавхжуулах зорилго бүхий “Малын эрүүл мэнд”, “Монгол мал”, “Монгол малчин”, “Монгол экспорт”, “Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр”, “Эрүүл мал”, “Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих” зэрэг хөтөлбөрийг баталсан. Эдгээр хөтөлбөрүүд хэрэгжиж эхэлсэн боловч, 2020-2022 онуудад дэлхий нийтийг хамарсан цар тахал, хөл хорио, нийлүүлэлтийн сүлжээний тасалдал, БНХАУ-ын Ковид-19-ын тэг бодлого болон импортын мах, махан бүтээгдэхүүнд тавигдах хүнсний аюулгүй байдлын стандарт шаардлагын шинэчлэл, малын гоц халдварт өвчний дэгдэлт зэрэг гадаад, дотоодын олон хүчин зүйлээс хамаарч манай улсын мах,

махан бүтээгдэхүүний экспортын түвшин буурсан (График 1). Харин 2023 оноос БНХАУ-ын хилийн боомтууд хэвийн горимд шилжсэнээр манай улс 2023 оны эхний 11 сарын байдлаар нийт 70.6 мянган тонн мах, махан бүтээгдэхүүн экспортолсноос үхрийн хөлдүү мах 185 тонн, хонь, ямааны мах 9 мянган тонн, адууны мах 30.2 мянган тонн, малын дайвар бүтээгдэхүүн 966.2 тонн, дулааны аргаар боловсруулсан мах (ДАБ) 30.1 мянган тонныг эзэлж байна. Тус хугацаанд нийт 275.7 сая ам.долларын мах, махан бүтээгдэхүүн экспортолж, үхрийн хөлдүү мах 752.7 мянган ам.доллар, хонь, ямааны мах 31.2 сая ам.доллар, адууны мах 116 сая ам.доллар, малын дайвар бүтээгдэхүүн 1.2 сая ам.доллар, ДАБ 126.4 сая ам.долларт хүргэсэн. (График 2) Дээрх үзүүлэлт манай улсын мах, махан бүтээгдэхүүний экспортын түүхэн дэх хамгийн өндөр үзүүлэлт бөгөөд экспортын бүтээгдэхүүний нэгж тутмын үнэ өсөж байгааг илтгэж байгаа юм. 2023 оны эцэс гэхэд мах, махан бүтээгдэхүүний экспорт 300 сая ам.долларт хүрэх төлөвтэй байна. ►

График 1. Мах, махан бүтээгдэхүүний экспортын хэмжээ, төрлөөр



** 2023 оны эхний 11 сарын статистик үзүүлэлт

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

► Манай улс илүү тогтвортой, олон тулгуурт эдийн засгийн өсөлтийг дэмжихийн тулд 71 сая толгой малыг эдийн засгийн эргэлтэнд оруулж, хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, худалдааны түншлэлийн харилцааг сайжруулах, экспортын орлогыг нэмэгдүүлэх бүрэн боломжтой. Бид судалгаандаа Япон улсын судлаач Ишикавагийн “Шалтгаан ба үр дагаврын диаграмм” аргачлалыг ашиглан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортын үйл явцыг гурван бүлэгт ангилан, бүлэг тус бүрээр экспортын хязгаарлагч хүчин зүйлсийг тодорхойлов (График 9.3).

График 2. Мах, махан бүтээгдэхүүний экспортын мөнгөн дүн, төрлөөр



** 2023 оны эхний 11 сарын статистик үзүүлэлт

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

График 3. Мах, махан бүтээгдэхүүнийг экспортод гаргах үйл явцад үүсэж буй хязгаарлагч хүчин зүйлс

Малыг махны чиглэлээр бэлтгэх үйл явц	Мах бэлтгэл, боловсруулах үйл явц	Мах , махан бүтээгдэхүүнийг олон улсын зах зээлд гаргах үйл явц
- Малын идэш тэжээл цаг агаарын байдлаас шууд хамааралтай учир хур тунадас бага жилд хомсдолтой байдаг - Малын гоц халдварт өвчний тархалт, вакцинжуулалттай холбоотой асуудлууд - Мал сүргээ махны чиглэлээр тусгайлан бэлддэггүй тул сүрэг сэлгэх, селекцийн асуудлууд - Махны нийлүүлэлт улирлын чанартай учир тогтвортой бус - Зарим нутагт бэлчээрийн даац хэтэрсэн тул отор газрын маргаан их байдаг - Малын бүртгэл, мөшгих систем хэвийн ажилладаг хэдий ч хэрэглэгчийн талаас тухайн мэдээллийг шаардах шаардлага бага байдаг - Орон нутагт мал эмнэлгийн шинжилгээний лаборатори, малын эмч нарын хүрэлцээ муу - Малаа тээвэрлэхэд тээврийн стандарт дүрэм журам дагадаггүй.	- Махны ченжүүд махаа уламжлалт буюу гар аргаар боловсруулахыг илүү үздэг учир боловсруулах үйлдвэрийн ашиглалтын хувь бага байдаг. - Бүрэн стандартад нийцсэн мах боловсруулах үйлдвэрийн тоо цөөн - Үйлдвэрийн үйл ажиллагааны ариун цэврийн хяналт сул, мэргэжлийн байгууллагын хяналт шалгалт танилын хүрээнд явагддаг - Мах, махан бүтээгдэхүүн хөлдөөх, гүн хөлдөөх агууламж дутмаг - Хөргүүртэй мах тээвэрлэх машины тоо цөөн, өртөг өндөр байдаг - Шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэхэд зах зээлийн судалгаа, өндөр тоног төхөөрөмж, технологи шаардлагатай.	- Экспортлогч орны тавигдах шаардлага, бичиг баримт, шинэчлэгдсэн стандарт, дүрэм журмын талаар мэдээлэл ил тод бус байдаг - Экспортын зөвшөөрөл буюу квот олгох үйл явц тухайн үйлдвэрийн төлөвлөгөө, холбогдох журмын дагуу бус танилын хүрээнд ил тод бус явагддаг - БНХАУ-ын Гаалийн Ерөнхий газраас Монгол Улсад ирж хяналт шалгалт хийхдээ шалгалт хийх үйлдвэрийн тоонд хязгаар тогтоодог. - Хил гаалийн хяналт, хорио цээрийн хяналтад зарцуулдаг цаг багасч байгаа мөн цаашид багасгах боломжтой - Монгол махыг олон улсад сурталчлах, гадаад хамтрагчтай худалдааны гэрээ хийх мэргэжилтэн дутмаг.

► Мах, махан бүтээгдэхүүний экспортын хязгаарлагч хүчин зүйлсийн үүсэх шалтгааныг нарийвчлан судалсны үр дүнд дараах арга хэмжээг нэн тэргүүнд хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзлээ.

1. Зарим эрх бүхий байгууллагад чиг үүргийн шинжилгээ хийх

Мал сүргийн эрүүл мэндийг хамгаалах, олон улсын шаардлагад нийцсэн зохистой байдлаар малаа төхөөрөх, ариун цэвэр, эрүүл ахуйн олон улсын стандарт шаардлагад нийцүүлэн мах, махан бүтээгдэхүүнийг боловсруулах нь тогтвортой махны экспортын үндэс билээ. Гэвч дотоодын болон олон улсын судалгаа, шинжилгээний материал, тайлан, гарын авлагуудад үйлдвэрлэлийн гинжин хэлхээний үе шатанд эдгээр стандартыг дагаж мөрддөггүй, мөн мэргэжлийн байгууллагын хяналт, шалгалтын үйл

Шигтгээ 1.

Ковид-19 цар тахлын дараа махан бүтээгдэхүүн хэрэглэгчдийн зан төлөв өөрчлөгдөж байна.

2023 онд “McKinsey&Company”-аас гаргасан хэрэглэгчдийн зан төлөвийн судалгаанд Их Британи, ХБНГУ, АНУ-ын хэрэглэгчид мах, махан бүтээгдэхүүн худалдан авахдаа махны үнэд хамгийн их ач холбогдол өгдөг бол БНХАУ-ын хэрэглэгчид махны үнэ, амт чанар, тогтвортой нийлүүлэлтээс илүү махны гарал үүсэл, хүнсний эрүүл, аюулгүй байдлыг анхаарч худалдан авалт хийдэг. Мөн хэрэглэгчдийн дийлэнх хувь нь ресторанд хооллохыг илүүд үздэг тул хөлдөөсөн махны хэрэглээ ирэх жилүүдэд 8 хувиар өсөх хандлагатай байна. Эндээс дүгнэхэд, Хятадын хэрэглэгчдийн худалдан авах чадвар сайжрахын зэрэгцээ хөдөө аж ахуй, аж үйлдвэрийн салбар хөгжсөн улс орнуудын Хятадын зах зээлд өрсөлдөхүйц үнэтэй, чанартай мах, махан бүтээгдэхүүн нийлүүлэх өрсөлдөөн улам ширүүсэж байна. Хятадын хэрэглэгчид малын гарал үүсэл, эрүүл ахуйн аюулгүй байдалд ихэд анхаарал хандуулж, цаашид бэлчээрийн гаралтай, органик хөлдөөж бэлтгэсэн үхрийн махыг илүү худалдан авах хандлагатай байна. Мөн тэд эдгээр шаардлагыг бүрэн хангаж байгаа мах, махан бүтээгдэхүүнд мөнгөө зарцуулахад бэлэн байна. Харин бид бэлэн үү?

ажиллагаа хангалтгүй байгаа талаар тусгасан байдаг. Байгууллагын чиг үүргийн шинжилгээ хийснээр, давхардах эсхүл алдагдаж буй албан үүргийг бодитоор тодорхойлох, үнэлгээ өгөх, байгууллага хоорондын уялдаа холбоо, үйл ажиллагааг сайжруулах санал, зөвлөгөө боловсруулах боломжтой болдог. Иймд мал эмнэлгийн хяналт шинжилгээ хийх үүрэг бүхий байгууллагуудад чиг үүргийн шинжилгээ хийж мэргэжлийн байгууллагын мэргэжилтнүүдийн ур чадвар, хөдөлмөрийн бүтээмжийг бодитоор тооцох нь зүйтэй гэж үзэж байна. Мөн тэдгээр байгууллагын хяналт шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтүүдийг боловсронгуй болгох, чиг үүрэг, дүрэм, журмын хэрэгжилтийг хангуулах, мэргэжилтнүүдийн чадавхыг бэхжүүлэхэд анхаарч ажиллах шаардлага үүсэж байна.

2. Махны маркетинг хөгжүүлэлтийг хариуцсан нэгж байгуулах

“McKinsey&Company”-аас гаргасан олон улсын хэрэглэгчдийн зан төлөвийн судалгаагаар хөгжингүй орны хэрэглэгчид бэлчээрийн маллагаатай, органик бордоогоор бордсон, антибиотик, нэмэлт бодис тариагүй малын махыг худалдан авахыг илүүд үзэж байна гэсэн дүгнэлт гарсан. Манай улс нүүдэлчин өв соёлтой, бэлчээрийн уламжлалт мал аж ахуй эрхэлж генийн өөрчлөлтгүй, органик бүтээгдэхүүн бэлтгэдэг харьцангуй давуу чанараа ашиглан олон улсын зах зээлд мах, махан бүтээгдэхүүнийг үнэ цэнд хүргэх бүрэн боломжтой. Монголын бэлчээрт 2,800 гаруй төрлийн ургамал ургадгаас 800-аад дээд зүйлийн ургамлыг мал иддэг гэсэн эрдэмтдийн судалгаа бий. Иймд манай улсын брэнд бүтээгдэхүүн хөгжүүлэх, маркетингийн сүлжээ, бизнесийн түншлэл бий болгох чиг үүрэг бүхий нэгжийг байгуулан холбогдох мэргэжлийн холбоо эсхүл харьяа төрийн байгууллагын үйл ажиллагааны чиг үүрэгт нэгтгэн оруулах нь зүйтэй гэж үзэж байна.

3. Махны экспортын дунд хугацааны бодлого боловсруулан хэрэгжүүлэх

Ковид-19 цар тахлын дараа улс орнууд ногоон, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон ухаалаг хөдөө аж ахуйн хөгжлийн бодлогыг боловсруулж байна. Хөгжиж буй орнууд хөдөө аж ахуйн салбарын экспортын дунд хугацааны бодлогыг хэрэгжүүлж, бодлогын засаглалын залгамж халааг сайн хангаж чаддаг учир гадаадын хөрөнгө оруулагчдын найдвартай түнш болж чаддаг.

Манай улсын хувьд мах, махан бүтээгдэхүүнийг ►

▶ олон улсын стандартын дагуу бэлтгэн боловсруулах, худалдааны шинэ чиглэл бий болгох, бүтээгдэхүүний нэр төрлөө төрөлжүүлэх, экспортын хэмжээг нэмэгдүүлэх зорилго бүхий нэгдсэн бодлогын баримт бичиг боловсруулах, хэрэгжүүлэх шаардлага үүсээд байна. Энэ хүрээнд “Шинэ сэргэлтийн бодлогын хурдасгуур төв” УТҮГ-аас мах, махан бүтээгдэхүүний экспортын дунд хугацааны хөгжлийн бодлогын төслийг боловсруулсан. Экспортын нэгдсэн бодлого байхгүй тохиолдолд махны үйлдвэр, мах бэлтгэгч аж ахуй нэгжүүдэд ирэх жилүүдийн бэлтгэн нийлүүлэлт, үйлдвэрлэлийн төлөвлөгөө гаргахад хүндрэлтэй байдал үүсэх, цаашлаад гадаадын хөрөнгө оруулагчдын хөдөө аж ахуйн салбарт хөрөнгө оруулах сонирхол буурах зэрэг сөрөг нөлөөтэй.

Монголын уламжлалт аж үйлдвэрийн салбар нь хөдөө аж ахуйн нөөц, хүний нөөц, санхүүгийн нөөц, хөрөнгө оруулалт болон худалдааны чадамжаас шууд хамааралтай

Шигтгээ 2.

БНХАУ-ын ӨМӨЗО-ны Тунляо аймгийн махны үхрийн аж ахуй

БНХАУ-ын ӨМӨЗО-ны Тунляо аймаг нь сүүлийн 10 жилийн хугацаанд махны чиглэлийн үхрийн аж ахуйг хөдөө аж ахуйн тэргүүлэх салбар болгон хөгжүүлж, орон нутгийн ДНБ-ий 20 хувийг бүрдүүлдэг. Чингэхдээ дан ганц мал аж ахуйн салбарыг хөгжүүлээд зогсохгүй үр тариа, малын тэжээлийн тариалалтыг орхигдуулалгүй хөгжүүлсэн. Орон нутгийн засаг захиргаа малын тэжээл, үржил шим, таргалалтаас эхлээд мах боловсруулах, эцсийн бүтээгдэхүүнээ тээвэрлэх хүртэл үйл ажиллагааг сайжруулах олон тооны төсөл хөтөлбөр хэрэгжүүлсэн. Жишээлбэл, орон нутгийн засаг захиргаанаас махны чиглэлийн өндөр ашиг шим бүхий үхрийн үржил селекцын ажлыг хариуцан зохион байгуулж, 160 мянган малын гүн хөлдөөсөн үрийг үнэ төлбөргүй олгосноор 62 мянган үхэр хээл авч, 37 мянган тугал төрсөн. Мал аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлэх тогтвортой хөтөлбөр хэрэгжүүлснээр Хорчин суманд 2018 оноос 2022 оны хооронд махны чиглэлийн үхрийн тоо 166 мянгаас 407 мянга, үхрийн мал аж ахуй эрхлэгчдийн тоо 15 мянгаас 30 мянга, хоршоодын тоо 200-аас 400 болж нэмэгдсэн бодит үр дүн гарсан.

Шигтгээ 3.

Австрали улсын махны экспортын зах зээлийн хөгжил

Австрали улсын мал аж ахуйн салбар нь бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг хослуулсан 200 гаруй жилийн түүхтэй. Дэлхийн үхрийн тоо толгойн 1.5 хувь, хонины 5 хувь тус оронд байдаг. 2021 онд махны экспорт тус улсын нийт экспортын 3.7 хувийг эзлэн амьд малын болон махны экспорт 14.6 тэрбум ам.долларт хүрснээс түүхий мах, боловсруулсан мах, махан бүтээгдэхүүний экспорт 13 тэрбум ам.доллар, амьд малын экспорт 1.6 тэрбум ам.долларт хүрсэн байна. Австрали, Хятад нь худалдааны найдвартай түнш орнууд бөгөөд Австралиас мах, махан бүтээгдэхүүн Хятад руу экспортлоход гаалийн татвар төлдөггүй байна. Мөн Хятад улс нь Австрали улсын гуравдахь том үхрийн мах импортлогч, хоёрдахь том хурганы мах импортлогч, хамгийн том хонины мах импортлогч орон юм. Австрали улсын махны экспорттой холбоотой цогц мэдээлэл, гарал үүслийн баталгаа, шаардлагатай маягт хуудаснууд, экспортын зарим статистик мэдээллийг Хөдөө аж ахуй, загас агнуур, ойн яамны албан цахим хуудаснаас авахад маш хялбар байдаг. Мөн мах импортоор авдаг улс орнуудын эрүүл ахуй, хорио цээрийн шаардлагын дэлгэрэнгүй мэдээлэл (улс орон, бүтээгдэхүүн тус бүрээр), импортлогч оронд мөрддөг хууль дүрэм, журам, холбогдох акт, стандартууд, импортын тариф зэрэг мэдээллийг бүрэн эхээр авах боломжтой.

байдаг. Түүхий эдийн бэлтгэлийн сүлжээ өрсөлдөөний зарчмаар ажиллаж байж хөдөө аж ахуйн нөөцийг гүйцэт ашиглах боломж бүрддэг. Манай улсын хувьд ногоон, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон ухаалаг хөдөө аж ахуйн хөгжлийг дэмжихийн тулд одоогийн үйлдвэрлэлийн технологи, нөөцийн удирдлагын арга барилыг сайжруулах хэрэгтэй. Мөн мал сүргийн эрүүл мэндийг сайжруулах, бэлчээрийн хяналт, зохицуулалт, малын тэжээл, малын дайвар бүтээгдэхүүний менежмент зэрэгт Засгийн газрын түвшинд анхаарч ажиллах шаардлагатай байна. ■

Дэлхий Монголыг онилно

Азийн үнэ
цэнтэй
аялагчдад
зориулсан
бодлого
барина

“CNN” сувгаар 2023 оны гуравдугаар сараас арваннэгдүгээр сар хүртэл Монгол Улсын аялал жуулчлалын талаар 17 удаа контент нэвтрүүлжээ. Харин “Lonely Planet” сэтгүүлийн аялал жуулчлалын мэргэжилтнүүд 2024 онд Монгол, Шотланд, Филадельфи, Парис болон Австралийн Кенгуру арлыг “Заавал аялах ёстой газар” хэмээн онцлов. Дээрх жишээ Монгол Улс дэлхийн аялал жуулчлалын хөгжил, трендээс хоцроогүй, харин ч “мода”-нд орж байгааг илтгэж байна.

Аялал жуулчлалын салбарынхан Ковидын үеийн ангал мэт уналтыг 2023 онд амжилттай даван туулж, хамгийн хурдан хэвийн үйл ажиллагаанд орсон салбар болов. Монгол Улсын түүхэн дэх 2019 оны хамгийн өндөр үзүүлэлт болох 577 мянган гадаадын жуулчид хүлээн авсан босго тоог 2023 онд 600 гаруй мянгад хүргэж, эдийн засагт 3.4 их наяд төгрөгийн орлого орууллаа. Аялал жуулчлалын компаниуд нэгдэн нийлж, кластер үүсгэж өөрсдөө зорилтот зах зээлийнхээ бодлогод оролцож эхэлсний үр дүнд олон ажлын байр шинээр бий болж, дагах үйлчилгээнүүдийн ашиг орлого нь нэмэгдсэн байна. Тухайлбал, МИАТ 2023 оны эхний хагас жилийн байдлаар 336.9 тэрбум төгрөгийн орлого олж, 313.9 тэрбум төгрөгийн зардал гарган, 23 тэрбум төгрөгийн татварын өмнөх ашигтай ажиллажээ. Харин 2023 оны эхний хагас жилийн байдлаар аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүд 63.6 тэрбум төгрөгийн татвар төлсөн байна. Энэ нь Монгол Улсыг зорин ирэх гадаадын жуулчид нэмэгдсэнийг баталж байна.

Аялал жуулчлал нь манай улсын стратегийн үндсэн салбарын нэг. Тиймээс Монгол Улсын Засгийн газраас 2023, 2024, 2025 оныг “Монголд зочлох жил” болгон зарлаж, эхний нэг жилд нэг сая жуулчин хүлээн авах маркетингийн зорилт дэвшүүлсэн. Зорилтын хүрээнд визний хөнгөлөлт чөлөөлөлт, агаарын тээврийн нислэгийн харьцангуй чөлөөт бодлого, гадаадын

жуулчдад зориулсан татварын буцаан олголт зэрэг холбогдох хууль, эрх зүйн зохицуулалт хийсэн нь эерэг үр дүн авчирлаа.

Аялал жуулчлалын салбарын 2023 оны төсөв 4.9 тэрбум төгрөг байсан бол 2024 оны төсөв даруй 2.5 дахин нэмэгдэж 12.8 тэрбум төгрөгөөр батлагдсан. Энэхүү төсөв нь салбарын гол үйл ажиллагаа болсон аялал жуулчлалын эвентүүд болон гадаад сурталчилгаанд зориулагдах аж. Тодруулбал, Улаанбаатар хот руу хамгийн ойроос ирж болох онгоцны нислэгтэй орнууд болон хил орчмын аялал жуулчлалд илүү төвлөрөх юм байна. Иймд эдгээр орнуудаас үндэснийх нь ▶



◀ Эрхэм таныг урьж байна

► нөлөөлөгч болон томоохон компаниудыг урьж маршрутын дагуу аялуулах “фам тур”-д илүү анхаарал хандуулах юм. Холын, үнэтэй нислэгтэй орнуудаас илүүтэй Азийн үнэ цэнтэй аялагч нарт зориулсан бодлогыг илүү баринагэдгийг БОАЖЯ-ны Аялал жуулчлалын бодлого, зохицуулалтын газрын дарга В.Батчимэг онцоллоо.

“Нэг хонь”, “Нэг ямаа” төсөл хэрэгжинэ

Аялал жуулчлалын салбар 2024 онд нэг сая жуулчин хүлээн авч, зургаан их наяд төгрөгийн орлоготой байх урьдчилсан тооцоо гарчээ. 2023 онд салбарын хэмжээнд аялал жуулчлалын 69 эвент зохион байгуулсан бол 2024 онд энэ тоо хоёр дахин нэмэгдэж, нийт 125 эвент зохион байгуулахаар БОАЖЯ, Соёлын яам хамтран шинэ оны төлөвлөгөө баталжээ. Түүнчлэн аялал жуулчлалын салбарын улирлын хамаарлыг багасгах зорилгоор өвлийн аялал жуулчлалыг бодлогоор дэмжиж, хөгжүүлэхээр ажиллаж

байна. Цаашдаа дэлхий дахинд өөрийн өвөрмөц ондоошил, ялгарал бүхий бүтээгдэхүүн үйлчилгээг жилийн аль ч улиралд үзүүлж болох арга хэмжээг тэд төлөвлөжээ. Тодорхой бүс нутгуудыг илүү онилж тэдгээр орноос ирэх хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээг мэдэрсэн аяллын бүтээгдэхүүнүүд хөгжүүлнэ. Тухайлбал, “Нэг хонь” төслийг Булган аймагт, “Нэг ямаа” төслийг Архангай аймагт хэрэгжүүлж, БНСУ-ын зах зээл дээр сурталчилж хөгжүүлэх дижитал технологийн системийг нэвтрүүлэх юм. Жуулчин ирээд хонь, ямааг үрчилж авах, эзэн нь болох өөрийн хонь ямаагаар дамжуулан бусдадаа сурталчилгаа хийх давуу талтай. Мөн тэдэнд хонь, ямаанаас нь авах ноос, ноолууран бүтээгдэхүүнийг эргүүлээд бэлэглэх, худалдах зэрэг ач холбогдолтой аж.

2023 оны тавдугаар сард “Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулга”-ыг УИХ баталсан. Энэхүү хуулийн дагуу аялал

2024 онд нэг сая жуулчин хүлээн авч, зургаан их наяд төгрөгийн орлого олно



“Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл-II”-ыг Баян-Өлгий, Увс, Ховд аймгуудад хэрэгжүүлнэ

► жуулчлалын салбарын бүхий л үйл ажиллагаа шинэ бодлого, стандарт, төлөвлөгөөний дагуу хэрэгжиж байна. Аялал жуулчлалын байгууллагууд чиглэл бүрээр дор бүрнээ ажилладаг байсан бол Аялал жуулчлалын мэргэжлийн холбоог нийтийн эрх зүйн статустай байгуулснаар салбарын аж ахуйн нэгжүүдийг нэгтгэх, нийлж бодлогоо тодорхойлдог систем рүү нь чиглүүлж эхэлсэн. Зах зээлүүд төрөлжиж нэг нэгэнтэйгээ өрсөлдөхөөс илүүтэй нийлж хөгжүүлдэг тогтолцоо руу шилжсэн байна. Мөн салбарын бизнес эрхлэгч нарыг сургах, мэргэшүүлэх, кластер үүсгэх боломж бололцоог олгож эхэлснээр жуулчдад үзүүлэх үйлчилгээний чанар хүртээмж сайжрах юм. Мөн бизнес эрхлэгчид хүний нөөцөө бэлдэхийн тулд шинэ санаачилга гаргаж байгаа нь идэвх сэргэж, урам зоригтой байгаагийн илрэл юм. Тухайлбал, жилдээ 100 гаруй оюутан энэ салбарыг сонгож элсдэг байсан бол 400 сая төгрөгний тэтгэлэгтэй оюутан хөтөлбөр зарлагдсан цагаас эхлэн энэ тоо 500 гаруй болж нэмэгджээ.

Төрөөс аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлогын хүрээнд “Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл-I”-ийг Хөвсгөл, Хэнтий аймагт хэрэгжүүлсэн. Салбарын хүний нөөцийг бэлтгэх, чадваржуулах ажлын хүрээнд БНСУ-ын Аялал жуулчлалын байгууллагын буцалтгүй тусламжаар сургалтын төв байгуулжээ. Мөн “Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл-II”-ыг Баян-Өлгий, Увс, Ховд аймгуудад хэрэгжүүлэх бөгөөд төслийн ТЭЗҮ-г боловсруулж байна. Түүнчлэн “Дэлхийн адал явдалт аялал жуулчлалын холбоо”-ныхон тусгай хамгаалттай газар нутагт хэрэгжүүлэх аяллын бүтээгдэхүүний стратеги төлөвлөлт, сургалт, судалгаа, хүний нөөцийн бодлогын баримт бичгийг боловсруулахад хамтарч ажиллах хүсэлт ирүүлсэн байна.

Дэлхийн хэвлэл мэдээлэлд

“Ethical Traveler” олон улсын судалгааны байгууллагаас “Дэлхийн шилдэг 10 ёс зүйтэй аялал жуулчлалын бүс нутаг” судалгааны 2023 оны тайланг танилцуулсан. Тус байгууллага 15 дахь жилдээ 200 орчим улс орныг хамруулан уг судалгааг хийжээ. Тэд нийгмийн халамж


болон амьтан хамгаалал, хүний эрх, байгаль орчны хамгаалал гэсэн дөрвөн хүчин зүйлсийг голлож, Дэлхийн банкны судалгааг эх сурвалжаа болгосон байна. “Дэлхийн 10 ёс зүйтэй аялал жуулчлалын бүс нутаг”-ийг Барбадос тэргүүлж, араас нь Белиз, Ботсван, Кабо Верде, Чили, Коста Рика, Монгол, Палау, Сейшелийн арлууд, Тимор оржээ.

Тэд Монгол Улсыг салхи исгэрсэн уудам говиос гайхамшигт Алтайн уулс хүртэлх онгон дагшин байгаль, зэрлэг амьтад, адал явдлын өлгий нутаг хэмээн онцлов. Ингэхдээ тархмал нүүдэлчдийн гэр, эртний сүм хийдэд нь зочилж, амар амгалан дунд уусахыг санал болгосон байна.


“Welcome to Mongolia” арга хэмжээний хүрээнд CNN, Financial Times, Washington Post зэрэг 40 гаруй дэлхийн томоохон хэвлэл мэдээллийн хэрэгслээр манай улсын тухай эерэг мэдээ, нийтлэл гарчээ. Мөн агаарын тээврийн либералчлалын бодлогын үр дүнд 2023 онд 40 гаруй улсын 150 чиглэлд нислэг хийх боломж бүрдсэн төдийгүй долдугаар сарын 1-нээс дотоодын нислэгүүдийг сэргээж эхэлснээс хойш нийт 32 мянган хүн тээвэрлэсний ихэнх нь гадаадын жуулчид байгаа юм. Бас нэгэн онцлох үйл явдал нь БНСУ-аас ирэх болон явах нислэг улам эрчимжиж гадаадын авиа компаниуд тус чиглэлд идэвхтэй оролцож эхэллээ. Мөн Монгол Улс, АНУ-ын хооронд шууд нислэг үйлдэх хэлэлцээр амжилттай хийгдэж, 2024 оны хоёрдугаар улиралд багтаан нислэг үйлдэх эхлэхээр болсон байна.

“World Travel & Tourism Council”-ийн (WTTC) судалгаагаар ирэх 10 жилд дэлхий даяар аялал жуулчлалын салбар эрчимтэй өсөн тэлэхээр байна. Энэ зун дэлхийн олон улсад онгоцны буудлууд жуулчдын хөлд дарагдсан нь салбарын цаашдын төлөвийг тодорхой илтгэж байлаа. Арван жилийн дараа аялал жуулчлалын салбар 15.5 их наяд ам.долларын зах зээл болж, дэлхийн эдийн засгийн 11.6-аас дээш хувийг эзлэхээр байгааг тус судалгааны байгууллага онцолжээ. Дэлхийн аялал жуулчлалын салбарын ирээдүйн ашигт шим Монголд “охь дээж”-ээ өгнө гэдэгт итгэлтэй байна. ■


Инфографик

Жуулчдын тоо
мянга


Эх сурвалж: YCX

Гадаадад зорчсон монгол жуулчид, хүн
мянга


Эх сурвалж: YCX

Улсын хилээр нэвтэрсэн гадаадын зорчигчдын тоо
мянга

Эх сурвалж: YCX


Гадаадын жуулчид, улсаар
мянга

Эх сурвалж: YCX

Улсын хилээр нэвтэрсэн зорчигчдын тоо
мянга

Эх сурвалж: YCX

Гадаадын зорчигчид, бүс нутгаар, хувь



Эх сурвалж: YCX

Аялал жуулчлал

Өмнийн говийн дундаршгүй үүц



Хөгжил дэвшилд хүрэх нэгэн жор нь төрөлхийн өгөгдөл юм. Өмнөговь бол уул уурхайгаас гадна аялал жуулчлалын арвин их өгөгдөлтэй аймаг. Монголд ирж байгаа жуулчдын 70-80 хувь нь Өмнөговь аймагт ирдэг гэсэн судалгаа бий. Тус аймаг үлэг гүрвэлийн мөрт Шар цав, Нэмэгт, эртний Цайны зам, Хүрдэт агуй, үлэг гүрвэлийн өндгийг анх олсон Баянзаг, үзэсгэлэнт Ёлын ам, Хонгорын элс, Говь Гурвансайхан, Галбын говь зэрэг дотоод гадаадын жуулчдыг соронздон татах олон “баялаг”-тай. Аймгийн ИТХ-ын дарга Н.Энхбат “Уул уурхай хөгждөгөөрөө хөгжиж, зам тээвэр, дэд бүтцээ сайжруулна. Гэхдээ манай аймгийг цаашид авч явах гол салбар бол аялал жуулчлал” гэж манай сэтгүүлд өгсөн ярилцлагадаа онцолсон.

Өмнөговь аймгийн удирдлага, салбар хариуцсан төрийн болон төрийн бус байгууллага, нутгийн ард иргэд сүүлийн жилүүдэд аялал жуулчлалын салбарт ихээхэн анхаарч, орон нутгийн төсвийн хөрөнгөөр томоохон бүтээн байгуулалт хийж байна. Тус аймаг 2023 оныг “Өмнөговьд зочлох жил” болгон зарлаж, “Нээлттэй Өмнөговь”, “Эх орон-миний говь” уриан дор 930 сая гаруй төгрөгийн бүтээн байгуулалтын ажлыг хийж байна.

Өмнөговь аялал жуулчлалын салбараа үндсэн гурван бүсэд хуваадаг. Эдгээрт хүрэх зам, цахилгаан, харилцаа холбооны сүлжээ зэрэг дэд бүтцэд сүүлийн жилүүдэд илүү анхаарч, хөрөнгө оруулж буй. Жуулчдын сонирхлыг ихээхэн татдаг баруун бүс нутгийн алслагдсан Хэрмэн цав, Нэмэгтийн хонгилыг “ойртуулахаар” Гурвантэс сум хүрэх хатуу хучилттай замыг барьж байна. Зүүн бүсэд Таван толгойгоос Ханги Мандалыг чиглэсэн хатуу хучилттай замыг барьж буй. Энэ зам зүүн бүсийн

**Монголд
ирж байгаа
жуулчдын
70-80 хувь
нь Өмнөговь
аймгаар
аялдаг**

аялал жуулчлалын хамгийн том кластер болох Шар цавын үлэг гүрвэлийн мөрт газраас гурван км-ын зайтай өнгөрнө. Эдгээр зам нь төвийн бүсээс баруун, зүүн бүсүүдэд аялал жуулчлалын хөгжлийг түгээх томоохон дэд бүтэц болох юм.

Аялал жуулчлалын нэг чухал бүтээгдэхүүн болох говийн ховор чухал биологийн төрөл зүйл, говийн булаг шандыг хамгаалах, нүүдлийн зэрлэг амьтдад зориулсан экологийн коридор нутгийг бий болгох зорилгоор Сэврэй, Баяндалай, Булган, Ханхонгор зэрэг сумдын булаг шандыг хамгаалах, орхигдсон худаг цооногуудад нарны өргүүр бүхий автомат төхөөрөмж суурилуулан усан сан үүсгэж байна. Булган сумын нутаг дахь Нүцгэний булгийн хамгаалалт нь Улаан номд бүртгэгдсэн борцгор хотонгийн нүүдлийн замыг тоссон томоохон бүтээн байгуулалт болжээ.

Түүнчлэн, улсын тусгай хамгаалалттай газрууд болон аялал жуулчлалын зорих газруудад отоглох цэг, аялал жуулчлалын мэдээллийн төв, нийтийн бие засах газар, хоол унд, кофешоп бүхий үйлчилгээний төвүүд байгуулж байна. Эдгээрээс Булган сумын иргэдийн байгуулсан “Баянзаг-Улалзах цонж” ТББ-ын мэдээллийн төвийн хамгаалалт, ашиглалт нь улсдаа үлгэр жишээ болохоор юм. Мөн Ази, Европыг холбосон алдарт Цайны замын ул мөр, бодит түүхэнд тулгуурлан олон улсын худалдаа арилжаа, соёлын харилцааг илэрхийлсэн тэмээн жингийн дурсгалын хөшөөг Баянзагт байгуулж байгаа нь аялал жуулчлалын нэгэн чухал үзмэр болно.

Японы Мичино-эки загварын халаалт, цахилгаан, цэвэр бохир усны сүлжээнд холбогдсон, нийтийн бие засах газар, хөнгөн хоол үйлдвэрлэл, “Булганд үйлдвэрлэв” брэнд бүтээгдэхүүний дэлгүүр, Булган сумын аялал жуулчлал, байгаль ▶

► орчны мэдээллийн төв бүхий нэгдсэн цогцолборыг байгуулахаар 600 сая төгрөгийн төсвийг батлаад байна. Ирэх жил ашиглалтад орох тус цогцолборын загвар зургаар бусад сумдад ийм цогцолбор барьж, орон нутгийн иргэдийн ТББ-д менежментийг нь бүрэн хариуцуулах аж.

Аялал жуулчлал, байгаль орчны газрын дарга Х.Отгонмөнх “Бид орон нутгийн иргэдийн орлогыг бодитоор дэмжихийн тулд иргэдийн оролцоонд тулгуурласан, говийн өвөрмөц онцлогийг харуулсан эвентүүд тогтмол зохион байгуулна. Энэ хүрээнд “Түмэн тэмээний баяр”, “Алтан элс-Элсэн манхны баяр”, “Сайханы сарлагийн наадаан” зэрэг эвентүүдээ “Гайхамшигт говь” аялал жуулчлалын холбоогоор гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж байна. Цаашид төр бүхнийг хийх биш хувийн хэвшил, ТББ-ын хамтын ажиллагаанд түшиглэх нь илүү оновчтой” гэв. Харин тус холбооны тэргүүн Х.Түмэндэлгэр “Зорих газрууд, түүх соёлын дурсгалт газар, тусгай хамгаалалттай газруудаа орон нутгийн ТББ-ын оролцоотойгоор хамгаалах, эзэнжүүлэх, дэд бүтцийг нь хөгжүүлэхэд аймгаас их хөрөнгө оруулалт хийж байна” хэмээсэн.

Түүний онцолсноор уул уурхайн үйл ажиллагаа ихсэхийн хэрээр иргэдийн хандлага өөрчлөгдөж, байгаль орчиндоо ээлтэй үйлчилгээг сонирхох болжээ. Тиймээс иргэд аялал жуулчлал, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний салбарыг илүүтэй сонирхон аялал жуулчлалын зам дагуу кофешоп,

Аялал жуулчлалын салбарт хэрэгжих томоохон бүтээн байгуулалтууд

- Даланзадгадаас Гурвантэс хүртэлх хатуу хучилттай зам
- Нэмэгтийн хонгилд Үлэг гүрвэлийн үндэсний парк
- Ёлын аманд Ёл цогцолбор
- Даланзадгад хотод олон улсын нисэх онгоцны буудал
- Даланзадгадаас Дундговийн Сайхан-Овоо хүртэлх аялал жуулчлалын зориулалттай хатуу хучилттай зам
- Олон улсын “Говь судлалын төв”
- Монголын говьд амьдардаг хавтгай тэмээ, бөхөн гөрөөсийг сэргээн нутагшуулна

хоолны газар, зочид буудал байгуулж байна. Гэвч үүнтэй холбоотойгоор иргэдийн байгаль орчин, аялал жуулчлалын боловсролыг хөгжүүлэх асуудал гарч ирж байгаа аж. “Аялал жуулчлал бол мэргэжлийн бизнес. Мэргэжлийн түвшинд төлөвлөж, удирдаж, зохион байгуулж байж амжилтад хүрдэг” хэмээн Х.Түмэндэлгэр онцлов.


Тиймээс аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газраас жуулчны бааз, гэр буудал, зам дагуух сумдын нийтийн бие засах газар, хоол үйлдвэрлэл, үйлчилгээг сайжруулах чиглэлээр төрөл бүрийн сургалт, ажлыг зохион байгуулж байна. Тухайлбал, “Гайхамшигт говь” аялал жуулчлалын холбоо, жуулчны баазуудын удирдах ажилтнууд, төрийн албан хаагчдаас бүрдсэн баг аравдугаар сард Японы Осака хотод болох олон улсын аялал жуулчлалын JATA үзэсгэлэнд оролцож, Японы аялал жуулчлалын хөгжилтэй танилцан, хамтын ажиллагаа үүсгэж, туршлага судлах аж.

Шөнийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, аймгаас дэд бүтцийг нь шийдэх замаар таван одтой зочид буудал барих боломжийг хувийн хэвшилд олгох, аймаг дотроо нислэгтэй болох, олон улсын нисэх буудал барих зэрэг олон амбицтай төсөл, санаачилгыг тус аймаг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Уул уурхайгаас олсон орлогоо Өмнөговь аймаг ирээдүйн хөгжлийг нь тодорхойлох аялал жуулчлалын салбартаа тууштай зориулж буйг онцлон тэмдэглэе. Энэ бол Өмнөговь аймгийн хөгжлийн ирээдүйгээ харсан зөв алхам. Хэрэв хөрөнгө оруулалт нь, зөв бодлого менежмент нь байвал Монгол орны бүхий л аймаг аялал жуулчлалын хөгжлөөр цойлох бүрэн боломжтой. Тэрхүү боломжийг хамгийн тэргүүнд олж харж, хэрэгжүүлж буй нь Өмнөговь аймаг болж байна. ■

**Дэд бүтцэд
илүү анхаарч,
хөрөнгө
оруулж байна**

Жуулчны тоо (2012-2022 он)



Эх сурвалж: Өмнөговь аймгийн ЗДТГ

Аялал жуулчлал

Х.Түмэндэлгэр: “Унаган төрхөөрөө буй арал” жуулчдыг соронзон мэт татаж эхэллээ

Өмнөговь аймгийн “Гайхамшигт говь” аялал жуулчлалын холбооны тэргүүн Х.Түмэндэлгэртэй ярилцлаа.

-Та “Гайхамшигт говь” холбооныхоо талаар товч танилцуулна уу?

-Аялал жуулчлалын салбар хөгжиж, жуулчны баазууд олноор байгуулагдахын хэрээр тэдний эрх ашгийг хамгаалахаас гадна аймгийн аялал жуулчлалын ерөнхий бодлого, төлөвлөлтийг гаргаж, хэрэгжүүлэх шаардлага үүссэнээр “Гайхамшигт говь” аялал жуулчлалын холбоог 2008 онд байгуулсан. Манай холбоо Тэргүүнээс гадна Удирдах зөвлөлийн долоон гишүүн, албан ёсны 28 гишүүн байгууллагатай. Мөн аймгийн гэр буудал, гар урчууд, жолооч, морь, тэмээ унуулагч иргэд сайн дураараа нэгдсэн.

Мэргэжлийн байгууллагын хувьд бид салбарын хөгжлийн бодлогыг тодорхойлох, бүтээн байгуулалт, төсөл хэрэгжүүлэх, салбарынхаа дуу хоолойг шийдвэр гаргагчдад хүргэх зорилгоор аймгийн БОАЖГ-тай хамтран ажиллах гэрээ байгуулсан. Эл гэрээний дагуу аймгийн төсвийн төлөвлөгөөнд урт, богино, дунд хугацаанд хийх ажлуудаа оруулах, зөвлөх, санал өгөх байдлаар ажилладаг. Холбооноос жил бүрийн хавар, намар зөвлөлдөх уулзалт зохион байгуулж, гишүүддээ салбарын үйл ажиллагааны мэдээ мэдээллийг цахимаар тогтмол өгдөг.



Улсын хэмжээнд гэр буудал, жуулчны баазын талаарх ойлголт, стандарт дутагдалтай хэвээр байна

-Өмнөговь аймгийн аялал жуулчлалын хөгжил өнөөдөр ямар түвшинд байна вэ?

-Говь нутаг маш эрт, 1920-оод оны эхнээс Америкийн Байгалийн Түүхийн музейн нэрт судлаач Рой Чапмен Эндрюсийн экспедицийн үеэс дэлхийд сурталчлагдсан гэж болно.

1963 онд байгуулсан одоогийн “Жуулчин говь” бол Монголын анхны хөдөөгийн жуулчны баазуудын нэг. Үйлчилгээ менежментийг нь Улаанбаатараас удирддаг, орон нутгийн иргэдэд хаалттай байсан энэ бааз 1993 онд хувьчлагдсан. 1991 онд анхны хувийн хэвшлийн “Түвшин тур”, “Ханбогд”, “Дуут манхан” жуулчны баазууд

► байгуулагдсанаар өмнөговьчууд анх удаа аялал жуулчлалын салбараас үр шимийг нь жинхэнэ утгаар хүртэж эхэлсэн.

Өмнөговь аймгийн анхны мастер төлөвлөгөө буюу аялал жуулчлал хөгжүүлэх бодлогын баримт бичгийг аймгийн ЗДТГ-ын мэргэжилтэн Б.Отгонбаяр бид хоёр 1997 онд боловсруулж байв. “Аялал жуулчлалын тогтвортой хөгжлийн төв”-тэй хамтарч уг төлөвлөгөөг 2008 онд болон 2019 онд тус бүр шинэчилсэн. Гэхдээ сайн мастер төлөвлөгөө гаргаснаар аялал жуулчлал хөгжихгүй. Түүнийг албан ёсны бодлогын баримт бичиг болгох хэрэгтэй. Үүний тулд аймгийн ИТХ-аар батлуулж, Засаг даргын төлөвлөгөө, төсөвт суулгаж, араас нь шахаж хөөцөлдөж байж үр дүн гардаг. Төлөвлөгөөг хэрэгжүүлэх, үр дүнд хүргэхийн тулд аймгийн Аялал жуулчлалын холбоо илүү идэвх санаачилгатай ажиллах хэрэгтэй нь харагдаж байна.

Өмнөговь аймаг “Аялал жуулчлал- Өрхийн орлого” хөтөлбөр хэрэгжүүлж эхэлсэн. Эл хөтөлбөрийн хүрээнд малчид, иргэдийн гэр буудлыг зохион байгуулалтад оруулах зорилгоор “Монгол гэр ажиллуулах журам”-ыг хэрэгжүүлэхээр зорьж байна. Гэвч улсын хэмжээнд гэр буудал, жуулчны баазын талаарх ойлголт, стандарт дутагдалтай хэвээр байна. Цаашилбал, сум, аймаг, хотуудад бий болсон hotel, hostel, motel, guest house, ecolodge, resort, eco ger гэх мэт олон нэршил бүхий үйлчилгээний газрыг нэгдсэн зохион байгуулалт, нэршилтэй болгох, тохирсон стандартыг батлах шаардлагатай.

Өмнөговь аймаг аялал жуулчлалын салбар, ялангуяа зорих газрууд, түүх соёлын дурсгалт газрууд, тусгай хамгаалалттай газруудаа орон нутгийн ТББ-ын оролцоотойгоор хамгаалах, эзэнжүүлэх, дэд бүтцийг нь хөгжүүлэхэд зориулан хөрөнгө оруулж байна. Үүний үр дүнд манай аймгийн аялал жуулчлалын хөгжлийн түвшин арай өвөрмөц яваа ч сайжруулах зүйл зөндөө бий.

-Холбооноос жуулчны баазууддаа ямар шаардлага тавьдаг вэ?

-Холбооноос үндсэн хэдэн шаардлага тавьдаг. Бид олон улсын экотуризмын үндсэн шаардлагуудыг харгалзах ёстой. Тухайлбал, үйлчилгээ, үйл ажиллагаа нь байгаль орчинд сөрөг нөлөөгүй байх ёстой. Хэрэв мод ургамал, хөрс шороог хөндөж эвдсэн бол түүнийг эргүүлээд

илүү сайнаар сэргээх ёстой. Говийн унаган мод ургамлыг тарьж, орчныхоо экосистемд дэмжлэг үзүүлэх, сумын сурагчдын байгаль хамгаалах нөхөрлөл, клуб, орон нутгийн иргэдийн орлогыг дэмждэг, орон нутагтаа хүртээлтэй байх, байгаль хамгаалалд тодорхой хөрөнгө оруулах зэрэг шаардлага тавьж ирсэн.

Манай холбоонд шинээр жуулчны бааз, гэр буудал байгуулах хүсэлтэй олон хүн ханддаг. Бидний зүгээс нэг л шаардлага тавьдаг. Та бүхэн Монгол Улсын хамгийн сайн жуулчны бааз, гэр буудлуудыг үз, тэнд ямар алдаа байна, түүнийг давтахгүйгээр бүр илүү сайнаар хийх ёстой гэдэг.

-Өмнөговьд уул уурхай эрчимтэй хөгжиж байна. Харин иргэд аялал жуулчлалыг түлхүү сонирхох хандлага ажиглагдаж байна.

-Уул уурхай ихсэхийн хэрээр иргэд тогтвортой, байгаль орчиндоо ээлтэй үйлчилгээ, үйл ажиллагааг сонирхох болсон. Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотойгоор уул уурхай хариуцлагатай, орон нутгийн иргэдэд хүртээмжтэй байх ёстой гэсэн хандлага түрж байна. Иргэд аялал жуулчлал, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний салбарыг илүүтэй сонирхох болсон нь сүүлийн үед Даланзадгад болон аялал жуулчлалын зам дагуух суурин газруудад олноор нээгдэж буй кофешоп, хоолны газрууд, зочид буудлаас харж болно. Үүнээс шалтгаалж иргэдийн байгаль орчин, аялал жуулчлалын боловсролыг хөгжүүлэх асуудал гарч байна. Аялал жуулчлал бол мэргэжлийн бизнес. Мэргэжлийн түвшинд төлөвлөж, удирдаж, зохион байгуулж байж амжилтад хүрдэг гэдгийг нь хаа хаанаа ойлгох ёстой.

-Аялал жуулчлал малчдын орлогын нэг томоохон хэсэг болжээ.

-Уур амьсгалын өөрчлөлт, ган зудаас хамаарч залуу үе мал аж ахуйгаас гадна нэмэлт орлого, бусад салбарыг сонирхож байна. Малчдын орлогыг нэмэгдүүлэх гол зүйл морь, тэмээн аялал. Мөн хээрийн аялалд хөтчөөр ажиллаж, гэр буудал ажиллуулж байна. Орлогын өөр эх үүсвэртэй болсон нь малын тоо толгойг зохистойгоор хязгаарлах, экосистемийн хэт ашиглалтыг тэнцвэржүүлэх алсын зорилгод чухал үр дүн авчрах болов уу. Өрхийн орлого мэдэгдэхүйц өсөнгүүт аялал жуулчлал руу орох иргэдийн сонирхол нэмэгдэж, өгөөж нь ч өөрсдөд нь мэдрэгдэж байна.

Бид 1995 онд анхны олон хоногтой тэмээн

Америкийн нэртэй хөхтөн амьтан судлаач Жон Халл “Монгол бол Орос, Хятад хоёр аварга гүрний дунд оршдог, байгаль орчин, зэрлэг амьтад нь унаган төрхөөрөө, эвдрээгүй дэлхий дээрх цорын ганц арал” гэж хэлсэн

▶ аялал, 1997 онд анхны Түмэн тэмээний баяр хийж байсан. Энэхүү арга хэмжээг тасралтгүй зохион байгуулсаар 2016 онд 1108 тэмээний уралдаан хийж Гиннесийн дээд амжилтыг шинэчлэн тогтоосон. 1990-ээд оноос нэг тавхайг нь 10 мянган төгрөгөөр Хятад руу гаргаж, хэдэн зуугаар нь хуушууранд нядалж байсан тэмээг аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгож, олны анхааралд оруулснаар тэмээнээс олох иргэдийн ашиг нэмэгдсэн. Тэмээний үнэлэмж нэмэгдэж, малчид тэмээгээ хайрлаж, өсгөж үржүүлж, аялал жуулчлалд ашиглаж, аж амьдрал, хүрээлэн буй орчноо “бүтээгдэхүүн” болгож байна.

-Аялал жуулчлал сэргэж эхэллээ. Ковидын дараах жуулчдын хандлага хэрхэн өөрчлөгдөж байна вэ?

-Ковидын дараа Өмнөд Солонгосын иргэд Европ жуулчдаас илүү их орлого оруулж байна. Өнгөрсөн хавар манай холбоо “Солонгос зах зээлийн Аялал жуулчлалын холбоо”- той хамтарч говио сурталчлах сургалт, танин мэдэхүйн аяллыг говийн үзэсгэлэнт болон түүх, соёлын дурсгалт газруудаар зохион байгуулсан нь амжилттай болж, шинэ зорих газруудыг гаргаж ирлээ. Эл аялалд Ноён, Гурвантэс сумын Засаг дарга н.Насанбуян, Г.Гангамаа нар ач холбогдол өгч оролцсон нь говийн бүсийн шинэ зорих газруудад төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны үрээр аялал жуулчлал эрчимтэй хөгжих суурь болно. Энэ зун Баянзаг, Ёлын аманд гар урчууд сувенирын эсгий тэмээгээ оёж амжихгүй болтлоо тийм хурдацтай борлуулалт хийж байна.

Саяхан Хонгорын элсний Дуут манхны хормойд 60 фургон зогсож байсан мэдээлэл бий. Фургон бүрд багадаа таван жуулчин байсан гэвэл нэг ээлжинд 300 жуулчин очсон гэсэн үг. Тэр өдрүүдэд жуулчдад унах тэмээ хүрэлцэхгүй байлаа. Ёлын ам, Хонгорын элс, Баянзаг орчмын малчдын гэр буудал, жуулчны бааз, отоглох цэгүүдэд жуулчид хонож, сум аймгийн дэлгүүр, хоолны газрууд, музей, мэдээллийн төвөөр үйлчлүүлж, тусгай хамгаалалттай газруудад төлбөрөө төлж, фургон, жийпний үнэ ханшийг өсгөж, сум, аймагт хамгийн хүрэлцээтэй байдаг цэвэр ус тасарч, шатахуун тасалдахад хүргэсэн. Жуулчдын энэ урсгалын үр дүнд орж ирж буй орлого байгууллага, иргэдэд шууд очиж байгаа гэхээр аялал жуулчлал маш олон салбарт хүртээлтэй бизнес болох нь харагдана. Гэхдээ үүнийг дагаад сөрөг нөхцөл байдал үүсэж

буйг бодолцох, зохицуулах хэрэгтэй. Солонгос жуулчдын урсгалыг дагаад хөдөөгийн зам дагуух сум, сууринд боловсон бие засах газар, хоолны газар, зочид буудлууд иргэдийн хувийн хөрөнгө оруулалтаар бий болж, иргэдийн орлого нэмэгдэж байгаа нь хамгийн чухал үр дүн юм.

-Ковидын дараа хүмүүс дэлхийн хамгийн эвдрээгүй, унаган төрхөөрөө буй байгаль, газар нутаг руу тэмүүлж байна.

-Хүмүүс илүү унаган төрхөөрөө байгаа, амгалан тайван улс руу аялах хандлага түрж эхэлсэн нь үнэн. Үүний тод жишээ нь Монгол Улс. Америкийн нэртэй хөхтөн амьтан судлаач Жон Халл “Монгол бол Орос, Хятад хоёр аварга гүрний дунд оршдог, байгаль орчин, зэрлэг амьтад нь унаган төрхөөрөө, эвдрээгүй дэлхий дээрх цорын ганц арал” гэж хэлсэн. Энэ “арал” бол Монгол орон. Унаган төрхөөрөө буй энэ “арал” жуулчдыг соронзон мэт татаж эхэллээ. Энэ арлын ховор чухал биологийн төрөл зүйлүүд, унаган төрх байдал, нүүдэлчин малчин соёл, түүх соёлын олдвор, дурсгалууд нь 70 гаруй жилийн туршид харьцангуй бага судлагдаж, нууц хадгалагдаж байгаад 1990-ээд оны ардчиллын дараа жуулчдыг соронзон мэт татаж эхэлсэн.

Дэлхийн байгаль хамгаалах сан, TNC зэрэг олон улсын байгууллага ч “Монгол бол хүний гарт хамгийн бага өртсөн, цөлийн хамгийн том зэрлэг туруутан амьтад дураараа нүүдэллэн амьдардаг, хамгийн том, сүүлчийн газар нутаг” гэж тодорхойлдог. Монгол орны цөөнгүй унаган зэрлэг газар нутаг дэлхийн шилдэг 200 экобүсийн тоонд орж байна.

Говийг ихэнх хүмүүс амьдралгүй цөл, элснээс өөр юу ч үгүй мэт төсөөлдөг. Гэтэл манай говьд дэлхий, бүс нутгийн хэмжээнд нэн ховор, ховордсон ангилалд бүртгэгдсэн, Монгол Улсын Улаан номын 33 зүйл амьтан цөлийн хүнд бэрх нөхцөлийг шүтэж амьдардаг. Үүнийг бид олон улсад таниулах ёстой. Үндэсний болон олон улсын судлаач эрдэмтэд Монголын говийг “Сэрүүн бүсийн серенгети” гэж нэрлэх болсон. Учир нь дэлхийн олон сая жуулчныг татаж буй Африкийн Серенгетигийн таван том (Big five) амьтнаас дутахгүй говийн гайхамшигт зургаан амьтан (GG-6) зөвхөн Монгол оронд хамгийн олноороо, зарим нь зөвхөн Монголын говьд амьдардаг. Хавтгай, хулан, хар сүүлт зээр, мазаалай, баавгай, тахь, бөхөн цөлд эрт галаваас өнөөг хүртэл амьдарсаар ▶

► байна. Өмнөговь аймаг хавтгай тэмээ, бөхөн гөрөөсийг нутагтаа сэргээн нутагшуулахаар ажиллаж байна. Энэ бүхэн аялал жуулчлалын шинэ зорих газрыг бий болгох, цөлийн ховор амьтдыг нутагшуулах онцгой ач холбогдолтой.

-Өмнөговь аялал жуулчлалын бүс нутгууд руугаа хатуу хучилттай зам, цахилгаан, интернэтийн сүлжээ зэрэг дэд бүтцийг үнэхээр төлөвлөлттэйгээр сайн тавьж байгаа юм байна.

-Зорих газруудаа улам хөгжүүлэх, шинэ зорих газруудыг нээж аялал жуулчлалыг бүх нутагтаа тэнцвэртэй хөгжүүлэх, хамгийн гол нь орон нутгийн иргэддээ менежментийн гэрээгээр өгч эзэнжүүлэхэд Өмнөговь аймгийн хөгжлийн цаашдын чиг хандлага чиглэж байна. Бид аймгийнхаа аялал жуулчлалын хөгжлийг Баруун, Төв, Зүүн бүсэд хуваан авч үздэг.

Аймгийн төсвөөр Гурвантэс сум руу хатуу хучилттай зам барьж байгаа нь Хонгорын элс, Нэмэгтийн хөндий, Наран даац, Хэрмэн цав, Зуунмод Зулганай, Бүгийн цав, Тост тосон бумбын нуруу, цаашлаад Шивээ хүрэнгийн боомтоор ирэх хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх гол зам болно. Энэ замыг барьж дуусахад Гурвантэсийн алдарт Нэмэгтийн хөндийд Үлэмж биет үлэг гүрвэлийн үндэсний парк, судалгаа шинжилгээний төвийг мэргэжлийн байгууллагатай хамтран байгуулна.

Төвийн бүсэд Баян заг, Ёлын ам байна. Баянзагийг 2002 онд орон нутгийн хамгаалалтад авч, нэг тэрбум 200 сая орчим төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн. Булган сумын иргэдээс бүрдсэн “Баянзаг-Улалзах цонж” ТББ байгуулж, менежментийг нь тус ТББ-д таван жилийн хугацаатай өгөөд байна. Энэ бол түүх соёлын дурсгалт газрыг орон нутгийн иргэдийн оролцоотой ашиглаж, хамгаалж буй манай улсдаа анхдагчид тооцогдох шилдэг сайн загвар болсон гэж бид үздэг. Өөрийгөө санхүүжүүлж, ашиглалт хамгааллаа хариуцдаг үлгэр жишээ загвар. Монголын хосгүй ховор, түүх соёлын олон дурсгал өнөөдөр эзэнгүй учраас сүйдсээр байгаа. Тэгвэл манай энэ загварыг ашиглах нь зөв гэж боддог. Манай холбоо Баянзагийн менежментийн төлөвлөгөөг Улаанбаатар аялал жуулчлалын холбоотой хамтран Америкийн Йосемит дархан цаазат газрын зөвлөмж, туршлагаар хийж гүйцэтгэсэн.

Ёлын аманд ирэх онуудад “Ёл цогцолбор”

хэмээх томоохон бүтээн байгуулалт хийхээр төлөвлөсөн. Ёлын амны зогсоолд өнөөгийнх шиг ийм олон машин чихэлдэж, дуу чимээ, хөрс, агаарын бохирдол үүсгэж байгааг зогсоож, ховор чухал биологийн олон янз байдал, экосистемийг нь сэргээн хөгжүүлэх зорилт тавьж байна. Ёлын музей, түүний орчныг бүрэн үйлчилгээ бүхий олон үндэстний хоолны газар, нийтийн бие засах газар, байгаль орчны мэдээллийн төв, худалдаа үйлчилгээ, томоохон авто зогсоол бүхий цогцолбор болгож, Ёлын ам руу хатуу хучилттай зам барьж зөвхөн том бага, дунд оврын автобус, цахилгаан хөдөлгүүр бүхий тээврийн хэрэгсэл зорчдог болгон авто хөдөлгөөний эрчмийг хязгаарлана гэж төлөвлөж ТЭЗҮ-ийг боловсруулах хөрөнгийг батлуулсан.

Төвийн бүсэд Даланзадгад-Булган-Мандал-Овоогоос Дундговийн Сайхан-Овоо чиглэлийн хатуу хучилттай замын зураг төслийг хийж дууслаа. Дундговь, Өвөрхангай аймгууд энэ төсөлд нэгдсэнээр аялал жуулчлалын босоо тэнхлэгийн зам бий болж, дээрх сумдыг чиглэсэн хөдөлгөөний эрчим нэмэгдсэнээр аялал жуулчлалаас хүртэх хүртээмж эрс өснө гэж үзэж байна. Харин Булган, Мандал-Овоо сум зочид буудал, музей, соёл урлагийн байгууллагууд, гэр буудлуудаа илүү сайн хөгжүүлэх, багтаамжаа нэмэгдүүлэх шаардлага үүснэ.

Зүүн бүсийн хувьд Манлайн Шар цав дахь дэлхийд хамгийн томд орох Шар цавын үлэг гүрвэлийн мөрт газар томоохон түшиц газар болно. Энэ чиглэлд Тавантолгойгоос Дорноговийн Ханги Мандал чиглэсэн хатуу хучилттай зам томоохон дэвшилийг авчрах боломжтой.

Өмнөговь аймгийн аялал жуулчлал, агаарын тээврийн хөгжилд олон улсын нисэх буудал онцгой үүрэг гүйцэтгэнэ. Базаад хэлбэл, Өмнөговь аймгийн аялал жуулчлалын салбарын ирээдүй уул уурхай түүнээс орж байгаа орлогын хэрээр өнгөлөг, гэрэлтэй харагдаж байна. Бид хэт олон биш, хариуцлагатай, өгөөжтэй уул уурхайтай хамтран нэгдэж хөгжихөөс аргагүй болж байна.

-Танай аймгийн жуулчны баазууд харьцангуй хөгжсөн, тохилог, чанар, үйлчилгээндээ ч ихээхэн анхаардаг нь харагдлаа.

-Говь харьцангуй эрт олон улсад танигдаж, сурталчилж, жуулчин авч эхэлсэнтэй холбоотой. Нөгөө талаас, говийн хүмүүсийн бусдаас илүү

**Аялал
жуулчлал
татвараас
гадна өөр
аргаар
орон нутаг,
иргэдийг
дэмжиж
буйг сайтар
ойлгуулсан
мэдээлэл өгөх
шаардлагатай**

**Гурвантэс,
Ханбогд
сумын нисэх
буудлууд
уул уурхайд
үйлчилж
байгаа ч
алсдаа говийн
аяллын
томоохон дэд
бүтэц болно**

► хөдөлмөрлөж, арга ухааныг илүү олж, аливааг цэвэр нямбай, төгс хийхийг хичээдэг зантай холбоотой. Байгаль цаг уурын хүнд бэрхийг олон зууны турш сөрж, зохицож амьдарч ирснээрээ говьчууд өнөөг хүртэл сайн сайхан амьдарч байна.

Монголын аялал жуулчлалын салбарынхан говийн баазуудыг үнэхээр сайн, орчноо сайхан бүрдүүлжээ гэдэг. Гэхдээ манайд сайн ч, муу ч зүйл бий. Алив зүйлийг хамгийн сайнаар хийх гэж эрмэлздэг нь говьд бүх зүйл хэцүү, хүнд байдагтай холбоотой. Байгаль цаг уурын энэ хүнд шалгарал дунд бид ажлыг чин сэтгэлээсээ, хамгийн сайнаараа хийхийг хичээж ирсэн. Бид цаг уурын нөхцөлдөө зохицуулан хийж ашиглаж амьдрахад суралцсан хүмүүс. Хүнд нөхцөлөөс шалгарч гарахын төлөө явдаг тул говьчуудын тархи толгой сайн ажилладаг, сэтгэдэг, хийдэг, бүтээдэг болов уу. Эртний хүмүүсийн үлдээсэн хадны зураг нь хүртэл уран гоё зохиомж, дүрслэлтэй байдаг нь сонирхол татдаг.

-Монголчуудын аялал жуулчлалын боловсрол дутмаг байгаа талаар мэргэжлийн хүмүүс ярьдаг. Харин танай аймаг дунд сургуулийн сурах бичгээр дамжуулан байгальд ээлтэй байхын ач тусыг ойлгуулах хөтөлбөр хэрэгжүүлж байгаа юм байна. Дэмжүүштэй, бусад аймагт хэрэгжүүлж болохуйц хөтөлбөр санагдлаа.

-Иргэдийн аялал жуулчлалын боловсролыг сайжруулах шаардлагатай. Дотоодын жуулчид, иргэдийн хувьд хөдөө нутагт аялаад, амраад явахаараа хаа хамаагүй бие засаж, хог хаяж, байгаль орчноо бохирдуулж байна. Тиймээс бид аялал жуулчлал, экологийн боловсролыг хүүхдүүдээс эхэлж олгох зорилготой, 3-7-р ангийн сурагчдад зориулсан “Өмнөговь-Танин мэдэхүйн сурах бичиг” ном гаргаж бүх сумандаа хүргэсэн. Аймгийн түүх соёл, дурсгалт газар, түүхэн олдворууд, биологийн ховор төрөл зүйлүүдээ бүрэн багтаасан сурах бичиг. Одоо багш нараа сургана. Аймгийн ЗДТГ-аас энэ ажлыг их дэмжиж байгаа.

Мөн жил бүрийн намар 12 дугаар анги төгсөх бүх хүүхдэд Баянзагийг үзүүлдэг уламжлал манай аймагт бий. Аймгийн Засаг даргын ивээл дор “Эх орон-Миний говь” уриатай зохион байгуулагддаг маш гоё хөтөлбөр. Мөн БОАЖГ-аас хол ойрын зочид, иргэд, ахмадууд, хүүхэд багачууддаа зориулсан Даланзадгад хотын аялал



нь сонирхолтой, эрэлттэй аяллын нэг болсон.

-Өмнөговь аймгийн аялал жуулчлалын салбарт ямар асуудлууд тулгамдаж байна вэ?

-Аялал жуулчлалын тухай хууль шинэчлэгдэж, улс, аймаг, орон нутгийн зэрэг шинэ бүсийг гаргаж ирсэн. Тусгай хамгаалалттай газар нутгийн бүсчлэлүүд байхад нэмж бүсүүд бий болгосон. Аялал жуулчлалын салбарыг сайн мэдэхгүй, орон нутгийн шийдвэр гаргагчид ийм бүс рүү орох болгонд хураамж авч эхэлнэ. Энэ нь манай салбарт сөргөөр нөлөөлөх вий гэж эмээж байна.

Монголчууд жуулчдыг маш баян хүмүүс гэж ойлгодог. Гэтэл тэд цалин, тэтгэврээ хуримтлуулж байгаад аялдаг, зарим нь бүр ямар ч орлогогүй, мөнгөгүй байдаг. Нөгөө хэсэг нь дундаж ►



► орлоготой. Жуулчид Монгол руу өндөр зардлаар нисэж ирдэг. Аялал жуулчлалаар Монгол орны өртөг өндөртөө орно. Тэгээд ирэхэд нь хураамж хэлбэрээр хуулчдын халаасыг нь сэгсэрч болохгүй. Шийдвэр гаргагчид энэ хуулийн заалтуудаа ойлгуулах хэрэгтэй. Аялал жуулчлал татвараас гадна өөр аргаар орон нутаг, иргэдийг дэмжиж буйг сайтар ойлгуулсан мэдээлэл өгөх шаардлагатай.

Нөгөө талаас, дээр дурьдсан олон нэршил, стандарт журмууд хурдан, зөв батлагдаж хэрэгжих хэрэгтэй. Жуулчны бааз, гэр буудал, бүтээн байгуулалт хоорондын зай ямар байх, сум суурин болон хөдөө орон нутаг, дэд бүтцээс алслагдсан отоглох цэгийн нийтийн бие засах газар ямар байх

ёстойг орон нутгийн байгаль орчин, цаг уурын нөхцөл байдалд зохицсон, зөв оновчтой стандарт, зураг дизайнаар тогтоох хэрэгтэй.

Мөн солонгос жуулчдын масс урсгалтай холбоотой маш их сөрөг нөхцөл байдал үүсэж буйг анхаарч, зохицуулах ёстой болж байна. Цаашдаа ийм том масс туризмд манай багтаамж хүрэх үү, зарим жуулчны бааз, зорих газар дээр бий болж байгаа солонгос жуулчдын урсгал, бөөгнөрөл, тэдэнд үйлчилдэг компаниудын жолооч, хөтчүүдийн болон салбарт харагддаггүй байсан сөрөг харилцаа, хандлага нь энэ шинэ том зах зээлийг хэрхэн удаан хадгалж чадах вэ гэдэг асуудлыг үүсгэж байна.

Манай нэг баазын захирал “Европ жуулчид

**Ёлын ам
орчимд олон
улсын “Говь”
судлалын
шинжлэх
ухааны төв
байгуулахаар
ажиллаж
байна**

Бид зорилтот зах зээлээ зөв тодорхойлох, тэдэнд зориулсан үйлчилгээ, бүтцийг зохион байгуулах ёстой

► нэг гэрт ганцаараа орчихдог, сул орны төлбөр нь хангалттай биш, гомдол чирэгдэл их гаргадаг. Гэтэл солонгосчууд шуугих, наргих нь их ч монголчууд шиг зодолдохгүй, ухаанаа алдахгүй, нэг гэрт олуулаа орно, гомдол гаргадаггүй, хамгийн гол нь төлбөрөө шууд төлдөг” гэж ярьсан. Солонгосчууд группээрээ тасралтгүй ирдэг учраас сул өдрүүд гардаггүй, сайн хэлж өгвөл баазын журам дүрмийг дагадаг, дандаа залуучууд учраас ойлголцоход амар учир ирэх жилээс солонгос жуулчдаар дагнана гэж байна. Энэ нь цаашдаа бид зорилтот зах зээлээ зөв тодорхойлох, тэдэнд зориулсан үйлчилгээ, бүтцийг зохион байгуулах ёстойг харуулах том жишээ.

Үүний тулд Монголд 400-500 мянган жуулчин ирлээ гэдэг статистик тоог задалж үзэх шаардлагатай. Өмнөговьд ирж буй жуулчдын тоо, иргэншлийг Ёлын ам, Баянзагаар нэвтэрсэн хураамж, тэнд тогтмол хийдэг бүртгэлээр гаргахыг бид эрмэлздэг. Баянзагт одоогоор 11 мянган гадаадын жуулчин нэвтрээд байгаагийн ихэнх нь солонгосчууд. Энэ тоо маш их зөрүүг үүсгэж байна. Говьд ийм байхад хангай дахь жуулчдын гол урсгалын нэг Хустайн БЦГ-т бидэнтэй тун ойролцоо тоон үзүүлэлт гардаг. Тэгэхээр жинхэнэ жуулчин хэд ирдэг вэ гэдэг нь асуудалтай. Уг нь эндээс бид зорилтот зах зээлээ тодорхойлох ёстой юм.

Бодлогын түвшинд юу хийх хэрэгтэйг сайтар ойлгуулбал манай аймгийн ИТХ, Засаг даргын зүгээс аялал жуулчлалын салбараа ихэд анхаарч, дэмждэг.

-Өмнөговь аялал жуулчлалын газруудынхаа бүсүүдийн жорлонгийн асуудлыг шийдсэн байна. Энэ туршлагаасаа бусад аймагтай хуваалцаж байна уу?

-Жорлон үнэндээ дэлхий нийтийн асуудал шүү дээ. Манайхтай адил, манайхаас доор ч орон зөндөө бий. Бид наймдугаар сарын 9-нд аймгийн ИТХ-аар Булган суманд барих, Японы “Мичино эки” загварын нийтийн бие засах газар, “Булган суманд үйлдвэрлэв” брэнд бүтээгдэхүүний дэлгүүр, кофешоп, хөнгөн хоол хүнсний үйлчилгээ, Булган сумын байгаль орчны мэдээллийн төв бүхий аялагч, жуулчид иргэдэд зориулсан, цэвэр ус, цахилгаан, дулаантай жижиг цогцолбор барилгын төсвийг батлууллаа. Энэ цогцолборыг аялал жуулчлалын гол зорих газрын дамжин өнгөрдөг сумуудад, цаашдаа бүх суманд

барих зорилготой байна. БОАЖЯ-наас түрүү жилүүдэд яриад чимээгүй болчихсон байсан асуудал л даа.

Бид Баянзагт анхны хуурай 00-ыг байгуулсан. 2002 оноос эхэлж загварыг нь хийж үзсэн юм. 2019 оноос хойш гадаад, дотоодын 33 мянган хүнд үйлчилсэн гэхэд уг 00 харьцангуй гайгүй байна. Гэхдээ Баянзаг худагтай, өндөр хүчдэлтэй болсон учир боловсон бие засах газартай болох боломжтой. Дэд бүтцээс алслагдсан малчин айлууд, гэр буудлуудаа энэ загвараар 00-ын асуудлыг нь шийдэж байна.

-Танай аймагт түүхэн өв, соёлын томоохон бүтээн байгуулалтууд өрнөж байна. Үлэг гүрвэлийн үндэсний парк байгуулах бүтээн байгуулалт жуулчдын урсгалыг маш их татна гэж бодож байна?

-Гурвантэс рүү явж буй зам замыг барьж дуусахад уг бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлнэ. 1920-оод оны эхээр АНУ-ын Байгалийн Түүхийн музейн Төв Азийн 3-р ангийн экспедиц манай говиос үлэг гүрвэлийн өндөг, яс, эртний хүмүүсийн чулуун зэвсгийн дурсгал, хөхтөн амьтдын чихмэл, олдворуудыг авч явсан. Ингэж Монголын говийг дэлхийд таниулсан түүхтэй. 1946 онд дэлхийн II дайны дараа Оросын судлаач Ефремовын удирдсан баг Монголд ирж, Нэмэгтийн хөндийгээс үлэг гүрвэлийн олдворууд олсон.

Гурвантэс сум нь үлэг гүрвэлийн өлгий нутаг. Гурвантэс орох замд Дунд голын давсны үйлдвэр хэмээх жижиг тосгон бий. Энэ тосгонд Гурвантэст нэвтрэх мэдээллийн төв, элс болон давсны сувилал байгуулж хөгжүүлэх боломжтой. Мөн давс анх яаж үүссэн, хэрхэн боловсруулдгийг харуулсан музей, давс боловсруулах цех байгуулж худалдаалдаг болгох хэрэгтэй. Дунд голоос Нэмэгтийн хөндий хүртэл 50 гаруй км. Манайхаас хулгайлагдсан аварга том Тарбозавр Батаарыг эндээс авсныг тогтоосон. Хатуу хучилттай зам нь Гурвантэсээс цааш Хятадтай холбогдсоноор хил орчмын болон хил дамнасан аялал жуулчлалын хөгжилд маш том дэмжлэг болно. Гурвантэс, Ханбогд сумын нисэх онгоцны буудлууд уул уурхайд үйлчилж байгаа ч алсдаа говийн аяллын томоохон дэд бүтэц болно.

-Цайны замын бүтээн байгуулалтын талаар тодруулж ярина уу?

-Цайны зам нь Торгоны замтай адилхан. Торго ►

► дурдан, бөс бараа зэрэг худалдаалж болох бүх барааг энэ замаар тээдэг байсан. Худалдаанаас гадна олон улсын түүх, соёлын харилцааг үүсгэж байсан зам гэдэг нь тодорхой. Бээжингээс гарч, Хөх хот, өнөөгийн Гашуун сухайтын боомтоор ороод Өмнөговийн Ханбогд, Баян-Овоо, Ханхонгор, Булган сумын нутгаар дамждаг байсан энэ замын дөрвөн метр шахуу өргөн мөр маш тод үлдсэн.

Рой Чапмэн Эндрюс 90 хоногийн өмнө Хятадаас гарч, Ховд хот, түүнээс цааш явах төлөвлөгөө бүхий 200 тэмээтэй махмудын худалдаачидтай Баянзаг дээр уулзсанаа номондоо дурдсан байдаг. Энэ зам Монголын эртний нийслэл Хархорин, цаашлаад Ховд, Улиастай, улмаар Туркистан, Кашгартай холбогдож байсан нь бүр Марко Пологоос ч өмнөх үеийнх. Манай аймаг энэ замыг аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгож, томоохон бүтээн байгуулалт хийгээд дуусаж байна.

Цайны зам судлаач О.Сүхбаатар, Улаанбаатар аялал жуулчлалын холбоотой хамтарч Хөх хотоос эхлээд Гашуун сухайт, Хархорин, Улиастай хүртэлх замын өртөөнүүдийг тодорхойлсны үндсэн дээр дурсгалын баганууд босгох хэрэгтэй. Цайны зам дагуух, цаашлаад Туркменистан, Кашгар хүрсэн авто аялал бий болгож, тодорхой хэсэгт нь тэмээгээр аялдаг маршрут гаргавал аялал жуулчлалын маш сайн бүтээгдэхүүн болно.

-Та бол шувуу сонирхогч, судлаач. Сүүлийн үед шувуу үзэж харахаар жуулчид их ирдэг болсон. Энэ чиглэлийн жуулчлал хэр хөгжиж байна вэ?

-Монгол бол шувуудад чухал орон. Нүүдлийн шувуудын 50 хүртэлх хувь нь манай оронд өндөглөж, үрждэг. Манайд 520 гаруй төрөл зүйлийн шувуу бүртгэгдсэн. Шинэ зүйл төрлийн шувууд жил бүр бүртгэгдсээр байгаа нь шувуу сонирхогч, судлаач, гэрэл зураг авдаг залуучууд шинэ, зөв хоббид хөтлөгдөж байгаатай холбоотой.

Өмнөговь аймгаас Ханбогдын Галбын говь, Гурвансайхан уул, Номгоны Бордонгийн говь Монгол орны шувуудад чухал газраар бүртгэгдсэн. Дэлхийн шувуудын нүүдэллэн өнгөрдөг дөрвөн гол замын нэг нь говь. Говьд нүүдлийн үеэр нь ирэхэд олон зүйлийн шувууг харах боломжтой. Мод цөөн, жижиг нууруудтай тул шувуудыг ойрхноос харах боломж олддог. Тусгай аяллын жуулчдын хувьд голдуу англи, европ, япончууд ирж байна.

Сүүлийн үед шувуу, зэрлэг амьтан, ялангуяа ирвэс харах мөрөөдөлтэй жуулчид олон ирдэг боллоо. Монголын говиос аргаль, янгир, хуланг нэг дороос харах боломжтой. Энэтхэгийн Ладахийн уулс шиг 5000-6000 метрийн өндөрт биш 2500 метрийн өндөрт ирвэс харах жишээтэй. Хөхтөн судалдаг хүмүүсийн мөрөөдөл нь цоохор ирвэс харах. Орон нутгийн иргэдийг цоохор ирвэс, мануул мий харах аялалд оролцуулснаар хулгайгаар агнахаас хамгаалах, агнаж үргээж биш амьдрах орчныг нь хамгаалж аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгох нь зөв менежмент болно. Зарим тусгай хамгаалалттай газрууд, байгаль хамгаалал, судалгааны төслүүд гаднаас санхүүжиж байгаа ч цаашдаа бид тогтвортой, байгаль орчин, орон нутгийн иргэдэд ээлтэй, хүртээмжтэй аялал жуулчлалыг зөв хөгжүүлснээр олон чухал биологийн төрөл зүйлийг найдвартай хамгаална.

Говь нь ховор чухал биологийн төрөл зүйлд нэн тааламжтай нутаг. Америкийн судлаач Жон Халл Ёлын аманд хийсэн шөнийн аяллаараа хоёрхон цагийн дотор мануул мий, эрээн хүрнэ, хадны суусар, өмхий хүрэн хараад “Танай энэ уул үнэхээр чухал газар байна. Би дэлхийн олон оронд хөхтөн амьтан судалж, 2000 удаа шөнийн аялал хийсэн. Гэхдээ ийм чухал дөрвөн зүйлийн амьтныг нэг дор, ийм богино хугацаанд хардаг газар орныг үзээгүй” гэж хэлсэн.

Өмнөговьчууд 1990-ээд оны эхээр суурийг нь тавьсан Говь хөдөлгөөн, говь судлалын үйл ажиллагааг эхлүүлэх цаг болсон. Бид Ёлын ам орчимд олон улсын “Говь” судлалын шинжлэх ухааны төв байгуулахаар ажиллаж байна. Мөн олон улсын эрдэмтэн судлаач, оюутнуудтай хамтарч говийн биологийн олон янз байдлын судалгааг хийх цаг болсон. Говь Гурвансайхан уулын цагаан мөөг бараг устаж байна. Элбэг байсан үхэр огдой, үхэр хэдгэнэ, зүйл бүрийн эрвээхэй устаж, цөөрч, мөн бороо багасч, газар нутаг гандаж хуурайшиж байна. Үүнд л амьдрал болоод байгаль орчинд тустай шинжлэх ухааны бодитой судалгаа хэрэгтэй.

Аймгийн Засаг дарга санаачлаад “Говийн эмт ургамлын зөвлөгөөн”-ийг зохион байгуулсан бол ХААИС-тай хамтраад Өмнөговьд мод ургамал, жимс тарих судалгаа хийж байна. Шинжлэх ухаанчаар судалсан зүйлийг бүтээл болгож амьдрал хэрэгжүүлэх нь хамгийн чухал. Говьд маш их боломж мөн хийх ажил их байна. ■

Сүүлийн үед шувуу, зэрлэг амьтан, ялангуяа ирвэс харах мөрөөдөлтэй жуулчид олон ирдэг боллоо

Эрсдэлийг удирдагч

Даатгуулах соёл



**Монгол Улсад
нийт 624
даатгалын
бүтээгдэхүүн,
үйлчилгээ
байна**

Даатгалыг энгийнээр тайлбарлавал ирээдүйн үйлчилгээнийхээ төлбөрийг урьдчилан авч буй үйл явц юм. Мөн даатгагч, даатгуулагчийн хооронд үүсэж буй мөнгөн харилцаа.

Монголчуудын даатгалын талаарх ойлголт, мэдлэг тийм ч сайн биш, эд хөрөнгөө барагтай л бол даатгуулдаггүй. Албан журмаар даатгуулдаг жолоочийн хариуцлагын даатгалынхаа утга учрыг ч 100 хувь мэддэг нь ховор болов уу. Мөн иргэдийн дунд даатгалтай холбоотой олон эргэлзээтэй ойлголт байдаг. Тиймээс даатгалын төрөл, ангилал, ямар эрсдэлээс хамгаалдаг, аливаа эрсдэлийг санхүүгийн хохирол багатай туулах боломжийн талаар мэдээлэлтэй болгох нь нэн чухал байна.

Даатгалыг хугацаагаар нь ердийн ба урт хугацааны гэж хоёр ангилдаг. Ердийн даатгал нь нэг жил хүртэлх хугацаатай бол урт хугацааны даатгалыг жилээс дээш хугацаатай хийдэг. Мөн албан журмын болон сайн дурын даатгал гэсэн хоёр төрөл бий.

Албан журмын жолоочийн хариуцлагын даатгалыг эс тооцвол манайд ихэнх даатгал сайн дурынх байдаг.

Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал нь жолооч замын хөдөлгөөнд оролцох үедээ бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд учруулсан хохирлыг даатгуулагчийн өмнөөс нөхөн төлөх зориулалттай даатгал.

Харин манай иргэд энэ даатгалд хамрагдснаар өөрийн тээврийн хэрэгсэлдээ учирсан хохирлыг мөн нөхөн төлүүлнэ гэсэн буруу ойлголт байдаг. Хэрэв та автомашинаа бүрэн хамгаалахыг хүсвэл тээврийн хэрэгслийн даатгалд сайн дураараа даатгуулах боломжтой. Ингэснээр таны автомашин иж бүрэн хамгаалагдана.

2022 оны жилийн эцсийн байдлаар Монгол Улсад сайн дурын даатгалын 22 хэлбэр болон албан журмын нэг даатгалын хэлбэрийн нийт 624 даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээг даатгалын компаниуд санал болгож байна.

- *Сайн дурын даатгалын төрөл*
- *Хүний амь нас, эрүүл мэнд, ашиг сонирхлын даатгал*
- *Гэнэтийн ослын даатгал*
- *Эд хөрөнгийн даатгал*
- *Санхүүгийн даатгал*
- *Хариуцлагын даатгал*
- *Тэтгэврийн даатгал*
- *Хуримтлалын даатгал*

Эдгээр даатгал дотроо хэд хэд хуваагддаг. Тухайлбал, автомашины, аяллын, хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, амь насны, тамирчдын, үл хөдлөх хөрөнгийн, байр, орон сууц, газрын, электрон тоног, төхөөрөмжийн зэргээр тоочвол олон бий. Даатгалын үйлчилгээ авахдаа үнэ цэнийг чухалчлахаас гадна та өөрийн зайлшгүй хэрэгцээ шаардлагад үндэслэх хэрэгтэй. Тухайлбал, та аялах дуртай бол аяллын, эрсдэлтэй нөхцөлд ажилладаг бол гэнэтийн ослын, ачаа тээвэр, логистикийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг бол ачаа тээврийн даатгалд хамрагдах хэрэгтэй.

Даатгалын үйлчилгээний гол зорилго нь таны эрсдэлийг батлан дааж, хохиролгүй болгох учраас үйлчилгээ авахдаа нөхөн төлбөрийн өндөр чадвартай компанийг сонгох нь зүйтэй. Аялж байхдаа бэртэж гэмтэх, эд зүйлээ алдахаас эхлээд үндэслэлтэй бүхий л тохиолдолд даатгалын компани нөхөн төлбөр олгодог.

► Зах зээл дээр үйл ажиллагаа явуулж байгаа олон даатгалын компанийн төрөл бүрийн даатгалаас яг өөрт тохирохыгоо сонгоно гэдэг тийм ч амар биш.

Та даатгалын гэрээнд гарын үсэг зурахдаа өндөр хариуцлагатай байх шаардлагатай. Тухайн гэрээ нь одоо мөрдөгдөж буй хууль, дүрэмтэй нийцэж байгаа эсэхийг нягтал. Ялангуяа, санхүүгийн хариуцлага хүлээх гэрээнд гарын үсэг зурахдаа анхааралтай хандах нь зүйтэй юм. Таны эрх ашигт энэхүү гэрээ нь нийцэж байгаа эсэх, нэмэлт өөрчлөлт оруулж тусгуулах зүйл байгааг анхаарах нь хамгийн чухал.

Хүнд үед санхүүгийн их хэмжээний хохирлыг өөртөө үүрэхгүйгээр даатгалын байгууллагуудад шилжүүлэх боломж байгаа бөгөөд таны эрсдэлийг даатгалын компани хариуцах юм. Даатгал бол эрсдэлийн дараах санхүүгийн алдагдлыг нөхөх, цаг хугацаа, эрүүл мэнд болон сэтгэл санааны хохирлыг бууруулах хамгийн шилдэг санхүүгийн хэрэгсэл гэдгийг нийтээрээ ойлгох хэрэгтэй.

Даатгуулсан гэдэг сэтгэл зүй нь аливаа эрсдэлээс айх, сандрах, санаа зовох байдлыг багасгах учир нийгмийн сөрөг сэтгэлзүй, стрессийг бууруулдаг ач холбогдолтой. Нөгөө талдаа эрсдэлийг хамтдаа даван туулах сэтгэл зүйг нийгэмд суулгадаг. Ингэснээр аливаа асуудалд төрөөс дэмжлэг хүсэхээс илүүтэй нийтээрээ томоохон гамшиг, эрсдэлийг даван туулах сэтгэл зүйтэй болдог байна. Хамгийн сүүлийн жишээ дурдвал өнгөрсөн зун Улаанбаатар хотод гурван удаагийн үер болсон. Энэ үеэр 60 гаруй айл орон гэргүй болж, 300 орчим автомашин их бага хэмжээгээр үерт өртөж, аж ахуйн нэгж эд хөрөнгөөрөө хохирсон. Усанд автсан аж ахуйн нэгжээс ердөө гурав нь, 20 автомашин даатгалтай байжээ. Даатгалтай байсан иргэн, аж ахуйн нэгж даатгалаасаа хохирлоо барагдуулан эргээд хэвийн ажил, амьдралдаа орсон тохиолдол бий. Даатгалын тогтолцоо сайн хөгжих нь

төрөөс нэг ч төгрөгийн хөрөнгө мөнгө гаргахгүйгээр аливаа эрсдэлийг даван туулах боломжтой.

Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх даатгалын хураамжийн хувь хэмжээ их байх тусмаа улс орны эдийн засаг харьцангуй тогтвортой байдаг гэсэн судалгаа бий. Гэтэл Монгол Улсад даатгалын хураамжийн хувь хэмжээ ДНБ-ий 0,5 хувь байгаа нь даатгалын салбар бодитоор улс орон, иргэдийг эрсдэлээс хамгаалж чадахгүй байна гэж мэргэжлийнхэн үзэж байна.

Өнөөдрийн байдлаар даатгалын салбарт ердийн даатгалын 15, давхар даатгалын нэг, амьдралын даатгалын хоёр компани үйл ажиллагаагаа явуулж байна. Даатгалын зах зээл дээр 17 нэр төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ бий. Даатгалын үйлчилгээ 21 аймгийн 330 суманд хүрч ажилладаг.

Монгол Улс 3,5 сая хүн амтай, үүнээс давхардсан тоогоор нэг сая орчим сайн дурын даатгалд өөрийн эд хөрөнгө, амь нас, албан байгууллагаа даатгуулжээ.

Даатгалын салбар 495 тэрбум төгрөгийн хөрөнгөтэй. Нийт 300 тэрбум орчим төгрөгийн хураамж төвлөрүүлдэг. Үүнээс 240 тэрбум төгрөг нь дотооддоо авч үлдэж байгаа хураамжийн орлого.

Даатгал нь аливаа улс орны санхүүгийн тулгуур салбар юм. Эдийн засгийн дархлаа салбар нь болж явдаг.

Дэлхийн улс орнууд эдийн засгаа босгохын тулд хүнд үйлдвэрлэл рүүгээ хөрөнгө оруулалт хийдэг. Үүний дараа зам барилга, гадаад, дотоод худалдаа зэрэг эдийн засгаа тогтворжуулаад эцэст нь даатгалын салбарыг хөгжүүлдэг сайн туршлага бий. Даатгалын салбар нь хөгжиж байж тухайн босгосон эдийн засгийг хамгаалдаг, дархлаа нь болдог.

Монгол Улсад банкны салбар үүсэж хөгжөөд 100 гаруй жил болж байна. Харин даатгалын салбар ирэх онд 90 жилийн ойтойгоо золгох гэж буй. Гэхдээ ДНБ-д эзлэж байгаа даатгалын хувь хэмжээг харахад чамлалттай үзүүлэлт юм. ■

ДААТГАЛЫН БҮТЭЭГДЭХҮҮН СОНГОХДОО АНХААРАХ

- Учирч болзошгүй эрсдэлээ тодорхойлох
- Эрсдэлд тохирсон даатгалын бүтээгдэхүүний үнэлгээ, хураамжийг судлах
- Тухайн бүтээгдэхүүнтэй ижил төстэй, хамгийн багадаа 2-3 компанийн бүтээгдэхүүнийг харьцуулах
- Даатгалын компани сонгох, даатгалын гэрээгээ сайн уншиж танилцах, даатгуулах
- Нөхөн төлбөр олгох болон олгохгүй нөхцөлтэй танилцаж, асууж тодруулах
- Нөхөн төлбөрийг хэрхэн шийдвэрлэх нөхцөлтэй танилцах

ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР ОЛГОХООС ТАТГАЛЗАХ НӨХЦӨЛҮҮД

- Даатгуулагч санаатайгаар хохирол учруулж нөхөн төлбөр авах нөхцөл бүрдүүлэх
- Даатгуулагч худал мэдээлсэн, хуурамч бичиг баримт бүрдүүлсэн нь тогтоогдох
- Даатгалын гэрээнд зааснаас бусад шалтгаанаар хохирол гарах
- Гарсан хохирлыг даатгуулагч буруутай этгээдээр нөхөн төлүүлсэн
- Даатгуулагч хүндэтгэх шалтгаангүйгээр хууль болон гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй бол, тухайлбал даатгалын тохиолдлын талаар заасан хугацаанд даатгагчид мэдэгдээгүй, нөхөн төлбөр авах хүсэлт, бичиг баримтаа бүрдүүлж өгөөгүй гэх мэт
- Дайн байлдаан, хувьсгал, төрийн эргэлт, хорлон сүйтгэх үйл ажиллагаа, бослого, үймээнд оролцсоны улмаас үүссэн хохирлыг төлөхгүй

Монгол даатгал

Л.Төр-Од: Даатгал нь санхүүгийн тогтвортой байдлын чухал бүрэлдэхүүн хэсэг юм



Даатгалын компаниуд юун түрүүнд бүтээгдэхүүнээс илүүтэйгээр үйлчилгээндээ анхаарч ажиллах шаардлагатай

Даатгалын салбарын ууган компани болох “Монгол даатгал” ХК-ийн Гүйцэтгэх захирал Л.Төр-Одтой ярилцлаа.

-Энэ онд Монгол Улсад даатгалын салбар үүсэж хөгжсөний мөн “Монгол Даатгал” компани үүсгэн байгуулагдсаны түүхт 90 жилийн ой болно. Энэ хугацаанд салбарын хөгжил ямар түвшинд явж ирсэн гэж та үзэж байна вэ?

-Одоогоос 90 жилийн тэртээ 1934 оны арваннэгдүгээр сарын 24-ний өдөр монголчууд түүхэндээ анх удаа “Улсыг Аюулаас хамгаалах газар” нэртэйгээр орчин цагийн даатгалын байгууллагын үндэс суурийг тавьсан. Энэ нь тухайн цагийн хүнд бэрхийг үл хайхран ирээдүйгээ өөдрөгөөр харах монгол түмний чин хүслийн тод илэрхийлэл байсан юм.

Манай улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжих шилжилтийн үеийг даван туулах, бүтээн байгуулалтыг цогцлооход ард иргэд, бизнесийн байгууллагуудын хэрэгцээ, шаардлагыг хамгийн түрүүнд соргоогоор мэдэрсэн нь даатгалын салбар юм.

Манай компани үүсгэн байгуулагдсан цагаасаа л улс орны хөгжлийн хөдөлгөгч хүч болсон ард иргэдийнхээ амьдралын баталгааг хангах, бизнесийн байгууллагуудыг учирч болох эрсдэлээс хамгаалахад чиглэсэн нийгмийн хамгааллын чиг үүргээ нэр төртэй биелүүлж ирсэн.

Бид Монгол Улсад арилжааны даатгалын тогтолцоог бий болгох, даатгалын салбарын мэргэшсэн мэргэжилтнүүдийг бэлтгэн гаргах, салбарын хөгжлийг олон улсын түвшинд хүргэх, улс орны бүтээн байгуулалт өөрчлөлт шинэчлэлтэд дэмжлэг үзүүлэх зэрэг олон төлөвлөсөн ажлын гараагаа эрч хүчтэйгээр эхлүүлж, байр сууриа бататгахаар түүчээлэн тэмүүлж байна.

-Эрсдэлийг даван туулахад даатгалын үүрэг маш чухал. Монголчууд бид үнэ цэнтэй бүхнээ даатгуулах хандлагад хэрхэн суралцах ёстой вэ? Иргэдийн даатгалын боловсролыг нэмэгдүүлэхийн тулд юу хийх ёстой вэ?

-Даатгал нь эрсдэлийг удирдах, бууруулах үндсэн хэрэгсэл юм. Иргэдийн даатгалын боловсролыг нэмэгдүүлэхийн тулд юу хийх вэ гэдэг асуултын цаана хувь хүний үүрэг хариуцлага, нийгмийн бүлгүүдийн оролцоо, олон нийтийн боловсрол яригдана. Засгийн газар, ашгийн бус байгууллагууд, даатгалын компаниуд даатгалын талаар цогц боловсролын хөтөлбөрүүдийг бий болгохын тулд хамтран ажиллах ёстой. Ялангуяа даатгалын боловсролыг санхүүгийн мэдлэг олгох өргөн хүрээний хөтөлбөрүүдэд тусгах, түүний ач тусыг ойлгуулахад чиглүүлж даатгал нь санхүүгийн тогтвортой байдлын чухал бүрэлдэхүүн хэсэг мөн гэсэн ойлголтыг нэмэгдүүлэх нь чухал.

Даатгалын боловсролыг дээшлүүлэхэд дараах алхмуудыг хийх хэрэгтэй гэж бодож байна. Үүнд, төрөл бүрийн платформууд ашиглах хэрэгтэй. Даатгалын талаарх мэдээллийг түгээхийн тулд воркшоп, семинар, онлайн курс, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл гэх мэт харилцааны янз

► бүрийн сувгийг ашиглах нь илүү өргөн хүрээг хамрахад тусална. Хоёрдугаарт, боловсролын байгууллагуудтай хамтран ажиллах шаардлага бий. Сургууль, коллеж, их дээд сургуулиудтай хамтран даатгалын боловсролыг сургалтын хөтөлбөрт нь оруулж, даатгалын зарчмуудыг бага наснаас нь ойлгох суурийг бий болгоход чиглүүлэх нь зүйтэй. Гуравдугаарт, олон нийтийн үйл ажиллагаанд оролцож, олон нийтэд хүрч ажиллах хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх хэрэгтэй. Орон нутгийн арга хэмжээ, үзэсгэлэн худалдаа, олон нийтийн төвүүд нь даатгалын талаар мэдээлэл өгөх, асуултад хариулах үр дүнтэй газар байж болно. Түүнчлэн, мэдээллийг хялбарчлах ёстой. Даатгалын ойлголтууд нь нарийн төвөгтэй, хэт мэргэжлийн үг хэллэгтэй байвал олон нийтэд даатгалын талаарх ойлголтуудыг өгөхөд саад болох талтай. Мэдээллийг олон нийтэд илүү хүртээмжтэй болгох үүднээс ойлголтыг хялбарчлах, энгийн үг хэллэгийг үйл ажиллагаандаа түлхүү ашиглах нь чухал.

Энэ бүгдээс харахад төр, хувийн хэвшил, боловсролын байгууллагууд хамтран олон талт үйл ажиллагааг хэрэгжүүлснээр даатгалын талаарх олон нийтийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлж, үр дүнд нь хувь хүн болон олон нийтийн санхүүгийн аюулгүй, тогтвортой байдлыг сайжруулахад хувь нэмэр оруулах бүрэн боломжтой юм.

-Өнгөрсөн зуны үерт олон бизнес эрхлэгч, иргэд хохирол амссан. Харин эд хөрөнгөө даатгуулсан иргэд, аж ахуйн нэгж санхүүгийн хохирол багатай, зарим нь 100 хувь хамгаалагдаж чадсан. Энэ явдлаас үүдэн даатгуулагчдын тоо нэмэгдсэн үү?

-Манай даатгуулагч нар багагүй хохирол амссан. Худалдааны төвийн талбайд лангуу түрээслэн худалдаа эрхэлдэг 10 гаруй иргэн болон бизнес эрхлэгчдийн бараанууд үерийн усанд өртсөн, мөн 20 гаруй иргэний автомашин болон үл хөдлөх хөрөнгө нь үерийн усанд живсэн тохиолдол гарлаа.

Манай компани эдгээр даатгуулагч нараас ирсэн нэхэмжлэлийн дагуу хохирлыг 100 хувь барагдуулсан. Бид нийт 90 гаруй сая төгрөгийг нөхөн төлбөрт олгосон байна. Үүнтэй холбоотойгоор бизнес эрхлэгч хуулийн этгээд болон иргэд өөрийн эд хөрөнгө, амь нас, эрүүл мэндээ даатгуулах сонирхол их болж, манай даатгуулагч харилцагч нарын тоо нэмэгдсэн.

-Монгол Улсад даатгагч, даатгуулагчийн

хооронд үүсэх даатгалын харилцааг зохицуулах эрх зүйн орчин хэр бүрдсэн бэ?

-Даатгалын эрх зүйн харилцааг Монгол Улсын Иргэний хууль болон 2004 онд батлагдсан Даатгалын тухай хуулиар зохицуулдаг. Тус хууль батлагдсанаас хойш 16 удаа нэмэлт өөрчлөлт орсон.

Нийгэм цаг үеийн шинэчлэлттэй холбоотойгоор даатгалын салбар өргөжин тэлж, хууль эрх зүйн хувьд шинэчлэл хийх зайлшгүй шаардлага бий болоод байна. Үүнтэй холбоотойгоор “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны бодлогын баримт бичиг, 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д даатгалын салбарын эрх зүйн шинэчлэлтийг үе шаттай хэрэгжүүлэх зорилт тусгагдсан.

Уг зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд Сангийн яам, Санхүүгийн Зохицуулах Хорооны хамтарсан ажлын хэсэг Даатгалын тухай хууль, Даатгалын зуучлалын тухай хууль болон Жолоочийн даатгалын тухай хуулиудын шинэчилсэн найруулгын төслийг боловсруулан, уг хуулийн төсөлд даатгалын байгууллагууд, иргэд олон нийт, холбогдох газруудаас санал авч, саналыг тусган дахин боловсруулах шатанд явж байна.

-Даатгалын компаниуд хэрэглэгчдэд олон төрлийн, хүртээмжтэй бүтээгдэхүүн санал болгож чадаж байгаа юу?

-Даатгалын компаниуд нийт 16 хэлбэрийн 60-70 төрлийн бүтээгдэхүүн борлуулж байна. Харилцагчийн сэтгэл ханамжийн судалгааг харахад дийлэнх даатгуулагч тодорхой хэмжээнд даатгалыг хэрхэн ашиглахаа мэддэг болсон байна.

Харин тус судалгаанаас даатгалын компаниуд юун түрүүнд бүтээгдэхүүнээс илүүтэйгээр үйлчилгээндээ анхаарч ажиллах шаардлагатай гэсэн дүгнэлт гарсан. Тэгэхээр хүртээмжтэй, олон төрлийн бүтээгдэхүүнийг даатгалын компаниуд хүргэж байна гэж үзэж болох юм. Харин эсрэгээрээ үйлчилгээ тал дээр даатгалын компанийн ажилтнууд, төлөөлөгч зуучлагч нар илүү мэргэжлийн түвшинд ажиллахад анхаарах нь зүйтэй байна. ■

Даатгалын талаар цогц боловсролын хөтөлбөрүүдийг бий болгохын тулд хамтран ажиллах ёстой

Байгаль хамгаалал

Ногоон ирээдүйг бүтээгчид


Хүн төрөлхтөн ногоон ирээдүйд тэмүүлж байна. Тийм ч учраас “ногоон” байхын үнэ цэнийг хамгийн түрүүнд ойлгосон улс үндэстэн илүү амар тайван аж төрж, илүү хүчирхэг эдийн засгийг бүтээж байна. Нэг хүнд ногдох ДНБ-ээрээ дэлхийд тэргүүлж буй Скандинавын орнууд үүнийг батлах тод жишээ юм.

Йель болон Колумбын их сургууль Дэлхийн эдийн засгийн форумтай хамтран Байгаль орчны гүйцэтгэлийн индекс (EPI)-ийг боловсруулж, улс орнуудын байгаль орчны талаарх бодлого, шийдэл бодит амьдралд хэрхэн тусгалаа олж буйг үнэлж дүгнэдэг. Энэ индексээр хамгийн хүчирхэг, хамгийн тогтвортой өсөлт үзүүлж буй орнуудын нэг бол Дани юм. Тус улс хүлэмжийн хийн ялгарлыг бууруулж буйгаараа дэлхийд тэргүүлдэг бол хөрш Швед нь хог хаягдлын дахин боловсруулалтаар төгс туршлага хуримтлуулсан. Мөн Дани, Финланд, Нидерланд, Швед зэрэг улс бохир ус цэвэршүүлэх шилдэг технологиороо гайхагддаг.

Харин Азид энэ үзүүлэлтээр Сингапур тэргүүлж буй. Тус улс тогтвортой хөгжлийн бусад үзүүлэлтээр ч манлайлдаг. Мөн Малайз улс ногоон болоод тогтвортой хөгжлийн бодлого, төлөвлөлтөөрөө бусад улсад сайн туршлага болдог. НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд хийсэн “Тогтвортой хөгжлийн зорилгуудыг хөгжлийн төлөвлөлтөд нэгтгэн тусгах нь: Малайз улсын жишээ, туршлага” судалгаанд тус улсын хөгжлийн хөтөлбөр, санхүүжилт оновчтой байдгийн нэг “нууц”-ыг дэлгэжээ. Малайз улс тогтвортой хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг тооцоолохдоо симуляцын аргыг ашигладаг байна. Тухайлбал, ногоон өсөлтийг дэмжих бодлого, арга хэмжээ ДНБ-ий өсөлтөд ямар нөлөө үзүүлэхийг урьдчилан тооцдог аж.

Дэлхийд хөгжлөөрөө тэргүүлэгч улс орнууд ►

“Ногоон” байхын үнэ цэнийг хамгийн түрүүнд ойлгосон улс үндэстэн илүү амар тайван аж төрж, илүү хүчирхэг эдийн засгийг бүтээж байна



Шведийн Badjelannda үндэсний парк дахь Tarradalen хөндий



Хамгийн ногоон орнууд		
	ЕРІ оноо	Нэг хүнд ногдох ДНБ, 2019 он, ам.доллар
1 ДАНИ	82.5	60,170
2 ЛЮКСЕМБУРГ	82.3	114,705
3 ШВЕЙЦАРЬ	81.5	81,994
4 ИХ БРИТАНИ	81.3	42,330
5 ФРАНЦ	80.0	40,494
6 АВСТРИ	79.6	50,138
7 ФИНЛАНД	78.9	48,783
8 ШВЕД	78.7	51,615
9 НОРВЕГ	77.7	75,420
10 ГЕРМАН	77.2	46,445

► илүү ногоон байгаа нь баян тусмаа ногоон байна уу, эсвэл ногоон тусмаа баян уу гэсэн сонирхолтой асуултыг дагуулж байна. Аливаа улс орны байгаль орчны гүйцэтгэлийн индекс нь нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ ногоон байхад хэрхэн нөлөөлж буйг нь харуулж болох ч ногоон болсноор тухайн улс ямар их үнэ цэнийг хүртэж буйг давхар харуулдаг. Хөгжиж буй улс орнууд ногоон хөгжлөөр, ногоон эдийн засгаар тэргүүлэх хэмжээнд хүрэх амаргүй ч өнөөгийн нөхцөл байдалд ахиц гаргахыг хичээх нь хамгаас чухал болоод байгаа билээ.

Тогтвортой хөгжил-Дэлхийн тэмүүлэл

Дэлхийн улс орнууд аж үйлдвэржин эдийн засаг нь хурдацтай өсөж, байгалийн баялгийг хайр гамгүй хэрэглэхийн хэрээр хүрээлэн буй орчны асуудал анхаарах татах болсон юм. Үүнийг хүн төрөлхтөн ухамсарлан ойлгож, дэлхий нийтээрээ тогтвортой хөгжилд тэмүүлээд цөөнгүй жилийг үджээ.

“Тогтвортой хөгжил-2030” хөтөлбөрийг анх 2012 онд Бразилийн Рио-Де-Жанейро хотод болсон НҮБ-ын бага хурлын үеэр санаачилсан түүхтэй. Тогтвортой хөгжлийн зорилго нь 2015 онд хэрэгжиж дууссан “Мянганы хөгжлийн зорилтууд”-ын үргэлжлэл бөгөөд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 70-р чуулганаар тогтвортой хөгжилд тэмүүлэх 17 зорилго, 169 зорилтыг баталснаар 2016 оны нэгдүгээр сарын 1-нээс албан ёсоор дэлхий нийтээр хэрэгжүүлж эхэлсэн.

“Тогтвортой хөгжил-2030” нь нийгэм, эдийн засаг, байгаль орчин гэсэн гурван тулгуурт суурилсан дэлхийн нийтийн урт хугацааны бодлогын баримт бичиг юм. Дэлхийн унаган төрхийг хадгалан нийгэм, эдийн засгийн хөгжилд тэмүүлэх зорилгод улс орнуудыг нэгтгэж буй учраас тогтвортой хөгжлийн зорилтуудыг ногоон хөгжилд түүчээлэх хамгийн том хөтөч гэвэл буруудахгүй.

НҮБ, Дэлхийн банк, олон улсын төрийн бус байгууллагуудын хамтран боловсруулсан “Тогтвортой хөгжил-2021” тайланд дэлхий дахин тогтвортой хөгжилд хэрхэн тэмүүлж буйг танилцуулжээ. Тус судалгаан дахь тогтвортой хөгжлийн зорилтын индексийг авч үзвэл мөн л Финланд, Швед, Дани, Герман улсууд эхэнд бичигджээ. Жагсаалтыг тэргүүлсэн Финланд 85.9 оноо авсан бол манай улс ►

► 63.8 оноогоор 106 дугаарт эрэмбэлэгдсэн. Тогтвортой хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэх үзүүлэлтээр манай улстай ойролцоо үзүүлэлттэй яваа орнууд нь Ирак, Өмнөд Африк, Бангладеш, Лаос гэх мэт улсууд байна.

Харин дэлхийн хамгийн хүчирхэг эдийн засагтай АНУ 76 оноогоор 32-т эрэмбэлэгдсэн бол Хятад улс 72.1 оноогоор 57-д оржээ. Мөн социалист систем нуран унахад Монгол Улстай ижил гараанаас хөдөлсөн хэмээн тодотгодог Казахстан улс 59-д, Беларусь улс 78.8 оноогоор 165 орноос 24-т эрэмбэлэгджээ.

Тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэх тал дээр тэргүүлж буй улс орнууд нь Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD) -ын гишүүн орнууд байгаа нь анхаарал татаж байна. Тус байгууллагын гишүүн орнуудын хувьд, Хорватаас бусад нь бүгд эхний 20-д орж байгаа юм. Гэвч эдгээр улс ч тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхдээ сорилттой тулгардаг, дор хаяж нэг сорилт нь “улаан” оноотой байгааг тайланд дурджээ.

Өндөр орлоготой орнууд нь тогтвортой хэрэглээ, үйлдвэрлэл болон биологийн төрөл зүйл, амьтан ургамлыг хамгаалах чиглэлд хангалттай ахиц дэвшил гаргахгүй байгаа аж. Харин бага орлоготой орнууд нь нэн ядуурлыг арилгах, дэд бүтцийн хүртээмжийг сайжруулахад ихээхэн бэрхшээлтэй тулгарч байна. Тогтвортой хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэхэд манай улсад ч мөн ийм сорилт тулгарч буй. Ядуурлыг бууруулах, уян хатан дэд бүтэц бий болгох зорилтын хэрэгжилт 50 хувьтай байгаа бол үйлдвэрлэлийн бүтцийг бүрдүүлэх зорилт ердөө 15.3 хувьтай байна.

Түүнчлэн хүрээлэн буй орчинтой холбоотой зорилтууд хангалтгүй хэрэгжиж байгааг Үндэсний статистикийн хорооны мэдээлэлд дурджээ. Дэлхийн экосистемийг хамгаалах, нөхөн сэргээх, ойг тогтвортой ашиглах, цөлжилттэй тэмцэх, хөрсний доройтлыг сэргээх, биологийн олон янз байдлыг хамгаалах, цаг уурын өөрчлөлттэй тэмцэх зорилтууд ердөө 35-38 хувийн биелэлттэй байна. Гэтэл Тогтвортой хөгжлийн зорилтыг хэрэгжүүлж дуусах хугацаа бараг талдаа ороод байгааг мартаж болохгүй. Хэрэв манай улс тууштай арга хэмжээ авахгүй бол үлдэж буй найман жилийн хугацаанд дэлхий нийтийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлж чадахгүй. Тиймээс Монгол Улс олон улсын туршлагаас суралцаж, шийдтэй алхам хийх цаг нэгэнт иржээ. ■

Тогтвортой хөгжлийн зорилтын индекс

Улс	Эрэмбэ	Оноо
ФИНЛАНД		
	1	85.9
ИХ БРИТАНИ		
	17	80
БЕЛАРУСЬ		
	24	78.8
БНСУ		
	28	78.6
АНУ		
	32	76
ОХУ		
	46	73.8
ВЬЕТНАМ		
	51	72.8
БНХАУ		
	57	72.1
КАЗАКСТАН		
	59	71.6
МОНГОЛ УЛС		
	106	63.8

Ногоон бизнес

Асуудлын бус шийдлийн нэг хэсэг нь бизнес

Тогтвортой хөгжил нь бизнесийн ертөнцийн хувьд улам бүр чухал асуудал болж байна. Уур амьсгалын өөрчлөлт хүмүүний төдийгүй дэлхий дээрх бүх амьтан, ургамлын төрөл зүйлд нөлөөлсөн хэвээр. Ийм нөхцөлд бизнесийн эзэн, удирдагч, менежерүүдийн хувьд тогтвортой хөгжилд чиглэсэн бизнесийн арга барилуудыг ашиглах зайлшгүй шаардлагатай болж байгаа юм.

Үйлдвэрлэлийн бүхий л салбар нь газар, байгалийн нөөц, малтмал түлшнээс нэн хамааралтай, ихэнх тохиолдолд тасралтгүй үйлдвэрлэл болоод хэрэглээ нь уур амьсгалын өөрчлөлтөд маш их сөрөг нөлөө үзүүлэх болсон.

Тогтвортой хөгжилд чиглэсэн бизнес гэж хүрээлэн буй орчинд сөрөг нөлөө үзүүлдэггүй бизнесийн үйл ажиллагааг хэлдэг. Ийм бизнес нь зөвхөн ашгийг бус нийгэм, хүрээлэн буй орчинд үзүүлж буй нөлөөндөө онцгой ач холбогдол өгдөг. Ногоон бизнес нь үйл ажиллагаа явуулж буй систем, бүтцийнхээ сайн сайханд хувь нэмрээ оруулж байдаг учраас тогтвортой байдаг, улмаар өсөн дэвшиж, хөгжих орчноо бүрдүүлж байдаг юм.

Яагаад тогтвортой хөгжил чухал вэ

Тогтвортой хөгжлийг чухалчлах нь бизнесүүдэд яагаад нэн чухал вэ гэдгийг илтгэн харуулах зүйл бол “Номхон далайн хогны их бөөгнөрөл” юм. Шинжлэх ухааны “Environmental Sustainability” сэтгүүлд дурдсанаар Монгол улсын газар нутгийн талбайтай дүйцэх хэмжээний хогон арал өдгөө Номхон далайд хөвж байна. Хэрэв хуванцар бүтээгдэхүүнийг ихээр үйлдвэрлэдэг мөн ашигладаг компаниуд үгүйсэн бол ийм арал үүсэхгүй.

Тус сэтгүүлд бичсэнээр бөөнөөр үйлдвэрлэх, бүтээгдэхүүний эрэлтийг нэмэгдүүлэн ашгийн хэмжээг аль болох ихэсгэхийг чухалчлах болсон өнөөгийн бизнес загварын улмаас 2050 он гэхэд



Ногоон бизнес нь үйл ажиллагаа явуулж буй систем, бүтцийнхээ сайн сайханд хувь нэмрээ оруулдаг

хүн төрөлхтөн 27 тэрбум хатуу хог хаягдал үйлдвэрлэх ажээ. Түүнчлэн нүүрстөрөгчийн давхар ислийн ялгарлыг хянахад анхаарал хандуулахгүй бол 2050 оны орчимд дэлхийн агаар хоёр хэмээр дулаарч, үүний улмаас далай тэнгисийн түвшин нэмэгдэх, цаг уурын аюулт үзэгдэл улам ихсэх эрсдэл бий.

Саяхны нэгэн судалгаанаас үзвэл ердөө 100 компани нийт ялгаруулалтын 71 хувийг эзэлж байгаа аж. Тиймээс бизнесүүд асуудлын бус шийдлийн нэг хэсэг болох цаг нь иржээ.

Ногоон бизнесийн сайн нөлөө

Ногоон бизнес нь зөвхөн хүрээлэн буй орчин, нийгэмдээ төдийгүй тухайн бизнест өөрт нь ихээхэн ач холбогдолтой. Тэдгээрийн заримаас дурдъя. ►

► Зардлыг бууруулна: Бизнесээ “ногооруулах” замаар зардлаа хэмнэх боломжтой нь нэгэнт нотлогдсон зүйл. Жишээлбэл, эрчим хүчний хэмнэлттэй гэрэлтүүлэг ашиглах, хэрэглэж буй материал, хөрөнгөө дахин бүтээлчээр хэрэглэх гэх мэт. Мөн нарны эрчим хүчийг ашиглахад гарааны хөрөнгө оруулалт ихээхэн шаардагддаг ч эцэстээ зардал хэмнэдэг ач холбогдолтой. “EnergySage”-ийн судалгаагаар нарны хавтангаар цахилгаанаа шийдсэн оффис эзэмшигч нь сард цахилгааны төлбөрөөс 500 ам.доллар, тухайн хавтангийн ашиглалтын хугацаа дуусах хүртэл 587,377 ам.доллар хэмнэдэг аж. Ийм хавтан худалдаж авсны дараа 5-7 жилийн дотор зардлаа нөхдөг аж. Дүгнэж хэлбэл таны бизнес тогтвортой болох тусам эрчим хүч, эд материалын зардал төдийчинээ бага гарна.

Нэр хүнд сайжирна: Ямар ч бизнес нэр хүндээ эрхэмлэдэг нь бичигдээгүй хууль. Хэрэглэгчид өдгөө тогтвортой хөгжлийг давуу тал гэж үздэг болсон учир ногоон үнэ цэн бүтээдэг компаниудаас худалдан авалт хийх, хөрөнгө оруулах ихээхэн сонирхолтой болсон. Бизнесээ ногооруулснаар танайх зөвхөн мөнгө хийхэд л анхаардаггүй гэдгээ хэрэглэгч нартаа харуулна. Чухам үүнийгээ бизнесээ сурталчлах, брэндээ хөгжүүлэхэд бахархалтайаа ашиглаж болно.

Энэ тал дээр Данийн тоглоомын “Lego” компанийг жишээ болгон дурдах нь зүйтэй. Тус компани бүх бүтээгдэхүүнийхээ түүхий эдийг ургамлаас гаргаж авна гэж мэдэгдсэн бөгөөд 2030 он гэхэд гол бүтээгдэхүүнүүд болон сав баглаа боодлоо навч, чихрийн нишингээр хийхээр зорьж байна. Үүний үр дүнд компанийн нэр хүнд, борлуулалт үлэмж өссөн.

Өрсөлдөөнд давуу талтай болно: Стратегидаа тогтвортой байдлыг суулгаж өгсөн S&P 500 индекст бүртгэлтэй компаниуд нь бусдаасаа илүү орлоготой ажилладаг. Тэд уур амьсгалын өөрчлөлтөд сайн бэлтгэлтэй байгаа нь тодорхой учраас хөрөнгө оруулалтын өгөөж нь 18 хувиар илүү байдаг аж. “Бид 30 том корпорацын тогтвортой хөгжлийн талаарх санаачилгыг сүүлийн жилүүдэд судаллаа. Бидний судалгаанаас үзвэл тогтвортой байдал нь орлого, ашгийн хэмжээг ихээхэн нэмэгдүүлдэг байгууллагын болоод технологийн инновацын эх код юм” гэж Harvard Business Review-ийн судлаачид онцолжээ.

**Бизнесээ
ногооруулснаар
танайх зөвхөн
мөнгө хийхэд л
анхаардаггүй
гэдгээ хэрэглэгч
нартаа
харуулна**

Бизнесээ хэрхэн ногооруулах вэ

Бизнесээ илүү тогтвортой, ногоон болох нь эхэндээ хэцүү мэт санагдах боловч ийм сорилтыг даван туулахын үнэ цэн, өгөөж нь өндөр байдаг. Амжилттай энтрепренер, эзэд, манлайлагчид нь асуудлыг боломж болгон харахдаа гарамгай хүмүүс байдаг. Зөвхөн тэднээс гадна тухайн компанийн ажилтнууд ч компаниа “ногоон” болгоход ихээхэн хувь нэмэр оруулах боломжтой.

Тухайлбал, ихээхэн ач холбогдолтой боловч нүдэнд үл анзаарагдам үйлдэл бол хог хаягдлаа дахин ашиглах юм. Үүний үр дүнд газарт булах, шатаах зууханд очих хог хаягдлын хэмжээ буурахаас гадна жил бүр 757 мянган шинэ ажлын байрыг бий болгодог сайн талтай. Харин албан газар, компаниуд хог хаягдлыг ангилан ялгах орчин нөхцөл бүрдүүлэх, хогийн савыг хангалттай тоогоор байлгах зэрэг наад захын алхмыг авах нь чухал юм.

Хүмүүсийн өдөр тутамдаа хэрэгжүүлэх боломжтой өөр нэг “ногоон алхам” бол хувийн тээврийн хэрэгсэл бус нийтийн тээврээр илүүтэй зорчих явдал. Дэлхий даяар автомашинтай хүмүүс өдөр бүр 2.9 тэрбум литр бензинийг түгжрэлд үр ашиггүй шатааж, нэг хүний бүтээмж жилд 710 долларын алдагдал хүлээдэг тооцоо бий. АНУ-д гэхэд тээврийн салбар, тэр дундаа ажил-гэрийн хооронд зорчих явдал нь тус улсын хүлэмжийн хийн ялгарлын хамгийн том эх үүсвэр болжээ. Ажилчдын автобус ашиглах, ажилтнуудынхаа явган алхах, дугуй, скүүтер, цахилгаан дугуй унах дадлыг дэмжих, машинаа хуваалцах үйлчилгээ зэрэг нь компаниудын зүгээс байгаль орчноо хамгаалах, нүүрсхүчлийн хийн ялгарлыг бууруулахад оруулах энгийн атлаа хүчтэй нөлөөллүүд болох юм. Түүнчлэн цар тахлаас шалтгаалан ажилтнууд зайнаас болон гэрээсээ ажиллах болсон нь ногоон хөгжилд оруулж буй бас нэгэн хувь нэмэр гэж тооцогдох болсон. Хүмүүс зайнаас ажиллах нь хүрээлэн буй орчинд мод шинээр тарихтай адилхан нөлөө үзүүлдгийг “Global Workplace Analytics”-ийн судалгаа харуулдаг.

Бизнесүүдийн хувьд дээр дурдсан үл ажиглагдам боловч өдөр тутамдаа хэрэгжүүлж болох өөрчлөлтүүд нь органик хүнс, сэргээгдэх эрчим хүчний бүтээгдэхүүн, ухаалаг барилга зэрэг томоохон инновац, бүтээн байгуулалтуудтай дүйцэх өөрчлөлтийг авчрах боломжтой юм. ■

Хөрөнгө оруулалт

Монгол Улсад үргэлжлүүлэн хөрөнгө оруулахыг урьж байна



Хуулийн болон эдийн засгийн баталгааг олон улсын сайн туршлагад нийцүүлэн сайжруулсан

Гадаадын шууд хөрөнгө оруулалт (ГШХО) нь ажлын байрыг шинээр бий болгож, эдийн засгийг тэлэх өндөр ач холбогдолтой. Тиймээс Монгол Улс хөрөнгө оруулалт татах, хамгаалах механизмыг бүрдүүлж, 2024 онд ГШХО-ыг дөрвөн тэрбум ам.долларт хүргэхээр төлөвлөж байна. "Орчин үеийн дэвшилтэт технологийг ашиглан агаарын геофизикийн хайгуулын цогц судалгааны ажлыг эхлүүлж, хайгуул хийх талбайг 20 хувьд хүргэж, уул уурхайн салбар дахь хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд ихээхэн хүчин чармайлт гарган ажиллана" хэмээн Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар хэлсэн.

Улс болон гадаад улсын иргэд хооронд хөрөнгө оруулалтын маргааныг шийдвэрлэх тухай 1965 оны "Вашингтоны конвенц" (ICSID), НҮБ-ын "Комиссын арбитрын дүрэм" (UNCITRAL), "Эрчим хүчний харт" зэрэг олон талт гэрээнд нэгдэн орсон. Мөн 43 улстай Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцах хамгаалах хэлэлцээр, 26 улстай Давхар татварын гэрээ байгуулаад байна.

Эдгээр хоёр болон олон талт гэрээний дагуу

хөрөнгө оруулалтын хамгаалалтын үндсэн шударга байдал, эрх тэгш хандах, үл ялгаварлах, хөрөнгийг хууль бусаар хураан авахгүй байх зэрэг баталгааг хангах үүрэг Засгийн газар хүлээсэн байдаг. Үүргээ зөрчсөн тохиолдолд хөрөнгө оруулагчаас Засгийн газрын эсрэг хөрөнгө оруулалтын маргааны нэхэмжлэл гаргах эрхтэй.

Гадаад худалдааны таатай нөхцөл бүрдүүлж, экспортын зах зээлийн боломжийг тэлэх зорилгын хүрээнд Монгол Улс Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээрт нэгдэн орсноор БНСУ, БНЭУ, БНХАУ, Шри Ланка, Бангладеш, Лаос руу ойролцоогоор 11 мянган төрлийн бараа бүтээгдэхүүнийг экспортлох боломж бүрдэж байгаа юм. Мөн Европын холбооны Хөнгөлөлтийн Ерөнхий Систем GSP+ статустай болсноор Европын Холбооны гишүүн орнууд руу 7200 төрлийн бараа бүтээгдэхүүнийг, зөвхөн Монголд хөрөнгө оруулахаас гадна түүхий эдийн нөөцийг нь ашиглан боловсруулж, үйлдвэрлээд, буцаагаад экспортлох боломжтой.

Засгийн газраас хөрөнгө оруулалт, бизнесийн орчныг сайжруулах хүрээнд хууль эрх зүйн орчныг ►

▶ боловсронгуй болгох, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах, институцийн тогтолцоог сайжруулах, төрийн үйл ажиллагааг цахимжуулж, хялбаршуулах зэргээр бүхий л хүчин чармайлт гарган гадны хөрөнгө оруулагчдыг татахаар ажиллаж байна.

Гадаадын хөрөнгө оруулалт татах цогц арга хэмжээний хүрээнд энэ оны хоёрдугаар сард Хөрөнгө оруулалт, худалдааны агентлаг шинээр байгуулах Засгийн газрын тогтоол гарсан. Тус агентлаг нь дан ганц уул уурхайгаас гадна хөдөө аж ахуй, мэдээлэл технологи, аялал жуулчлал, эрчим хүчний салбаруудад хөрөнгө оруулахад нь хөрөнгө оруулагчдад дэмжлэг, үйлчилгээ үзүүлнэ.

Тус агентлаг нь хөрөнгө оруулалтын орчин, хөрөнгө оруулагчдын итгэлийг сайжруулахад нэн тэргүүнд анхаарч, гадаадын хөрөнгө оруулах боломжуудыг нэмэгдүүлэх чиглэлээр ажиллах бөгөөд долоодугаар сарын 2-ноос үйл ажиллагаагаа эхлүүлнэ.

Манай улс эдийн засгаа төрөлжүүлэхийн тулд аялал жуулчлал, хөдөө аж ахуй зэрэг түүхий эдийн нөөц ихтэй салбартаа гадаадын хөрөнгө оруулалт татах ихээхэн сонирхолтой. Тухайлбал, хөдөө аж ахуйн болон Хөшигийн хөндий зэрэг чөлөөт бүсүүдийг хөрөнгө оруулалтаар үйл ажиллагааг нь идэвхжүүлж эдийн засгийн эргэлтийг нь түргэсгэх боломж бий. Чөлөөт бүсүүдэд худалдаа, экспор, үзвэр, үйлчилгээ, логистик зэрэг үйлчилгээ эрхлэх боломжтой.

Чөлөөт бүсийн тухай хуулиар гааль, хөдөлмөр эрхлэлт, татварын тусгай дэглэмтэй, зөвхөн тухайн бүсэд үйлчлэх давуу эрх бий. Засгийн газраас сүүлийн хоёр жилд хил, боомтын хүчин чадлыг нэмэгдүүлэхэд анхаарсан. Удахгүй Ханги-Мандал, Гашуунсухайт-Ганцмод боомтыг холбогдох экспортын хүчин чадал нэмэгдэж илүү хямд өртгөөр, илүү их бараа бүтээгдэхүүн тээвэрлэх боломж бүрдэнэ. Бүх аймгийг хатуу хучилттай автозамаар холбосон гэх мэтчилэн суурь дэд бүтцээ бүрдүүлээд байна.


Монгол Улсын баруун өмнөд, өмнөд бүс нутаг нь сэргээгдэх эрчим хүчний арвин нөөцтэй бол аж үйлдвэрийн чиглэлээр ган, зэс хайлуулах, арьс шир, газрын тосны үйлдвэрийн төслүүдийг хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Мөн түргэн хоолны газар, жижиг дэлгүүр гэх мэт франчайз бизнесүүд хүлээлтээс давж ажиллаж байгаа тул

Гадаадын хөрөнгө оруулалт татах замаас монголчууд буцах эрхгүй

амжилттай яваа олон улсын бизнес загварыг Монголын үйлчилгээний салбарт нэвтрүүлэх боломжтой гэдгийг хөрөнгө оруулагчдад бодитоор харуулж буй. Монголын ноолуур, хөдөө аж ахуйн салбар ч итгэл найдвар төрүүлэхүйц гэдгийг онцлох нь зүйтэй.

Манай улс анх 1993 онд Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуультай болж, 2013 онд шинэчлэн найруулж, баталсан. Уг хуулиар хөрөнгө оруулагчид үзүүлэх дэмжлэгийг татварын ба татварын бус хэмээн ангилж, хөрөнгө оруулагчийн татварын орчныг тогтвортой байлгах баталгааг төр гаргаж, уул уурхайн бус хөрөнгө оруулалтыг ▶

Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын ГШХО-ын урсгал, шилдэг 5 эдийн засагтай орон



► дэмжсэн заалт оруулсан зэрэг сайжруулалт хийсэн.

Харин энэ удаа Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”, “Шинэ сэргэлтийн бодлого”, Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд туссан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээнд Эдийн засаг, хөгжлийн яамнаас Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулан УИХ-д зургаадугаар сард өргөн мэдүүлсэн.

Үүнээс өмнө 65 хоногийн хугацаанд хуулийн төслийг монгол, англи хэлээр цахим хуудсанд байршуулж, олон нийтээс санал авсан. Мөн олон улсын байгууллага, хөгжлийн түнш, Элчин сайдын яамд, мэргэжлийн холбоод, бизнесийн зөвлөл, танхимууд, төрийн байгууллага зэрэг гадаад, дотоодын 120 гаруй байгууллагын 250 орчим төлөөллийг оролцуулан хуулийн төслийн нээлттэй хэлэлцүүлгийг хоёр удаа, хөрөнгө оруулагч, мэргэжлийн холбоодын төлөөлүүдтэй 10 гаруй цуврал уулзалтыг зохион байгуулж олон нийтийн оролцоог хангаж ажилласан юм.

Хөрөнгө оруулагчдын хамгийн их айж, болгоомжилдог өөр нэг зүйл бол маргаан шийдвэрлэх процесс. Хуулийн төсөлд ирүүлсэн саналуудын дунд хөрөнгө оруулагчийн баталгаа, гомдол, маргаантай холбоотой зарчмын саналууд болон дагалдах хуулиудаар зохицуулах шаардлагатай саналууд дийлэнх хувийг эзэлжээ. Мөн татварын болон татварын бус урамшуулал, хөрөнгө оруулагч болон төрийн байгууллагуудын эрх, үүргийг тодорхой болгох санал ирүүлсэн.

Монгол Улс хууль, эрх зүйн зохицуулалтын түвшинд гадаадын шууд хөрөнгө оруулалтад нээлттэй улс боловч бусад жишиг оронтой харьцуулахад хөрөнгө оруулалт харьцангуй бага хэвээр байна. Гадаадын хөрөнгө оруулалт татахад хөрөнгө оруулалтын таатай эрх зүйн орчин, тогтвортой байдал, хуулийн хэрэгжилтийг хангах, татварын болон татварын бус урамшуулал зэрэг нь нэн чухал юм. Тиймээс энэ удаа Хөрөнгө оруулалтын тухай хуулиа илүү чамбайруулж өмнөх алдаа дутагдалтай зүйл, заалтыг засаж залруулах, гадаадын болон дотоодын хөрөнгө оруулагчид, аж ахуйн нэгж, олон улсын байгууллагаас ирсэн саналуудыг тусгахаар зорьж байна. Энэ хүрээнд хөрөнгө оруулалтын баталгааг сайжруулах, хөрөнгө оруулагчдад үзүүлэх дэмжлэг, төрийн үйлчилгээг сайжруулж, хялбаршуулахыг зорьж доорх 10 зарчмын асуудлыг хуульд шинээр тусган

Хөрөнгө оруулалт, худалдааны агентлаг нь хөрөнгө оруулагчдын итгэлийг сайжруулахад нэн тэргүүнд анхаарна


боловсруулжээ.

1. Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг хориглосон, хязгаарласан зарим зохицуулалтыг арилгав.
2. Хуулийн болон эдийн засгийн баталгааг олон улсын сайн туршилагад нийцүүлэн сайжруулсан.
3. Хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах зөвлөл буюу гомдол шийдвэрлэх тогтолцоог бүрдүүлж, гомдлыг шийдвэрлэх асуудлыг нарийвчлан тусгасан.
4. Хөрөнгө оруулалтын маргааныг олон улсын арбитрын журмаар шийдвэрлүүлэх эрхийг баталгаажуулна.
5. Хөрөнгө оруулалтыг хамгаалах, дэмжих үүргийг төрийн бүх байгууллагын чиг үүрэг болгон тодорхойлж тусгасан.
6. Татварын ялгамжтай болон ойлгомжгүй байдлыг арилгах зорилгоор татварын урамшууллын асуудлыг татварын хуулиар зохицуулах, суутган татварын хувь хэмжээг ижил тэгш болгох өөрчлөлт оруулсан.
7. Төрөөс хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын давхардлыг арилгах зохицуулалтыг оруулсан.
8. Виз, оршин суух зөвшөөрөл авах процессыг хялбарцуулж, хөрөнгө оруулагчид давхар ачаалал үүсгэх зохицуулалтыг бууруулсан.
9. Тогтворжуулах гэрчилгээ олгох шалгуурыг хялбарцуулж, цахимаар олгох нөхцөлийг бүрдүүлсэн.
10. Газар ашиглах харилцаатай холбоотой хуулийн хийдэлтэй зохицуулалтыг Газрын тухай хуультай нийцүүлэн шийдвэрлэсэн.

Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсанаар эдийн засгийн өсөлт, ажлын байрыг нэмэгдүүлэх, Монгол Улсын өрсөлдөх чадварыг сайжруулах зэрэг олон эерэг нөлөө үзүүлэх юм. Уг хуульд орох хамгийн гол өөрчлөлтийн нэг нь хөрөнгө оруулагчдыг гадаад, дотоодоор нь ялгаварлан авч үздэг заалтуудыг өөрчлөх юм. Тодруулбал, уг хуулийн төсөлд гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдийн хөрөнгө оруулалтын хэмжээ болох 100 мянган ам.долларын босгыг арилгах юм. Одоогоор энэ босгыг дэлхийн 200 гаруй орноос 24 орон л хөрөнгө оруулагчдад тавьдаг.

Мөн гадаадын хөрөнгө оруулагч тус бүрийн оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ гэх заалтыг ►

► Олон нийтээс ирсэн гол саналууд



► хасах, дагалдах хуулийн өөрчлөлтөөр бусад салбарын хуульд байгаа хөрөнгө оруулалтыг хориглосон хязгаарлалтыг арилгах, гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдийн улсын тэмдэгтийн хураамжийн хэмжээг 350 мянган төгрөг буюу 100 ам.доллар болгох аж. Мөн гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийг бүртгүүлэх үйл ажиллагааг хялбаршуулна. Тодруулбал, хоёр өдрийн дотор аж ахуйн нэгж бүртгэх ажиллагааг шийдэх юм.

Хуулийн төсөл нь үндсэн долоон бүлэг, 33 зүйлээс бүрдэх бөгөөд дагалдаж Хууль хүчингүй болсонд тооцох тухай, “Хуулийн хэрэгжилтийг хангуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл болон холбогдох бусад 18 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хамтад нь боловсруулжээ.

Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар “Монгол Улсад бизнес хийхээр орж ирсэн хөрөнгө оруулагч зургаа, цаашлаад 16 жил шүүхээр явсан тохиолдол гарсан. Бараг Гиннесийн номд бичигдэхээр үйл явдал. Тиймээс хөрөнгө оруулагчтай холбоотой маргааныг шийдвэрлэх зөвлөл байгуулахаар хуулийн төсөлд тусгасан. Хөрөнгө оруулагч хүсвэл Арбитр болон шүүхээр асуудлаа шийдүүлэх боломж нээлттэй” гэв. Мөн тэрбээр “Монгол Улс гадаадын хөрөнгө оруулагчдыг татаж, хувийн хэвшлийг дэмжихгүй л бол цаашид бидэнд сонголт байхгүй гэдгийг өнгөрсөн хугацааны алдаа, оноо харууллаа. Тийм учраас гадаадын хөрөнгө оруулалт татах замаас монголчууд буцах эрхгүй. Хөрөнгө оруулалт татаж байж Монгол Улс богинохон хугацаанд хөгжих боломжтой” хэмээн мэдэгдсэн.

“Монгол Улсад бизнес хийхээр орж ирсэн хөрөнгө оруулагч зургаа, цаашлаад 16 жил шүүхээр явсан тохиолдол гарсан.



Эх сурвалж: ЭЗХЯ

Монгол Улс ийн гадаадын хөрөнгө оруулагчдад илүү нээлттэй, хамтын ажиллагаагаа шинэ түвшинд гаргахаар хичээж буй. Бизнесийн орчноо сайжруулж, Хөрөнгө оруулалтын тухай хуулиа илүү чамбайруулан баталж, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдад эрх тэгш хандахаа амлаж тууштай ажиллаж байна. Тухайлбал, Монгол Улсын Засгийн газрын бүх яам, агентлаг, салбар нэгжүүд гадаад болон дотоодын хөрөнгө оруулагчидтай хамтран ажиллахад бэлэн гэсэн мэссэжийг илгээж эхэлжээ. Гадаадын хөрөнгө оруулагчдыг Монгол Улсад үргэлжлүүлэн хөрөнгө оруулахыг урьж байна. ■

Сэргээгдэх эрчим хүч

Дараагийн Оюу толгойг хаанаас олж болох вэ

Монгол Улс газрын доорх баялгаараа дэлхийд тэргүүлэгч улсуудын нэгд тооцогддог. Эдийн засагт нь уул уурхайн салбар голлох байр суурь эзэлж, Эрдэнэт, Оюу толгой, Таван толгой зэрэг том уурхай эдийн засаг, нийгмийн гол түшиг тулгуур болсоор байна. Өдгөө дэлхийд дөрөвт эрэмбэлэгдэх зэсийн уурхайтай болсон монголчууд дараагийн Оюу толгойг хаанаас олж болох вэ хэмээн таамаглал дэвшүүлэх нь бий.

Монголын дараагийн том “уурхай” нь газрын доор бус харин газрын дээр байх бүрэн боломжтой. Тэр бол сэргээгдэх эрчим хүчний салбар юм.

Монгол Улс 2,600 гВт-аар хэмжигдэх сэргээгдэх эрчим хүчний нөөцтэй. Азийн хөгжлийн банкны тооцоогоор Монгол Улс салхи, нарны энергийг ашиглан цагт 5,457 тераватт цахилгаан эрчим хүч гаргаж авах бололцоотой аж. Энэ нь БНХАУ-ын 2022 оны нийт цахилгаан эрчим хүч үйлдвэрлэлийн 63 хувьтай тэнцэх үзүүлэлт юм. Түүнчлэн нийт газар нутгийн 40 хувьд сэргээгдэх эрчим хүчний станцууд барих техникийн боломжтой гэсэн үр дүн гарчээ. Хамгийн нөөц сайтай буюу салхины хурд найман м/с-ээс дээш, нарны илч GHI 1700кВт/м² нөөцтэй бүсийн тоонд Говь-Алтай, Баянхонгор, Өвөрхангай, Дундговь, Дорноговь, Өмнөговь аймгийн нутаг орж байна. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын баруун өмнөд, өмнөд бүс нутаг нь сэргээгдэх эрчим хүчний арвин нөөцтэй юм. Улмаар цэвэр эрчим хүч экспортлох салхины 200 гигаватт нөөц, нарны 1200 гигаватт нөөцтэй гэсэн тооцоолол бий.

Сэргээгдэх эрчим хүч бол Монгол Улсын хувьд цоо шинэ салбар биш. 2007 онд Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль батлагдсан бол 2013 онд сэргээгдэх эрчим

хүчний анхны эх үүсвэр "Салхит" салхин цахилгаан станц ашиглалтад орж байв. Түүнээс хойших 10 жилд сэргээгдэх эрчим хүчний хэд хэдэн төсөл, тэр дундаа нар болон салхины 245 МВт-ын хүчин чадалтай есөн станц баригдсан.

Манай улс 2012 онд ногоон хөгжлийг эдийн засгийн хөгжлийн шинэ стратеги гэж зарлаж, "Ногоон хөгжлийн бодлого, Тогтвортой хөгжлийн бодлого-2030", "Алсын хараа 2050" бодлогын бичиг баримтуудыг тус тус баталсан. Эдгээр баримт бичигт нийт эрчим хүчний суурилагдсан хүчин чадалд ►



Цэвэр эрчим хүч экспортлох салхины 200 гигаватт нөөц, нарны 1200 гигаватт нөөцтэй гэсэн тооцоолол бий

► сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувь хэмжээг 2030 он гэхэд 30 хувь хүртэл нэмэгдүүлэхээр тусгасан.

Гэхдээ дээрх зорилтуудыг хэрэгжүүлэхийн тулд сэргээгдэх эрчим хүчний салбарыг хөгжүүлж байна гэж ойлгох нь өрөөсгөл. Том зургаар нь харвал сэргээгдэх эрчим хүчний том төслүүд хэрэгжүүлж, эрчим хүч экспортлогч болох нь Монгол Улсын гол зорилго, том амбиц юм.

Нар, салхины эрчим хүчний нөөцөд их хэмжээний хөрөнгө оруулалт хийж, хөгжүүлснээр 2031 он гэхэд 12 ГВт орчим суурилагдсан хүчин чадалтай сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүдтэй болох боломж бий. Ингэснээр нүүрсний экспортын борлуулалтаас олох орлоготой тэнцүү хэмжээний орлогыг бий болгох бүрэн боломжтой юм.

“Өөрсдийгөө эрчим хүчээр хангаж

чадахгүй байж, эрчим хүч экспортлох нь холын санаа гэдэг. Би харин тэгж боддоггүй. Харин ч алдаж болохгүй алтан боломж” гэж Монгол Улсын зөвлөх инженер П.Товуудорж өгүүлсэн.

Учир нь Монгол Улстай хиллэж буй БНХАУ болон Зүүн Хойд Азийн бүс нутагт дэлхийн топ дөрвөн эдийн засагтай улс байна. Тодруулбал, дэлхийн хүн амын 25, эдийн засгийн 25, эрчим хүчний хэрэглээний 30 хувь энэ бүс нутагт ногддог. Өөрөөр хэлбэл, маш том эрэлт хэрэгцээ Монгол Улстай ойрхон байна.

БНХАУ бол дэлхийн эрчим хүчний номер нэг хэрэглэгч бөгөөд эрчим хүчний хэрэгцээ нь тасралтгүй өсөж байна. Сүүлийн үеийн тооцоогоор жилийн 190 тэрбум киловатт/цаг, 40-50 гигаваатт цахилгаан хэрэглэж байна. Энэ ч үүднээс Азийн Супер сүлжээ, “Тобитек”, “Нэг бүс, нэг зам”, “Эдийн засгийн

**2031 он гэхэд
12 ГВт орчим
суурилагдсан
хүчин
чадалтай
сэргээгдэх
эрчим
хүчний эх
үүсвэрүүдтэй
болох боломж
бий**



Төр, хувийн хэвшил нь хөрөнгө оруулагч талдаа ч, эрчим хүчний системдээ ч харилцан ашигтай хамтран ажиллах хэрэгтэй

► коридор”, “Зүүн хойд Азийн эрчим хүчний нэгдсэн сүлжээ” зэрэг олон улс хоорондын төсөл, хөтөлбөрүүдэд Монгол Улс голлох үүрэгтэй оролцох боломжтой. “Цар тахал, геополитикийн нөхцөл байдлаас хамаарч дээрх төсөл, хөтөлбөрүүд удааширч байна. Гэхдээ удахгүй бүс нутгаараа эрчим хүчний нэгдсэн интеграцид орно. Гагцхүү ямар зарчим, ямар хувилбараар явахыг цаг хугацаа харуулна” гэж Монголын анхны хоёр салхин цахилгаан станцыг бүтээн байгуулсан “Ньюком” группийн Дэд Бүтцийн Асуудал Эрхэлсэн захирал Д.Ганхуяг өгүүлсэн.

Сэргээгдэх эрчим хүчний салбарын хөгжилд садаа мундахгүй бий. Дотоодын зах зээлд үнэ тариф гол бэрхшээл болж байна. Азийн хөгжлийн банкны Зүүн Азийн газрын Дэд бүтцийн тогтвортой хөгжлийн Хэлтсийн захирал Сужата Гупта “Монгол Улсад тулгамдаж буй нэг чухал асуудал бол сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлд үүсдэг хэлбэлзлээс хамаарч эрчим хүчний нийлүүлэлтийг зохицуулах уян хатан горим бий болгох, түүнийг мөрдүүлэх явдал юм” гэж онцолсон.

Харин гадаад орчны тухайд харилцан ашигтай түншлэл, гадаадын хөрөнгө оруулалт дутмаг байгаа нь үнэн юм. Уур амьсгалын өөрчлөлт, дэлхийн дулаарал, нүүрстөрөгчийг ялгарлыг бууруулах хүрээнд олон улсад сэргээгдэх эрчим хүч

рүү чиглэсэн хөрөнгө оруулалт ихээхэн нэмэгдсээр байна. Хөрөнгө оруулалтын энэ урсгалын нэгээхэн хэсгийг Монголд татаж, эрчим хүчний чиглэлд бүс нутгийн хэмжээний тоглогчийн байр сууринд очих далайцтай, амбицтай зорилтыг Монгол Улс тавих ёстой юм. Хөрөнгө оруулалт, санхүүжилтээ татаж, улмаар зөв төсөл рүү чиглүүлээд дорвитой, зоригтой ажиллаж чадвал тэрхүү амбицтай зорилтод хүрэх боломжтой. Монголын цөөнгүй хувийн хэвшил энэ чиглэлээр гадаадын түншүүд, олон улсын санхүүгийн байгууллагуудтай хамтран хэд хэдэн төслийг эхлүүлэхээр ажиллаж байна. Түүнчлэн, “Шинэ сэргэлтийн бодлого”-ын Эрчим хүчний сэргэлтийн хүрээнд 13 арга хэмжээ, 22 хөгжлийн төслийг эхний ээлжинд үе шаттай хэрэгжүүлнэ. “Энэ салбарт маш сайн бодлого төлөвлөлт, зохицуулалт шаардлагатай. Төр, хувийн хэвшил нь хөрөнгө оруулагч талдаа ч, эрчим хүчний системдээ ч харилцан ашигтай хамтран ажиллах хэрэгтэй” гэж ШУТИС-ийн Эрчим хүчний сургуулийн Сургалт, чанарын албаны дарга, доктор Ч.Улам-Оргил өгүүлж байв.

Сэргээгдэх эрчим хүчний салбараа хөгжүүлж, төрөлжүүлснээр Монгол Улс хөгжлийн зам мөрөө тод болгоод зогсохгүй дэлхий дахины тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулах юм. ■





МАНДАЛ
ЛАЙФ

**ХАЙРЫГ НЬ
ОРЛОХГҮЙ Ч**

**ХАЛАМЖИЙГ НЬ
ҮРГЭЛЖЛҮҮЛНЭ**

Амьдралын Даатгалын Компани



www.mandallife.mn

ИЙМ БОЛТОЛ НЬ
БИТГИЙ ХҮЛЭЭ

ЗҮГЭЭР Л ДААТГАЛАА ХИЙЛГЭ

Даатгалаа
утсаараа ердөө
2 минутад
хийлгээрэй.

 1800-1989

 Тэнгэр Даатгал

Нөхөн
төлбөр
олголт

100%